



НЭЭЛТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



Оюуны  
Инноваци  
ЭРХ ЗҮЙН  
ИННОВАЦИ ТББ



ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН  
ТӨЛӨӨ ТББ



ЭРХ ЗҮЙН  
СОЁЛ  
ЭРХ ЗҮЙН СОЁЛ  
ТББ



ХӨГЖЛИЙН  
АКАДЕМИ ТББ

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Эмхэтгэл 1

Улаанбаатар хот  
2018 он

## **ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ**

Эмхэтгэл 1

НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД  
НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ  
ХҮҮХДИЙН ЭРХ, АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛСАН БАЙДАЛ

ГЭМ БУРУУГУЙ НЬ ТОГТООГДОЖ ЦАГААТГАГДСАН ХЭРГҮҮД БА ТҮҮНИЙ  
УЛМААС ХОРИГДСОН ИРГЭДИЙН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН  
ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгаа хийсэн байгууллагууд:

Оюуны инноваци ТББ  
Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ  
Эрх зүйн соёл ТББ  
Хөгжлийн академи ТББ

Холбогдох хаяг:

Нээлттэй Нийгэм Форум  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
Жамьян гүний гудамж - 5/1  
Улаанбаатар 14240  
Монгол Улс  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
И-мэйл: osf@forum.mn

## АГУУЛГА

Өмнөх үг	5
Товчилсон үг	7
<b>НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ</b>	<b>8</b>
Удиртгал	8
1. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн асуудал	11
2. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь	15
3. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт	29
4. Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа	66
5. Дүгнэлт, зөвлөмж	81
<b>ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХҮҮХДИЙН ЭРХ, АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛСАН БАЙДАЛ</b>	<b>87</b>
Удиртгал	87
1. Судалгааны арга зүй, судалгааны түүвэр	88
2. Шүүхийн шийдвэрийн агуулга, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ	92
Нэг. Шүүхийн шийдвэрийн агуулгын шинжилгээ	92
Хоёр. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүн шинжилгээ	104
Дүгнэлт	106

<b>ГЭМ БУРУУТГҮЙ НЬ ТОГТООГДОЖ ЦАГААТГАГДСАН ХЭРГҮҮД БА ТҮҮНИЙ УЛМААС ХОРИГДСОН ИРГЭДИЙН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛБӨР</b>	110
Удиртгал	110
1. Цагдан хорих арга хэмжээ ба олон улсын туршлага	112
2. Шүүхээр цагаатгагдсан иргэдийн цагдан хоригдсоноос үүдсэн хохирол, түүнийг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт	131
3. Дүгнэлт, зөвлөмж	149
<b>ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ</b>	154
Товч дүгнэлт	154
1. Эрүүгийн хуулийн хэрэглээ	156
2. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн хэрэглээ	159
3. 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ	164
4. Ял оноосон байдал	168
5. Шүүхийн тогтоол тодорхой, ойлгомжтой байх шаардлага буюу тогтоолын найруулга, өгүүлбэр, үг зүйн алдааны тухайд	170
6. Хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэрэгтэй холбоотой тусгай дүн шинжилгээ	171
Дүгнэлт	174
Санал, зөвлөмж	178

## ӨМНӨХ ҮГ

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд 2013 оноос эхлэн шүүхийн шийдвэрийг олон нийтэд ил болгосон нь шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангахад чухал алхам болсон юм. Нээлттэй Нийгэм Форум нь нийтэд ил болсон шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж байх нь шүүхийн шийдвэрийн чанарыг дээшлүүлэх, шүүгчийн ажлын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал хөшүүрэг болно гэж үзсэний дүнд шүүхийн шийдвэрийн үндэслэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

2016 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуультай хамтран анхны дүн шинжилгээг хийсэн бол 2017 оноос иргэний нийгмийн байгууллагууд, бие даасан судлаач, хуульч нарын дунд тодорхой төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт шинжилгээ хийх төслийн уралдаан жил бүр зарлан өргөжүүлж байна. 2017 оны 12 сард зарлагдсан эхний төслийн уралдаанд дараах дөрвөн байгууллага өөрийн сонгосон шүүхийн шийдвэрийн төрөлд дүн шинжилгээ хийснийг энэхүү цувралын анхны дугаараар Та бүхэнд толилуулж байна. Үүнд:

- Оюуны Инноваци ТББ - Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх
- Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ - Гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалсан байдал
- Эрх зүйн соёл ТББ - Гэм буруугүй нь тогтоогдож цагаатгагдсан хэргүүд ба түүний улмаас хоригдсон иргэдийн хохирлын нөхөн төлбөр
- Хөгжлийн Академи ТББ - Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ зэрэг орно.

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Эдгээр шинжилгээ нь хууль хэрэглэх ажиллагааны академик болон практик үр нөлөөг дээшлүүлэх, хуулийн сургуулийн оюутнуудад сургалтын хэрэглэгдэхүүн болох, шүүхийн шийдвэрт хөндлөнгийн байр сууринаас мэргэжлийн үнэлгээ өгөх, улмаар шүүгчдийн хууль хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, шүүхэд тавих олон нийтийн хяналтыг дээшлүүлэхэд хувь хувь нэмэр болно гэж найдаж байна. ННФ нь цаашид шүүхийн шийдвэрийг судалгааны эргэлтэд оруулах үүднээс Шүүхийн шийдвэрийн шинжилгээг эмхтгэн цуврал болгон гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд шүүхийн шийдвэрийн шинжилгээний төслийн уралдаант шалгаруулалтад идэвхтэй оролцохыг судлаач хуульчдаас энэ дашрамд хүсэх байна.

Шударга ёсны баталгаа болсон шүүхийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хариуцлагажуулахад бүх хуульчид, иргэдийн оролцоо, шаардлага зайлшгүй хэрэгтэй билээ.

ННФ-ын Гүйцэтгэх Захирал  
П.Эрдэнэжаргал

## ТОВЧИЛСОН ҮГ

БГД	Баянгол дүүрэг
ЗХХША	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЗХШХШТХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ПтХ	Прокурорын тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХШХШТХ	Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

# НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ

*П.Баттулга (Хуульч)*

*Т.Мөнх-Эрдэнэ (Хууль зүйн магистр)*

## Удиртгал

*Судалгаа хийх хэрэгцээ, шаардлага*

Монгол Улсын Үндсэн хуулийн §16.14-т Монгол Улсын иргэн нь «Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй» гэж заан иргэдийн шүүхэд хэрэг, маргаан хэлэлцүүлэх эрхийн эрх зүйн үндсийг тодорхойлсон. Уг заалтаар нийтийн засаглалын эсрэг хүний эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлэх боломжийг Үндсэн хуулийн түвшинд баталгаажуулж өгч байгаагаараа онцгой ач холбогдолтой бөгөөд энэ нь захиргааны хэргийн шүүх эрх мэдлийн хувьд хамгийн чухал эрх зүйн үндэс байна<sup>1</sup>.

Иргэн болон хуулийн этгээд субъектив эрх нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд хандан уул эрхээ хамгаалуулах нь улс орнуудад нээлттэй байдаг<sup>2</sup>. Харин өөрийнх нь эрх зөрчигдөөгүй байхад, гэхдээ нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс нэхэмжлэл гаргах

---

<sup>1</sup> Г.Банзрагч «ХБНГУ-ын захиргааны шүүхийн Үндсэн хуулийн болон энгийн хуулийн эрх зүйн үндсүүд (II хэсэг) «Хууль дээдлэх ёс» сэтгүүл, УБ., 2010 №2(29), 60 дахь тал.

<sup>2</sup> Субъектив эрх гэдэг нь үүрэг бүхий этгээдийн эсрэг хэрэгжүүлэх ба тодорхой этгээдэд олгогдсон (хувь хүн, хуулийн этгээд), тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг ханган хэрэгжүүлэхэд чиглэгддэг хүсэл зоригийн эрх мэдэл юм. Ц.Давхарбаяр «Хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөхгүй» Өмгөөлөгч сэтгүүл. 2005 оны 05 дугаар сар №43. 13 дахь тал.



эрхийг эрх зүйн зохицуулалтын түвшинд нээж баталгаажуулсан байдал улс орнуудад түгээмэл биш.

Улсын Их Хурал (УИХ)-ын 2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан «Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр»-ийн Тав дахь хэсэгт нийтийн эрх ашгийг<sup>3</sup> төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, байгаль хамгаалал, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжихээр тусгасан байна<sup>4</sup>. Үүний хүрээнд Засгийн газраас Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ЗХШХШТХ)-ийн төсөлд нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах зохицуулалтыг оруулан УИХ-д өргөн барьсан.

Улмаар Улсын Их Хурлаас 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр ЗХШХШТХ-ийг баталсан бөгөөд тус хуулийн §18.3-т зааснаар хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд нь тухайн хуульд заасан асуудлаар, харин хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад этгээд нь «нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх», «дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх» гэсэн хоёр шаардлагыг хангасан нөхцөлд хүрээлэн байгаа орчин (1), хүүхдийн эрх (2), нийтийн эрүүл мэнд (3), нийтийн өмч (4) гэсэн дөрвөн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой болсон.

Ийнхүү нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг илүү мэдээлэлтэй, туршлагатай, асуудлыг ул суурьтайгаар харж чадах, асуудалд илүү ойр байдаг тэрхүү хэсэг буюу төрийн бус, мэргэжлийн байгууллагад нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар захиргааны хэргийн шүүхэд хэрэг хэлэлцүүлэх боломжийг нээснээрээ нийтийн ашиг сонирхол хангагдах баталгааг илүү нэмэгдүүлсэн. ЗХШХШТХ

<sup>3</sup> ЗХШХШТХ батлагдахаас өмнө «нийтийн эрх ашиг», «нийтийн ашиг сонирхол» гэх байдлаар өөрөөр бичиж байсан бөгөөд цаашид хуульчлагдсан утгаар нь «нийтийн ашиг сонирхол» гэсэн нэр томъёог хэрэглэж хэвших нь зүйтэй болов уу - Зохиогчид.

<sup>4</sup> <http://legalinfo.mn/law/details/8722?lawid=8722>

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөөд даруй хоёр жил шахам хугацаа өнгөрөөд байгаа бөгөөд цаашид нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн нэхэмжлэлтэй маргааны тоо өсөх хандлагатай байна.

Иймд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, шүүх энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зэргийг судалж, тодорхой санал зөвлөмж гаргах нь онолын болоод практикийн түвшинд ач холбогдолтой гэж үзэн энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн болно.

### *Судалгааны баг*

Энэхүү судалгааны ажлыг «Оюуны-Инноваци» ТББ-ын Гүйцэтгэх захирал П.Баттулга, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн багш Т.Мөнх-Эрдэнэ нар хийж гүйцэтгэсэн бөгөөд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын тэнхимийн багш, доктор Ц.Цогт зөвлөхөөр ажиллалаа. Судалгааг 2017 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 2018 оны 4 дүгээр сарын 16 хүртэл нийт 4 сарын хугацаанд гүйцэтгэлээ. Судалгааны хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах ЗХШХШТХ-ийн зохицуулалтын үзэл санаа, агуулгыг судалж, хууль хэрэгжиж эхэлснээс хойш захиргааны хэргийн шүүхээс энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэж буй практикт дүн шинжилгээ хийн тодорхой санал, зөвлөмжийг боловсруулав.

## 1. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн асуудал

Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах тухай ойлголт нь анх Англи-Саксоны эрх зүйн системтэй улсуудад ХХ зууны дунд үед үүсэж, энэ нь процессын эрх зүйд нөлөөлж, улмаар шүүх тодорхой шийдвэрээрээ эрх зүйг бүтээдэг жаягийн дагуу нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах журам бүхий жишиг тогтсон. Харин эх газрын буюу Ром-Германы эрх зүйн системтэй улсуудад энэ нь хууль тогтоогчоос ихээхэн хамааралтай асуудал буюу хууль тогтоогч нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлээгүй тохиолдолд үл гүйцэлдэнэ<sup>5</sup>.

Нөгөөтэйгүүр, өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй байхад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хэмээн шүүхэд, ялангуяа захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргадаг байх нь онолын хувьд маргаантай асуудал байдаг. Учир нь захиргааны эрх зүйн үүднээс авч үзвэл аливаа захиргааны байгууллагын өөрийнх нь гол зорилт нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн буюу захиргааны үйл ажиллагаа ямагт нийтийн ашиг сонирхолд чиглэсэн байх ёстой<sup>6</sup>. Гэтэл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хангахын төлөө үйл ажиллагаа явуулах ёстой захиргаа маань ийнхүү чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийтийн ашиг сонирхолд харшилсан шийдвэр гаргасан, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд үүнийг хэн таслан зогсоож, нийтийн ашиг сонирхлыг хэрхэн сэргээх вэ? гэдэг асуудал тулгарна<sup>7</sup>. Хэрэв захиргаа чиг үүргээ хуулийн дагуу хэрэгжүүлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шийдвэрээ гаргадаг байсан бол нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах шаардлага үүсэхгүй нь тодорхой.

Нэгэнт бодит байдалд тийм биш байх тул нийтийн ашиг сонирхлыг захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэн хамгаалах талаар

<sup>5</sup> О.Зандраа «Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах асуудал» Захиргааны эрх зүй-4 (Сургалтын гарын авлага), УБ., 2012, 53 дахь тал.

<sup>6</sup> П.Одгэрэл «Захиргааны эрх зүйн ерөнхий анги» УБ., 2008, 28-30 дахь тал.

<sup>7</sup> <http://tsogt.blogmn.net/98378/baigali-orchniig-hamgaalah-asuudald-zahirgaanii-hergiin-shuuhiin-guitsetgeh-uureg>

ярихаас өөр аргагүй. Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй байдал, хэл, соёл, зан заншил, өв уламжлал, шүтлэг бишрэл, үндэсний аюулгүй байдал зэрэг олон асуудал нь сөрөг үр дагавар бүхий шийдвэр, үйл ажиллагаанд өртөх тохиолдолд тэдгээрийг «нийтийн ашиг сонирхол»-ын үүднээс нэхэмжлэн хамгаалах хэрэгцээ шаардлага урган гарна<sup>8</sup>.

Гэхдээ энд, ХБНГУ-ын хуульч Нийс (Niese)-ийн «Хэрэв захиргааны шүүхийн зорилго нь захиргааны үйл ажиллагааны объектив эрхийн хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэх юм бол захиргааны байгууллагаас хууль зөрчин гаргасан акт, шийдвэрүүд нь зөвхөн шүүхийн шийдвэрээр л засагдах боломжтой болно. Энэ байдал нь захиргаа, шүүх хоёрын харилцаа үндсээрээ өөрчлөгдөхөд хүргэнэ. Өөрөөр хэлбэл, захиргааны шүүх нь дээд шатны захиргааны байгууллага болж хувирах юм. Ингэснээр захиргааны шүүхийн зорилго нь хувь этгээдийн субъектив эрхийг хамгаалахад бус, харин захиргааг хууль ёс сахиулахад чиглэгдэх болно»<sup>9</sup> гэж хэлснийг анхаарахгүй өнгөрч болохгүй. Иймээс Захиргааны хэргийн шүүхийн зорилго нь «захиргааг хянах бус» (дээд шатны захиргаа биш) харин захиргааны хууль бус үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтоох явдал юм.

Бусад улс орны туршлага, эрх зүйн зохицуулалтаас үзэхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг үндсэн хуулиараа баталгаажуулсан улс ч байна. Тухайлбал, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн 38-р зүйлийн (d)-д «Нийтийн ашиг сонирхлын төлөө хэн ч» шүүхэд хандах гаргах эрхтэй<sup>10</sup>, Португал Улсын Үндсэн хуулийн 52-р зүйлийн 3-ын «а» болон «б»-д зааснаар иргэн нь нийтийн эрүүл мэнд, хэрэглэгчийн эрх, амьжиргааны түвшин, байгаль орчин, соёлын өв, түүнчлэн төр, автономит бүс болон орон нутгийн өмчийг хамгаалах

<sup>8</sup> О.Зандраа «Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах асуудал» Захиргааны эрх зүй-4 (Сургалтын гарын авлага), УБ., 2012, 53 дахь тал.

<sup>9</sup> Г.Банзрагч «ХБНГУ-ын захиргааны шүүхийн Үндсэн хуулийн болон энгийн хуулийн эрх зүйн үндсүүд (II хэсэг) «Хууль дээдлэх ёс» сэтгүүд, УБ., 2010 №2(29), 60 дахь тал.

<sup>10</sup> <http://www.justice.gov.za/legislation/constitution/saconstitution-web-eng.pdf>

асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй»<sup>11</sup> талаар заажээ. Мөн зарим улс оронд салбарын хуулиар тусгайлан эрх олгох, ингэхдээ нэхэмжлэн хамгаалж болох «нийтийн ашиг сонирхол»-д хамааруулах асуудлуудыг тодорхойлох, нэхэмжлэл гаргах субъектэд тодорхой шалгуур тавих, түүнчлэн дээрх асуудлыг хэрхэн ойлгож хэрэглэж болох талаар Дээд шүүхийн тайлбар гаргах, салбарын яамаас тусгай журам гаргах байдлаар нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах боломжийг бий болгосон байна<sup>12</sup>.

ХБНГУ-ын хувьд нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг манай улс шиг тусгайлан нээж өгөөгүй. Тийнхүү нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээгээгүй үндэслэл нь ХБНГУ-ын Үндсэн хуулийн<sup>13</sup> 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт «Хэн нэгэн өөрийн эрхийг нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагаагаар зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд хандах эрх нээлттэй ...» гэж заасантай холбоотой байна. Тодруулбал, ХБНГУ-ын одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийн дээрх заалтаар объектив эрхийн хяналтыг шүүхээс хэрэгжүүлэхийг зөвшөөрөөгүй, харин зөвхөн субъектив эрхийн хяналтыг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн гэж олонх эрдэмтэн үздэг бөгөөд хэн нэг этгээд бусдын өмнөөс нэхэмжлэл гаргах боломжгүй гэж тайлбарладаг<sup>14</sup>.

Гэхдээ иргэдийн хүчтэй шаардлага, төрийн бус байгууллагуудын идэвхтэй санаачилгаар ХБНГУ-ын хууль тогтоогчид төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой нийгэмлэг, холбоодоос нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс Захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаартай олгосон байна.

<sup>11</sup> [https://www.constituteproject.org/constitution/Portugal\\_2005.pdf](https://www.constituteproject.org/constitution/Portugal_2005.pdf)

<sup>12</sup> Хүний эрх хөгжил төв «Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах эрхийг бий болгох нь» Бодлогын баримт бичиг УБ., 2010.

<sup>13</sup> <https://www.gesetze-im-internet.de/gg/index.html>

<sup>14</sup> Түүхэн талаас нь авч үзвэл, өмнөд ба хойд Германы хоёр систем байсан бөгөөд өмнөдийн систем нь субъектив эрхийн хяналтыг зөвшөөрдөг, харин хойд Германы систем нь объектив эрхийн хяналтыг зөвшөөрдөг байжээ. Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийг өмнөд Германы системийн үзэл баримтлалыг барьж боловсруулсан байдаг. Энэ тухай Friedhelm Hufen, *Verwaltungsprozessrecht*, 7. Auflage, Verlag C.H.Beck, München, 235-236 дахь талаас үзнэ үү.

Тухайлбал, Холбооны байгалийн нөөцийг хамгаалах тухай хуулийн §63-64-ийн дагуу байгалийн нөөцийг хамгаалахтай холбоотой асуудлаар, Холбооны байгаль орчныг хамгаалах асуудлаар гомдол гаргах журмын тухай хуулийн §2-ийн дагуу байгаль орчныг хамгаалах асуудлаар, Холбооны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийн тухай хуулийн §13-15-ын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах асуудлаар, амьтныг хамгаалах асуудлаар 8 муж улсад нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн байна. Харин нийтийн ашиг сонирхлын тухай нэхэмжлэл гаргах зохицуулалт нь тухайн улсын шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд дагаж мөрддөг хуульд тусгагдсан тохиолдол төдийлөн байдаггүй аж<sup>15</sup>.

Манай улсын Үндсэн хуульд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй боловч Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар иргэд өөрт хамааралгүй асуудлаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл (actio popularis) гаргах боломжтой ба энэ нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах агуулгатай байна.

2017 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан ЗХШХШТХ-иар өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбогдолгүйгээр үүсэж явагддаг нийтийн ашиг сонирхлын маргааныг хэт нээлттэй биш, хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрсөн нь захиргааны нийгэмд гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой алхам болсон. Ийнхүү хязгаарлалт хийж өгсөн нь захиргааны байгууллагад нийтийн ашиг сонирхол хийгээд хувийн ашиг сонирхлын хамгаалалтын балансыг барих боломж олгосон. Нөгөө талаас захиргааны хэргийн шүүхийг тодорхой бүлэг, цаашлаад улс төрийн ашиг сонирхлын талбар болгохоос сэргийлэх, мөн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хийсвэр ачаалал бий болгохоос сэргийлсэн утгаараа өнөөдрийн байдлаар оновчтой зохицуулалт гэж үзэж болно.

---

<sup>15</sup> Ц.Цогт «Байгаль орчныг хамгаалахад захиргааны хэргийн гүйцэтгэх үүрэг, оролцоо» <http://legaldata.mn/buteel/pdf?id=141>

## 2. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь

### 2.1. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох онол, арга зүйн үндэс

ЗХШХШтХ-иар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой болсноор Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаанд «нийтийн ашиг сонирхол» гэсэн ойлголтыг судлах, танин мэдэх, түүний агуулга, концепцийг онол, арга зүйн үндэслэлтэй тодорхойлох шаардлага тавигдаж байна.

Нийтийн ашиг сонирхол гэж юу болох, түүний агуулгад юу хамаарах зэрэг асуудал нь дэлхийн улс орнуудын хууль зүйн шинжлэх ухаанд мөнхийн сэдэв байсаар ирсэн гэж үзэж болно. Нийтийн ашиг сонирхол гэх ойлголт нь улс төрийн үзэл баримтлал, төрийн онолын янз бүрийн чиг урсгалуудаас хамаарч тодорхойлогддог гэж барууны хууль зүйн шинжлэх ухааны бүтээлүүдэд дурдсан байдаг бөгөөд нийтийн ашиг сонирхол хэмээх ойлголтын агуулга, мөн чанарыг авч үзэхэд тэргүүлэх байр сууринд тавигддаг онолын гурван концепци<sup>16</sup> байдаг байна. Үүнд:

1. Нийтийн ашиг сонирхлын либерал концепци;
2. Нийтийн ашиг сонирхлын төр төвтэй концепци;
3. Нийтийн ашиг сонирхлын ардчилсан ёсны концепци.

#### *А. Нийтийн ашиг сонирхлын либерал концепци*

Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлдог либерал-утилитар концепци нь Адам Смитын томъёолсон либерализмын суурь ойлголтод тулгуурладаг. Нийтийн сайн сайхан нь «үл үзэгдэх гар»-ын тусламжтайгаар үүсдэг бөгөөд хувийн давуу тал, ашиг тусыг зорилгоо болгосон хувь этгээдүүдийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхлын эх үүсвэр хэмээн үздэг<sup>17</sup>.

Энэхүү үзэл баримтлалыг төрийн онолын түвшинд боловсруулсан хүн бол Фрайхэрт фон Штайн гэж үздэг бөгөөд тэрээр нийтийн асуудлыг бүх иргэдийн асуудал болгохын тулд хувь

<sup>16</sup> Andreas Fisahn., Der Begriff des oeffentlichen Interesses im Fachplanungs- und Naturschutzrecht., Uni Bielefeld., 4 дэх тал.

<sup>17</sup> Мөн тэнд.

этгээдийн ашиг сонирхлыг ашиглах учиртай ба тэдгээрийн «бие даасан үйл ажиллагаа»-г улсын эсхүл үндэстний сайн сайхан болгох ёстой гэж үзэж байсан байна<sup>18</sup>. Тийм ч учраас хувь өмчлөгч ялангуяа, газрын өмчлөгч этгээд нь өөрийн хувийн өмчийн ашиг сонирхлыг нийтийн сайн сайхны төлөө хэрэгжүүлэх үүрэг хүлээж болох ба тэдний (өмчлөгчдийн) бие даасан үйл ажиллагаа нь улсын ашиг сонирхолтой холбогдох, мөн үндэстний нийтийн ашиг сонирхолд ач тустай байх ёстой ажээ<sup>19</sup>. Фрайхэрт фон Штайн «Хувийн өмчлөгчид тийнхүү төрийн (нийтийн захиргааны) үйл хэрэгт оролцсоноор хамтын аж амьдрал, иргэн байхын утга учир тодорч, нийгмийн гишүүдийн хүчин чадлыг үр дүнтэй ашиглаж, эх орныхоо төлөө гэх үзэл, бие даасан байдал, үндэстний нэр төр эргэн сэргэдэг»<sup>20</sup> хэмээн бичжээ.

#### *Б. Нийтийн ашиг сонирхлын төр төвтэй концепци*

Дээр дурдсан либерал-утилитар концепцийн эсрэг нийтийн ашиг сонирхлын төр төвтэй концепци гэж байдаг. Энэхүү концепци нь нийтийн сайн сайхан буюу нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлын эсрэг авч үздэг. Уг концепцийн онолын эх үндсийг Гегель тавьсан ба тэрээр «иргэний нийгэмд янз бүрийн хийгээд өөр хоорондоо эсрэгцсэн «хэрэгцээ шаардлагад чиглэсэн» хувийн ашиг сонирхлууд оршин байдаг» гэж үзжээ<sup>21</sup>. Мөн түүний үзсэнээр нийт гэдэг бол ямар ч утгаараа төр байх бөгөөд философийн үүднээс авч үзвэл энэ нь туйлын ашиг сонирхол юм<sup>22</sup>.

Төр нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлдэг бөгөөд нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос аль ч утгаар авч үзсэн зааглагдана. Төрийн бүхий л институт зарчмын хувьд нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох, мөн төлөөлөх хамгийн эцсийн субъект

<sup>18</sup> Stein, Nassauer Denkschrift, in: Briefe und aml. Schriften, Freiherr vom Stein, Bd. II/2, S. 500 ff.

<sup>19</sup> Schwab, Die «Selbstverwaltungsidee», S. 132.

<sup>20</sup> Stein, Nassauer Denkschrift, in: Briefe und aml. Schriften, Freiherr vom Stein, Bd. II/ 1.S. 394.

<sup>21</sup> Hegel, Grundlinien der Philosophie des Rechts, § 189 ff.

<sup>22</sup> Hegel, Enzyklopedie der philosophischen Wissenschaften § 564 ff.



болдог<sup>23</sup>. Форстхофф үзэхдээ «Төр бол олон нийт юу шаардаж байна түүнийг нь хамгаалагч бөгөөд гүйцэтгэгчийн хувиар хийх оюун санааны болоод улс төрийн эрхтэй. Энэ нь төрийн үндсэн үүрэг» гэжээ<sup>24</sup>.

Форстхоффын дээрх дүгнэлтээс үндэслэн авч үзвэл «Нийтийн сайн сайхан буюу нийтийн ашиг сонирхол нь төртэй холбоотой ба энэ нь төрийн зайлшгүй байх урьдчилсан нөхцөл юм»<sup>25</sup>.

### *В. Нийтийн ашиг сонирхлын ардчилсан ёсны концепци*

Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлсон гурав дахь томоохон концепци бол «Ханна Арендтын республиканизм» хэмээн нэрлэгддэг. Харин үүнийг ХБНГУ-ын хувьд нийтийн ашиг сонирхлын ардчилсан-плюралист концепци хэмээн нэрлэдэг байна<sup>26</sup>.

Энэ концепцийн хүрээнд гарсан хоёр «сонгодог» жишээ бий. Үүний нэг нь «1874 оны Өмч хөрөнгө хураан авах тухай Пруссын хууль» юм. Уг хууль нь орчин үеийн захиргааны эрх зүйн чухал институт болсон «төлөвлөлтийн үйл ажиллагаа»-ны үндэс суурь болж өгсөн гэж үздэг. Пруссын үед гарсан дээрх хууль нь өмч хөрөнгө хураан авах материаллаг үндэслэлийг нэг бүрчлэн тодорхойлохоос татгалзсан бөгөөд хувийн өмчийг хураан авах үндэслэл нь зөвхөн нийтийн сайн сайхан (нийтийн ашиг сонирхол) болохыг зөвшөөрсөн байдаг<sup>27</sup>.

Энэ үндэслэл нь тухайн үеийн Пруссын парламентад эсэргүүцэл дагуулсан бөгөөд эсэргүүцсэн гишүүд нь «нийтийн ашиг сонирхол гэх эрх зүйн тодорхойгүй ойлголтод тулгуурлан Засгийн газарт өмч хураан авах эрх хэмжээг олгож болохгүй. Харин үүний оронд тухай бүрт нь өмч хураан авах арга хэмжээний хууль баталж (тодорхой тохиолдлуудыг зааж өгөх байдлаар) шийддэг байх нь зөв» гэсэн санааг хэлж байжээ<sup>28</sup>. Гэвч Пруссын парламентын цөөнхийн

<sup>23</sup> Andreas Fisahn., Der Begriff des oeffentlichen Interesses im Fachplanungs- und Naturschutzrecht., Uni Bielefeld., 5 дахь тал.

<sup>24</sup> Forsthoff, Gemeinwohl, S. 41.

<sup>25</sup> Мөн тэнд.

<sup>26</sup> Andreas Fisahn., Der Begriff des oeffentlichen Interesses im Fachplanungs- und Naturschutzrecht., Uni Bielefeld., 5 дахь тал.

<sup>27</sup> Verhandlungen des Hauses der Abgeordneten 1873/74, S. 128 ff.

<sup>28</sup> Andreas Fisahn., Der Begriff des oeffentlichen Interesses im Fachplanungs- und

санал амжилт олоогүй байна. Түүнчлэн, нэрт эрх зүйн онолч Ханс Кельзен «res publica» болон «эрх зүй» хэмээх ойлголтууд нь ижил агуулгатай гэж үзсэн байдаг ба «res publica» гэдэг нь төр буюу сонгодог утгаараа «нийтийн асуудал» гэж орчуулагдана гэжээ<sup>29</sup>. Тэрээр цааш нь «Төр гэдэг бол хууль тогтоомж. Гэхдээ бүх хууль тогтоомж бол төр биш. Харин төрийн гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагууд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хэм хэмжээг бий болгосон хууль тогтоомж бол төр гэсэн үг» гэжээ<sup>30</sup>. Засгийн газар болон түүний харьяаны аппаратууд жам ёсны дагуу үүссэн эрх, эрх чөлөөг баталгаажуулах ёстой ч энэ нь хуульгүйгээр боломжгүй. Зөвхөн парламентаас баталсан ерөнхий-хийсвэр зохицуулалттай хэм хэмжээ (хууль) л эрхийг баталгаажуулдаг<sup>31</sup>. Тиймээс нийтийн сайн сайхан, нийтийн ашиг сонирхлыг парламентын бүтээсэн ерөнхий-хийсвэр хэм хэмжээ л илэрхийлэн хамгаалдаг байна<sup>32</sup>.

Гэвч төр нь нийтийн ашиг сонирхлыг ямар ч тохиолдолд бүхэлд нь хамгаалж чаддаг уу? гэвэл үгүй юм. Зарим тохиолдолд захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй. Ялангуяа, нийтийн ашиг сонирхол өөр нэг нийтийн ашиг сонирхолтой зөрчилдсөн тохиолдолд алийг нь илүү чухал гэж үзэж хамгаалах шаардлагатай вэ? гэдэгт зөв гаргалгаа хийж чадахгүй байх тохиолдол үүсдэг. Энэ тохиолдолд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээдэд төрөөс гадна нийгмийн янз бүрийн нийгэмлэг (холбоод)-ийг хамруулах байдлаар эрх зүйн зохицуулалт хийж өгөх нь тун оновчтой гэдгийг ардчилсан-плюралист концепци зөвшөөрдөг байна.

Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлсон дээрх онолын концепциудыг агуулгын хувьд дүгнэвэл:

- а) нийтийн ашиг сонирхол нь хувь этгээдүүдийн ашиг сонирхлын нийлбэр бөгөөд хувь этгээдүүдийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхлын эх үүсвэр болохын

---

Naturschutzrecht., Uni Bielefeld., 6 дахь тал.

<sup>29</sup> Мөн тэнд.

<sup>30</sup> Kelsen, Reine Rechtslehre, S. 117.

<sup>31</sup> Kelsen Reine Rechtslehre, S. 113.

<sup>32</sup> Andreas Fisahn., Der Begriff des oeffentlichen Interesses im Fachplanungs- und Naturschutzrecht., Uni Bielefeld., 6 дахь тал

хувьд түүнийг хамгаалснаар нийтийн ашиг сонирхол хамгаалагдана гэх либерал концепци;

- б) нийтийн ашиг сонирхол гэдэг бол төрийн оршин байх зайлшгүй урьдач нөхцөл бөгөөд нийтийн ашиг сонирхлыг зөвхөн төр төлөөлөн илэрхийлж, хамгаална гэх төр төвтэй концепци;
- в) нийтийн ашиг сонирхлыг ардчилсан ёсны зарчмаар сонгогдсон парламент ерөнхий-хийсвэр зохицуулалттай хууль бүтээх замаар тодорхойлж, хамгаалах бөгөөд хэрвээ парламент энэхүү чиг үүргээ хангалттай гүйцэтгэж чадахгүй байгаа бол нийгмийн өөр бусад нийгэмлэгт (холбоодод) нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрхийг нь олгох ёстой гэх ардчилсан-плюралист концепци тус тус байна.

Дээрхээс авч үзвэл, нийтийн ашиг сонирхлын либерал концепци дэлхий нийтийн олонх хүлээн зөвшөөрсөн чиг хандлага биш байна хэмээн дүгнэж болохоор байна. Хувийн өмчийг хураан авахад чиглэгддэг (үндэслэгддэг) нийтийн ашиг сонирхол (нийтийн сайн сайхан)-ыг төлөөлөх асуудал нь төр төвтэй концепцид хамаарч байна. Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээдэд нийгэмлэг буюу холбоодыг хамааруулан тооцож, хуулиар тэдэнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах эрхийг олгож байгаа нь ардчилсан-плюралист концепцийн агуулгад хамаарч байна.

ХБНГУ-ын захиргааны эрх зүйн нэрт эрдэмтэн, доктор Хартмут Маурэр «... Захиргааны үйл ажиллагаа нийтийн ашиг сонирхол дээр суурилсан байх ёстой. «Нийтийн ашиг сонирхол» гэх ойлголт нь бүх тохиолдолд нэг мөр агуулгыг илэрхийлдэггүй бөгөөд тухайн цаг үеийн өөрчлөлтийн нөлөөнд өртөж, улмаар цаг үе бүрт ихэвчлэн маргаантай байдаг. Юуны өмнө олон ургальч үзэл хандлагын хамааралд оршин буй төрийн үед нийтийн ашиг сонирхол гэдэгт юу хамаарах, ашиг сонирхлын зөрчилдөөн дунд нийтийн ашиг сонирхлын эзлэх байр суурь ямар байх вэ? гэдэг нь байнгын асуулт

дагуулж байдаг»<sup>33</sup> хэмээн бичжээ.

Түүнчлэн, ХБНГУ-ын нэр хүндтэй эрх зүйн толь бичигт «Нийтийн ашиг сонирхол гэх ухагдахуун нь а) хуулийн хэлэнд (ялангуяа, захиргааны эрх зүй болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд) ихэвчлэн хэрэглэгддэг ойлголт бөгөөд нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлын эсрэг тодорхойлох буюу нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тухай ойлголт (ХБНГУ-ын Захиргааны шүүхийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2.4 дэх заалтад «нийтийн ашиг сонирхлын үүднээс захиргааны актыг яаралтай гүйцэтгэх» тухай заасан байна); б) нийтийн ашиг сонирхол гэдгийг тодорхойлох урьдчилсан нөхцөлийг тодорхой нэг тохиолдолд хууль тогтоогчоос тогтоосон хуулийн агуулга, зорилгыг бүхэллэг байдлаар тайлбарлах замаар тогтооно; в) нийтийн ашиг сонирхол гэх ухагдахуун нь эрх зүйн тодорхойгүй ойлголт (хуулиар шууд тодорхойлох байдлаар заах боломжгүй ойлголт<sup>34</sup>) бөгөөд үндсэндээ түүний урьдчилсан нөхцөлийг эрх зүйн тодорхой маргаанд шүүхээс шалгах замаар тайлбарлана»<sup>35</sup> хэмээн тэмдэглэжээ.

АНУ-ын нэр хүндтэй эрх зүйн толь бичигт «Нийтийн ашиг сонирхол гэж а) хүлээн зөвшөөрөх байдал болон хамгаалалтыг үндэслэдэг нийтийн сайн сайхан; б) олон нийт бүхэлдээ оролцоотой байдаг зүйл (ялангуяа, төрийн зохицуулалтыг зөвтгөдөг ашиг сонирхол)»<sup>36</sup> гэж тодорхойлжээ.

Дээрх агуулгын хувьд төстэй буюу «төрөөс хүлээн зөвшөөрсөн, эрх зүйн зохицуулалт бүхий нийгмийн ашиг сонирхол бол нийтийн ашиг сонирхол байна гэж үзэж болох юм» гэсэн дүгнэлтийг ОХУ-ын зарим эрдэмтэд өгчээ<sup>37</sup>.

Дээр дурдсан зүйлүүдээс үзвэл «нийтийн ашиг сонирхол» гэх ойлголт нь яг таг буюу нэг томъёолол бүхий ухагдахуун биш

<sup>33</sup> Hartmut Maurer., Allgemeines Verwaltungsrecht., 16. Auflage., Verlag C.H.Beck., 2006., Muenchen., 5 дахь тал

<sup>34</sup> Герман, Австри улсуудад эрх зүйд үүнийг «unbestimmter Rechtsbegriff» гэж нэрлэдэг.

<sup>35</sup> Creifelds Rechtswoerterbuch., 19. Auflage., Verlag C.H.Beck., 2006., Muenchen., 839 дэх тал

<sup>36</sup> Black's Law Dictionary., 7th edition., St. Paul, Minn., 1244 дэх тал.

<sup>37</sup> М.С.Матейкович, В.А.Горбунов. Законные интересы в конституционном праве.-М.: Норма: ИНФРА-М, 2011. С.67-68, 83, 89, 91-92.

бөгөөд юуны өмнө, нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлын эсрэг тодорхойлох буюу нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тухай ойлголт байна. Үүнээс гадна нийтийн ашиг сонирхол гэдэг нь хуулиар шууд тодорхойлон заах боломжгүй ойлголт учраас түүний урьдчилсан нөхцөлийг тодорхой нэг тохиолдолд хууль тогтоогчоос тогтоосон хуулийн агуулга, зорилгыг бүхэллэг байдлаар тайлбарлах замаар шүүхээс шалган тайлбарладаг байна. Мөн «нийтийн ашиг сонирхол», «нийтийн сайн сайхан» хэмээх ойлголтууд нь агуулгын хувьд зарчмын томоохон зөрүүгүй байх ба хэрэглээний түвшинд хувийн өмчийг хураан авах шаардлагатай тохиолдолд түүнийг үндэслэдэг нийтийн ашиг сонирхлыг нийтийн сайн сайхан хэмээн нэрлэдэг байна.

«Нийтийн» хэмээх үгнээс нь улбаалахад тооны олонлог шинжийг агуулах боловч энэ нь ямар ч тохиолдолд зөвхөн тоон хэмжүүрээр илэрхийлэгдэнэ гэсэн үг бас биш гэдгийг зайлшгүй анхаарах учиртай. Жишээ нь, өнөөгийн байдлаар Монгол Улсад архи, тамхины хэрэглээ асар өндөр байгаа гэдэг нь статистикийн тоо баримтаар заавал нотлох шаардлагагүй буюу «нүдний өмнө ил» байна. Тэгвэл архи, тамхи хэрэглэж байгаа хүн нийгэмд олонхыг бүрдүүлж байгаа учраас тэдний хэрэглээг дэмжих нь нийтийн ашиг сонирхол мөн гэвэл үгүй. Учир нь архи, тамхины хэрэглээ бол буруу зуршил болохоос нийтийн ашиг сонирхол биш. Харин хүн бүр эрүүл амьдрах нь нийтийн ашиг сонирхол мөн. Тиймээс архи, тамхи хэрэглэдэг олонхын ч, хэрэглэдэггүй цөөнхийн ч эрүүл амьдрах ашиг сонирхлыг нь хамгаалах зорилгоор УИХ-аас Тамхины хяналтын тухай хууль баталж, тэрхүү хуулиар хувийн эрх зүйн хуулийн этгээдэд (хувийн ашиг сонирхлыг хэрэгжүүлж байгаа этгээдүүдэд) тодорхой үүрэг хүлээлгэдэг.

Мөн гол мөрний эх ундарга, ай сав байрладаг газрыг бохирдуулах үйл ажиллагаа (жишээлбэл, алтны уурхай) явуулж байгаа бөгөөд тэрхүү газарт нь тодорхой оршин суугч суурьшдаггүй, эсхүл Монгол Улсын хүн амын олонх суудаггүй байсан ч тэнд нийтийн ашиг сонирхол яригдана. Өөрөөр хэлбэл, хэдийгээр тэнд шууд өртөх олон нийт байхгүй ч тухайн голын усаар ундаалдаг олон зуун айл өрх, мал, ан амьтан эрүүл байгальд амьдрах эрхтэйгээс

гадна экологийн тэнцвэрт байдал алдагдана. Эдгээр нь нийтийн ашиг сонирхолд хамаарна. Өөрөөр хэлбэл, ашиг сонирхлын нийтийн байх шинж чанар нь агуулгын болон тоон бүрдүүлбэртэй. Агуулгад олон этгээдийн хувьд ач холбогдол бүхий үнэ цэнэтэй байхыг ойлгоно. Жишээлбэл, үндэсний эрүүл мэндийн асуудал нь олон хүн тамхи татахыг хүсэж байгаа эсэхээс үл хамааран хамгаалагддаг. Энэ нь хувь хүний тамхи татах хувийн ашиг сонирхолтой зөрчилдөх боловч амин чухал ашиг сонирхлыг хамгаалах хэрэг юм<sup>38</sup>. Өмнө дурдсантай холбоотойгоор тоон бүрдүүлбэрийг ердийн арифметик тоогоор тооцох боломж байхгүй. Гол нь ганц нэг хүнд хамаатай ашиг сонирхол биш байх нь чухал. Жишээлбэл, БГД-ийн 3 дугаар хорооны 7 дугаар байрны 8 давхрын 25 тоотод амьдрах шийдвэр бол зөвхөн тухайн айл өрхөд хамаатай<sup>39</sup>.

Түүнчлэн, гадаад орнуудын шүүхийн шийдвэрээс судалж үзэхэд, хүн амын ахуй амьдралын суурь хэрэгцээ болсон ус, хий, эрчим хүчний хэрэглээ, хог хаягдал, бохир усны менежмент, боловсрол, соёл, эмнэлгийн үйлчилгээ, оршуулгын газар, усан сан гэх мэт нь ямар ч маргаангүй нийтийн ашиг сонирхолд хамаарах асуудлууд гэсэн тайлбарыг хийсэн байна<sup>40</sup>.

## **2.2. Нийтийн ашиг сонирхол: Монгол Улсын Үндсэн хууль болон зарим хуульд туссан байдал**

А. 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд «нийтийн ашиг сонирхол» гэсэн ойлголт хуульчлагдаагүй бөгөөд харин «ашиг сонирхол»<sup>41</sup> гэсэн ойлголт дараах байдлаар нийт 6 удаа дурдагджээ:

<sup>38</sup> М.С.Матейкович, В.А.Горбунов. Законные интересы в конституционном праве.-М.: Норма: ИНФРА-М, 2011. С.117, 120, 140.

<sup>39</sup> «Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээх нь» сэдэвт бодлогын судалгааны ажил., УБ., 2016., 7 дахь тал

<sup>40</sup> Andreas Fisahn., Der Begriff des oeffentlichen Interesses im Fachplanungs- und Naturschutzrecht., Uni Bielefeld., 12 дахь тал. Түүнчлэн, энэ талаар ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн BVerfG v. 16. Dezember 1986, E, 74, 264., BVerfGE 66, 28/ 258., BVerfGE 74, 264/ 285 f. шийдвэрүүдийг тус тус үзэж болно.

<sup>41</sup> «Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээх нь» сэдэвт бодлогын судалгааны ажил., УБ., 2016., 2 дахь тал

---

§6.4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

§16.10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

§16.11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

§17.2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

§23.1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

§46.2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.

---

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтуудаас үзэхэд «ашиг сонирхол» гэдэг нь «хүн амын эрүүл мэндийн ашиг сонирхол», «байгаль хамгааллын ашиг сонирхол», «үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол», «нийгмийн ашиг сонирхол», «хувь хүний ашиг сонирхол», «гэр бүлийн ашиг сонирхол», «эх нялхсын ашиг сонирхол», «хүүхдийн ашиг сонирхол», «хууль ёсны ашиг сонирхол», «нийт иргэн, улсын ашиг сонирхол», «төрийн ашиг сонирхол» гэсэн олон төрлөөр тодорхойлогджээ. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан «... хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг

сонирхол ...» гэдэг нь агуулгын хувьд нийтийн ашиг сонирхол гэсэн ойлголттой дүйх бөгөөд энэхүү ашиг сонирхол нь өмчлөгчийн туйлын эрх<sup>42</sup> болох өмчлөх эрхээс давуу хүчин чадалтай болохыг илэрхийлж байна.

Б. Энэ хэсэгт Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, урьдчилан сэргийлэх тухай гурван хуулийг иш татан авч үзлээ.

а) Захиргааны ерөнхий хуулийн §5.1-д «*Нийтийн ашиг сонирхлыг* илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно» хэмээн тодорхойлсон бөгөөд тус хуульд захиргааны байгууллага тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахдаа «нийтийн ашиг сонирхол»-ыг үндэслэл болгох дараах 11 тохиолдлыг зохицуулсан байна:

---

§10.4.2. нийтийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулахаар бол;

§28.1.1. нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол;

§28.1.2. гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол

§48.2.2. бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн;

§49.3.3. шинэ нөхцөл байдал бий болсноор нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөөр бол;

§49.3.5. нийтийн ашиг сонирхолд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг зайлуулахын тулд.

§56.3. Захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхолд ноцтой хор уршиг учруулахаар бол түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл арилгах үүднээс захиргааны гэрээг дангаар цуцалж болно.

---

<sup>42</sup> Өмчийн эрх зүйд өмчлөгчийн өмчлөх эрхийг туйлын эрх хэмээн үздэг.



§62.2. Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ.

§73.1.7. хуульд өөрөөр заасан нийтийн ашиг сонирхлыг хөндөх бусад асуудал.

§79.3. Холбогдох захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд, эсхүл гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж болохуйц сөрөг нөлөөг арилгах арга хэмжээг авах үүрэгтэй.

§81.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нийтийн ашиг сонирхлыг ноцтой хохироох тохиолдолд тухайн захиргааны актыг хүчингүй болгож болно.

---

б) ЗХШХШтХ-д захиргааны хэргийн шүүхээс шийдвэр гаргахдаа «нийтийн ашиг сонирхол»-ыг үндэслэл болгох дараах 2 тохиолдлыг зохицуулсан байна:

---

§62.1.1. захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол;

§106.3.10. захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох.

---

Дээрх хоёр хуулиас үзэхэд, эдгээр хуульд «нийтийн ашиг сонирхол» хэмээх ойлголтыг оруулсан боловч агуулгыг нь тайлбарлаагүй байна. Ийнхүү тайлбарлахгүй байх үндэслэл, шалтгаан бий. Тодруулбал, «нийтийн ашиг сонирхол» гэх ойлголт нь өмнө дурдсанчлан хуулиар шууд тодорхойлон заах боломжгүй ойлголт учраас хууль тогтоогч шууд болон тодорхой тайлбар хийхээс татгалзаж, нээлттэй орхисон болохыг харуулж байна.

ЗХШХШтХ-ийн §62.1.1-д «нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол захиргааны актын биелэлтийг

түдгэлзүүлэхгүй» гэж заасан. Үүнтэй холбогдуулан захиргааны хэргийн шүүхээс захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхтэй «нийтийн ашиг сонирхол» хэмээх ойлголтыг тухайн тохиолдолд тодорхойлох, дэнслэн үзэх шаардлага гардаг байна.

**Тохиолдол-1:** *Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 34 дүгээр захирамжаар «Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг баримтлан Ховд аймгийн Буянт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолын биелэлтийг уг хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлж шийдвэрлэсэн» байна. Харин Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх «Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1-д «...нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй» гэж заасан. Ховд аймгийн Буянт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолын биелэлтийг түдгэлзүүлснээр төрийн удирдлагыг тухайн орон нутагт хэрэгжүүлэх этгээд тодорхой бус болж, дээд шатны удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелэгдэх, төрийн бодлого, үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх боломжгүй болсны улмаас дээрх хуульд заасан хохирол учрах нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй юм» гэж үзэн шүүгчийн захирамжийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна<sup>43</sup>.*

**Тохиолдол-2:** *«Бодь пропертийз» ХХК нь шүүхэд «Эрүүл мэндийн яамны БУА 13-01-07 дугаар бүхий Гэмтэл согог судлалын төвийн харьяа Түлэнхийн төвийн барилгын ажил гүйцэтгэх тендер шалгаруулах үнэлгээний хорооны шийдвэрийг хүчингүй болгуулах» тухай шаардлага бүхий нэхэмжлэл гаргасантай холбогдуулан маргаан бүхий актын*

<sup>43</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол, 2018.02.27, №221/ШТ2018/0129.

*биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасныг шүүх хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ «Түлэнхийн төвийн барилгын ажлыг хойшлуулбал цаана нь хүний амь нас, эрүүл мэндийн эрх ашиг хөндөгдөж байгаа гэх боловч иргэдийн уг эрхийг хангах нь төрийн байгууллагын үүрэг бөгөөд барилгын ажлаас үл хамааран энэ үйл ажиллагаа тасралтгүй явагдах ёстой тул үүнээс үүдэн нийтийн эрх ашигт шууд хохирол учрах нөхцөл байдал тулгарсан гэж үзэх боломжгүй» гэж дүгнэжээ<sup>44</sup>.*

в) 2012 онд батлагдсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд «нийтийн ашиг сонирхол» хэмээх ойлголтыг хуульчилж, дараах байдлаар 4 удаа дурдсан байна:

---

§1.1. Энэ хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино.

§3.1.1. «нийтийн ашиг сонирхол» гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг;

§3.1.3. «ашиг сонирхлын зөрчил» гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;

§6.4. Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ.

---

<sup>44</sup> Ц.Цогт, З.Ганзориг «Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудал: Шүүхийн практикт тулгуурласан шинжилгээ» <http://legaldata.mn/b/154>

Дээрх хуульд «нийтийн ашиг сонирхол» гэдгийг захиргааны байгууллагад ажиллаж буй нийтийн албан тушаалтны эрх зүйн байдал, чиг үүрэгтэй нь холбож, тэдэнд итгэж буй олон нийтийн итгэлийг нийтийн ашиг сонирхол гэж үзнэ хэмээн тодорхойлжээ. Улмаар нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг «ашиг сонирхлын зөрчил» гэж ойлгохоор хуульчилжээ<sup>45</sup>.

Дүгнэн үзэхэд нийтийн ашиг сонирхлыг тодорхойлсон либерал, төр төвтэй, ардчилсан ёсны хэмээх онолын гурван өөр концепци байдаг бөгөөд «нийтийн ашиг сонирхол» гэх ойлголт нь хуулийн хэлэнд өргөн хэрэглэгддэг хэдий ч хуулиар шууд тодорхойлон заах боломжгүй ойлголт болохыг хууль зүйн шинжлэх ухааны олон тооны эх сурвалжид өгүүлжээ.

«Нийтийн ашиг сонирхол» гэх ойлголт нь юуны өмнө, нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлын эсрэг тодорхойлох буюу нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тухай ойлголт болохын зэрэгцээ нийтийн байх шинж чанар нь агуулгын болоод тооны бүрдүүлбэртэй байна. Гэхдээ тооны бүрдүүлбэрийг ердийн арифметик тоогоор тооцох боломж байхгүй гэдгийг зайлшгүй анхаарах шаардлагатай ажээ.

---

<sup>45</sup> «Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээх нь» сэдэвт бодлогын судалгааны ажил., УБ., 2016., 6 дахь тал.

### **3. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт**

Өмнө нь дурдсанчлан ЗХШХШтХ-ийн §18.3-т зааснаар хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд нь тухайн хуульд заасан асуудлаар, харин хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад этгээд нь «нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх», «дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх» шаардлагыг хангаж байгаа тохиолдолд хүрээлэн байгаа орчин (1), хүүхдийн эрх (2), нийтийн эрүүл мэнд (3), нийтийн өмчийг хамгаалах (4) гэсэн дөрвөн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой.

ЗХШХШтХ-ийн §18.3-т заасны дагуу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээд буюу тодорхой нийгэмлэг, холбоодод нийтийн ашиг сонирхлын төлөө шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг олгосон нь ардчилсан-плюралист концепцийн, мөн хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг олгосон нь төр төвтэй нийтийн ашиг сонирхлын концепцийн агуулгад хамаарч байна.

Иргэний нийгмийн байгууллага нь тодорхой ашиг сонирхол, зорилгоороо нэгдсэн (тухайлбал, амьтан хамгаалах, байгаль хамгаалах г.м) хүмүүсийн нэгдэл байдаг бөгөөд гишүүдийнхээ ашиг сонирхлыг хамгаалахын зэрэгцээ, нийтийн ашиг сонирхлыг (хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгаль хамгаалах г.м асуудлын хүрээн дэх) хамгаалах үүрэгтэй байдаг. Хэрэв тухайн нийгэмлэгийн зүгээс зөвхөн өөрт харьяалагдах гишүүний ашиг сонирхлын төлөө гаргасан нэхэмжлэлийг гишүүнийхээ эрх ашгийг хамгаалах нэхэмжлэл (egoistische Verbandsklage), нийтийн ашиг сонирхлын төлөө гаргасан нэхэмжлэлийг олон нийтийн төлөөх нэхэмжлэл (altruistische Verbandsklage) хэмээн ялган авч үздэг болохыг тэмдэглэх нь зүйтэй<sup>46</sup>.

<sup>46</sup> Friedhelm Hufen., Verwaltungsprozessrecht., 7. Auflage., C.H.Beck., München., 2008., 263 дахь тал.

### 3.1. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээдэд тавигдах шаардлага

*А. Нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх*

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар төрийн бус байгууллага нь дүрэмдээ «байгууллагынхаа зорилго»-ыг заавал тусгана. Иймд шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага нь түүний дүрэмд заасан зорилготой нийцэж байгаа эсэхийг шалгах гол нотлох баримт нь тухайн төрийн бус байгууллагын дүрэм байна. Нэхэмжлэгч байгууллага нэхэмжлэлдээ дүрмээ хавсаргаж өгөөгүй тохиолдолд шүүхээс нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох, тогтоосон хугацаанд дүрмээ ирүүлээгүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаах үр дагавар үүснэ. Мөн шүүх нэхэмжлэгч байгууллагын дүрмийг авалгүйгээр хэрэг үүсгэн ажиллагаа явуулж, улмаар шийдвэр гаргасан тохиолдолд энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөнд тооцогдоно<sup>47</sup>.

*Б. Дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх*

Одоогийн байдлаар шүүхийн практикт «Дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх» гэсэн шаардлагыг ямар нотлох баримтад үндэслэн шийдвэрлэх вэ? гэдэг дээр жишиг тогтоогүй байна.

**Байгуулагдсан он.** Тухайн байгууллага байгуулагдаад доод тал нь гурван жил болсон байх ёстой. Хэрэв байгуулагдаад гурван жил болоогүй байхдаа шүүхэд нэхэмжлэл гаргасан бол уг байгууллагыг

<sup>47</sup> «Өвчтөн нийгмийн төлөөллийн зөвлөл» ТББ нь «Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл»-д холбогдох захиргааны хэргийг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим хяналтын шатны журмаар шийдвэрлэхдээ «Өвчтөн нийгмийн төлөөллийн зөвлөл» ТББ-ын дүрэм, үүсгэн байгуулагдсан баримт бичиг хэрэгт нотлох баримтаар авагдаагүйгээс тус төрийн бус байгууллага нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд эсэхийг тодорхойлох боломжгүй байна» гэж дүгнэжээ.

<http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/787/view>

хуулийн шаардлага хангаагүй гэж үзэх нь тодорхой байна.

**Үйл ажиллагаа.** Энэ шаардлагад буй «сүүлийн», «тогтвортой» гэсэн нөхцөл нь зайлшгүй бөгөөд нийтийн ашиг сонирхлын маргааныг эхлүүлэх эсэхийг шийдвэрлэх нэг гол нөхцөл болно. Тодруулбал, хуульд зөвхөн нэхэмжлэгч төрийн бус байгууллага нь үйл ажиллагаа явуулсан байх нь хангалтгүй бөгөөд үйл ажиллагаа нь «сүүлийн гурван жилийн хугацаанд хийгдсэн байх», «тогтвортой байх» шаардлагыг тавьсан байна.

Иргэний хуулийн §25.1-д «Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ» гэж заасан. Үүнээс үзэхэд «тогтвортой үйл ажиллагаа эрхлэх» нь хуулийн этгээдийн нэгэн үндсэн шинж бөгөөд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, гишүүд, удирдлага, ажилтан, бусад оролцогчид өөрчлөгдөхөөс үл хамааран хуулийн этгээд оршин байж, үйл ажиллагаагаа тогтвортой явуулна<sup>48</sup>.

Дээрх шалгуурыг дараах нөхцөл байдал, баримтад үндэслэн тогтоох боломжтой гэж үзэж байна:

1/ Юуны түрүүнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд нь зөвхөн цаасан дээр (гэрчилгээтэй байснаар бус) биш хууль тогтоомжоо биелүүлж бодит байдал дээр оршин байх учиртай. Үүнийг тухайн байгууллага сүүлийн гурван жилийн хугацаанд хуульд заасны дагуу санхүү, татварын тайлангаа өгч байсан эсэх зэргээр үндэслэл болгон шалгаж болох юм. Гэхдээ төрийн бус байгууллага нь ашгийн төлөө бус байгууллага тул уг хугацаанд тухайн байгууллага орлого олсон эсэх («Х» тайлан гаргасан эсэх) нь ач холбогдолгүй.

2/ Тухайн төрийн бус байгууллага нь аливаа үйл ажиллагаагаа зөвхөн өөрийн нэрийн өмнөөс явуулсан байх ёстой бөгөөд үүсгэн байгуулагч, удирдлагын зүгээс хувиараа гүйцэтгэсэн ажил үүнд

---

<sup>48</sup> Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, УБ., 2015, 46 дахь тал.

хамааралгүй бөгөөд үүнийг ажлын үр дүнгийн талаарх мэдээлэл (тайлан, хэвлэлт), хамтран ажилласан байгууллагын тодорхойлолт зэргээр тогтоох боломжтой. Мөн Төрийн бус байгууллагын тухайн хуулийн §8.1-д «дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан» нь төрийн бус байгууллагыг татан буулгах үндэслэл болохоор заасан тул гүйцэтгэсэн үйл ажиллагаа нь дүрмийнхээ зорилгод нийцээгүй тохиолдолд нэхэмжлэгчийг үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үндэслэл болж чадахгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

### **3.2. Хангалттай сонирхол илэрхийлсэн байх**

ЗХШХШТХ-ийн §52.5-д нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлд хамаарах зүйлүүдийг заасан байх бөгөөд §52.5.5-д «нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар «хангалттай сонирхол илэрхийлсэн байх» бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй» тухайгаа нэхэмжлэлдээ тодорхой дурдах ёстой гэжээ. Өөрөөр хэлбэл, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээд нь нэхэмжлэлдээ захиргааны үйл ажиллагаа хууль бус гэдгийг дурдах нь хангалтгүй бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хангалттай сонирхол байгааг илэрхийлэх шаардлагатай юм.

«Хангалттай сонирхол илэрхийлсэн байх» гэдэг нь захиргааны байгууллага хууль бус үйл ажиллагааг (захиргааны акт гаргасан, захиргааны хэм хэмжээний акт баталсан, захиргааны гэрээ байгуулсан) хэрхэн явуулсан, захиргааны байгууллагын ямар хууль бус эс үйлдэхүй байгаа, үүний улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал хэрхэн бий болсон, яагаад заавал энэ ашиг сонирхлыг шүүхээр хамгаалуулах шаардлагатай болсон, шүүхээс шийдвэр гаргуулснаар нийтийн ашиг сонирхол хэрхэн хамгаалагдах талаар нэхэмжлэлийн үндэслэлдээ тодорхой тайлбарласан байх явдал юм.



### 3.3. Нэхэмжлэл гаргах асуудлууд

#### А. Хүрээлэн байгаа орчин уу? Байгаль орчин уу?

**Тохиолдол-3:** «Онги голын хөдөлгөөн» ТББ-аас «Байгаль орчин, аялал жуулчлалын яам»-д холбогдуулан «Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Бөөрөлжүүтийн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, байгаль орчинд учирсан хохирлыг тооцон гаргаж олон нийтэд мэдээлэхийг хариуцагчид даалгах» шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргажээ. Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн ба давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн бөгөөд хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн хэмээн үзэж хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн байна<sup>49</sup>.

**Тохиолдол-4:** Энэхүү судалгааг хийж байх үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдан олны анхаарлын төвд байгаа нэгэн маргаан бол «Ноён уулаа аврах хөдөлгөөн» ТББ-ын нэхэмжлэлтэй Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох маргаан байсан. Маргааны агуулга: Сэлэнгэ аймгийн Мандал суманд Ноён уулын хүдэр нь 27667378 тонн бөгөөд алтны 7594211 тонн нөөцтэй нь тогтоогдсон байдаг. Энэ баялгийн 66 хувийг «Сентерра Гоулд» ХХК, 34 хувийг төр эзэмшихээр болсон. Нэхэмжлэгч тал Ашиглалтын дөрвөн тусгай зөвшөөрөл нь «Сентерра Гоулд» ХХК-ийн нэр дээр байгаа ашигт малтмалын ашиглалтын дөрвөн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан байна.

**Үг зүйн тайлбар.** Монгол хэлний их тайлбар тольд «хүрээлэн буй орчин» гэдгийг «Биднийг хүрээлэн орших амьд болон амьгүй зүйлс

<sup>49</sup> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.09.14, №0653, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, 2017.12.06, №0859, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2018.02.26, №88, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3664/view>

орших орон зай»<sup>50</sup>, «байгаль орчин» гэдгийг «хүрээлэн буй сав шим ертөнц, хүний гараар бүтээгдээгүй, аяндаа бий болсон зүйл»<sup>51</sup> гэж тус тус тодорхойлжээ.

Монгол Улсын хуулиудад «хүрээлэн байгаа орчин» гэсэн нэр томъёог тодорхойлсон тодорхойлолт байхгүй, харин «хүрээлэн буй орчин», «хүрээлэн байгаа орчин» гэх зэрэг нэр томъёог хэрэглэсэн байна. Харин Байгаль орчныг хамгаалах тухай хууль (БОХТХ)-ийн §3.2.1-д «байгаль орчин» гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна гэж тодорхойлжээ<sup>52</sup>.

Дээрхээс үзэхэд хүрээлэн байгаа орчин гэх ойлголтыг байгаль орчин гэх ойлголттой харьцуулбал харьцангуй өргөн утгыг илэрхийлнэ. Үүнд байгаль орчноос гадна хүний гараар бий болгосон дүр төрх буюу хот, цэцэрлэг, усан сан, аж үйлдвэрийн цогцолбор, барилга байгууламжууд хамаарагдана. Мөн хүрээлэн буй орчныг байгаль орчин, зохиомол (хүний гараар бүтээсэн) орчин, нийгмийн орчин гэх зэргээр ангилсан нь ч байна.

**Гарал зүйн тайлбар буюу хууль тогтоогчийн хүсэл зориг.** УИХ-аар ЗХШХШТХ-ийн төсөл боловсруулсан ажлын хэсэг, УИХ-ын гишүүд «хүрээлэн байгаа орчин» гэдгийг «байгаль орчин» гэж ойлгож байсан нь хуулийн төслийг хэлэлцсэн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс харагддаг<sup>53</sup>.

<sup>50</sup> <https://mongoltoli.mn/dictionary/detail/118377>

<sup>51</sup> <https://mongoltoli.mn/dictionary/detail/118377>

<sup>52</sup> *Чулуун мандал* (литосфер) – Астеносфер (мантийн дээд хэсэгт 70-700 км-ийн хооронд орших сийрэгжсэн, бага нягттай, уян налархай шинжтэй давхарга)-ээс дээших манти (мантийн давхарга нь газрын давхаргаас дотогш үргэлжилнэ. Дээд манти нь 900км хүртэл, доод манти нь 900-2900 км-ийн гүн хүртэл үргэлжилнэ)-ийн дээд хэсэг дээрх газрын давхарга, *Усан мандал* (гидросфер) - Дэлхийн усан шингэн бүрхүүл, *Агаар мандал* (атмосфер) - Дэлхийн татах хүчинд захирагдан, дэлхийн гадна талаар хүрээлэн байгаа хийн бүрхэвч, *Шим мандал* (биосфер) - Эрт эдүгээгийн амьд биет, амьдралын бүхий л ул мөр, үзэгдлийг агуулж буй дэлхийн бөмбөрцгийн орон зай. Шим мандлын үндсэн гол бүрэлдэхүүн нь амьд биет (амьтан, бичил биетэн, ургамал- эдгээрийг бүхэлд нь биосферийн амьд бодис гэнэ) юм.

<sup>53</sup> Хуулийн төслийг хэлэлцүүлэх ажлын хэсгийн даргын «нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд байгаль орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байгаа» гэсэн тайлбар байнгын хорооны хуралдааны тэмдэглэлд тусгагджээ. УИХ-ын 2015 оны намрын ээлжит

Иймд цаашид шүүхийн практикт «Хүрээлэн байгаа орчин» гэх ойлголтыг «Байгаль орчин» гэх ойлголттой адилтган хэрэглэх үү, эсхүл үг зүйн утгаар нь «Байгаль орчин» гэх ойлголтоос илүү өргөн утгаар нь хэрэглэх үү? гэсэн асуудлыг нэг мөр тодорхой болгох шаардлага тулгарч байна.

#### *Б. Хүүхдийн эрх*

**Тохиолдол-5:** *Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүүхдийн эрхийн асуудалтай холбоотой олны анхаарлын төвд байсан нэгэн маргаан бол хурдан морины унаач хүүхдүүдийн эрхийн асуудал байсан. Засгийн газар 2017 оны 02 дугаар сарын 22-нд 63 дугаар тогтоол баталж «Хурдан морины бүсийн уралдааны 2017 оны хуваарь»-ийг гаргасан бөгөөд уг тогтоолын 1 дэх заалтаар «Төвийн бүсийн хаврын хурдан морины “Дүнжингарав” уралдааныг 2017 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын Цагаан хөтөлд, бүсийн хурдан морины уралдааныг Хөвсгөл, Говь-Алтай аймагт 2017 оны 3 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулахыг, 2 дахь заалтаар Зүүн бүсийн зуны хурдан морины уралдааныг Сүхбаатар аймагт, Хойд бүсийн хурдан морины уралдааныг Сэлэнгэ аймагт, Говийн бүсийн хурдан морины уралдааныг Дундговь аймагт, Хангайн бүсийн хурдан морины уралдааныг Өвөрхангай аймагт, Баруун бүсийн хурдан морины уралдааныг Увс аймагт, Төвийн бүсийн хурдан морины уралдааныг Улаанбаатар хотын Хүй долоон худагт 2017 оны 7 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулахыг, 3 дахь заалтаар Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд холбогдох дүрмийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд, уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр явуулахыг холбогдох аймаг болон Нийслэлийн Засаг дарга, Монголын морин спорт, уяачдын холбоонд тус тус даалгаж шийдвэрлэжээ.*

---

чуулганы Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр /лхагва гараг/-ийн хуралдааны тэмдэглэл, 47 дахь тал.

Засгийн газрын дээрх шийдвэрийг эсэргүүцэж «Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний сүлжээ», «Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ», «МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ», «Өсвөр үеийнхний хөгжлийн төв», «Хүүхэд залуучуудын хөгжил хамгаалал», «Бүх нийт боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл», «Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв» зэрэг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагууд Засгийн газрыг хариуцагчаар татан Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхэд маргаан үүсгэсэн. Шүүхээс Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоолын 1 дэх заалт болох «Хурдан морины бүсийн уралдааны 2017 оны хуваарийг тогтоох тухай 63 дугаар тогтоол»-оор «Төвийн бүсийн хаврын хурдан морины Дүнжингарав» уралдааныг 2017 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын Цагаан хөтөлд, бүсийн хурдан морины уралдааныг Хөвсгөл, Говь-Алтай аймагт 2017 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тус тус зохион байгуулсугай» гэснийг хууль бус байсныг тогтоож шийдвэрлэсэн байна<sup>54</sup>.

**Тохиолдол-6:** *«Боловсролын давалгаа» ТББ-аас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд холбогдуулан «Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн «Иргэний боловсрол (ёс суртахууны унших эх) сурах бичгүүдийг хэрэглээнээс хасаж, сурахуйн онол, заах аргазүйн шаардлагад нийцүүлэн дахин зохиож хэрэглээнд нэвтрүүлэхийг хариуцагчид даалгах (1), Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/240 тоот тушаалаар батлагдсан «Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр»-ийн «Иргэний боловсрол» хичээлд холбогдох 6.1 ба 6.2 хэсгийг тус тус хүчин төгөлдөр бусад тооцуулах (2)» шаардлага бүхий нэхэмжлэл гаргаснаас шүүх нэхэмжлэлийн 1 дэх шаардлагыг хангаж, 2 дахь шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна<sup>55</sup>.*

<sup>54</sup> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.09.21, №688, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, 2017.11.23, №0830, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2018.01.15, №26, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1203/view>

<sup>55</sup> Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2016.10.14, №739,

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн<sup>56</sup> 1 дүгээр зүйлд «Энэхүү Конвенцийн зорилгод тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу тэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ», Хүүхдийн эрхийн тухай хуулийн §3.1-д «Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ» гэж заасан байна. Үүнээс үзвэл 0-18 хүртэлх насны хүний эрхийн тухай асуудал энэ хүрээнд яригдана гэсэн үг. Судалгаанаас үзэхэд хүүхдийн эрх зөрчигдөж буй дараах нийтлэг тохиолдлууд байна:

- 1) Хүчирхийллийн улмаас хүүхэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох;
- 2) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх;
- 3) Хүүхэд зам тээврийн осолд өртөх;
- 4) Агаарын болон орчны бохирдол - хүүхдийн эрүүл мэнд;
- 5) Уул уурхайтай холбоотой хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр;
- 6) Түлэгдэлт - халуун тогоо;
- 7) Хурдан морины унаач хүүхдийн асуудал.

Дээрх тохиолдлуудаас захиргааны байгууллагын үйл ажиллагаа, ялангуяа захиргааны байгууллагын эс үйлдэхүйтэй хамааралтайгаар үүсэж байгаа асуудал гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох эрх<sup>57</sup>, хүүхэд зам тээврийн осолд өртөх<sup>58</sup>, хурдан морины унаач хүүхдийн асуудал, агаарын бохирдол ба-хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг нэрлэж болох юм. Хүүхдийн эрүүл мэнд буюу хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийн асуудал нь нийтийн эрүүл мэндтэй давхцах, холбогдох тохиолдол түгээмэл байж болохоор байна. Тухайлбал, Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудал нь хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, байгаль орчинтой шууд холбогдоно.

---

<http://new.shuukh.mn/zahirgaanhan/1908/view>

<sup>56</sup> <http://legalinfo.mn/law/details/1276?lawid=1276>

<sup>57</sup> Сургуулийн дэд бүтцийг сайжруулах (налуу зам, шаардлага хангасан ариун цэврийн өрөө гэх мэт), харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулан ном, сурах бичгийг брайль үсгээр хөрвүүлж гаргах, электрон ном гаргах, дохионы хэлмэрчийг бэлтгэх гэх мэт асуудлууд байж болно.

<sup>58</sup> Сургуулийн ойр орчмын зам дээр school police буюу сургуулийн цагдаа ажиллуулах, хурд сааруулагч, явган зорчигчийн гарц, тэмдэглэгээ хийх гэх мэт асуудлууд байж болно.

*В. Нийтийн эрүүл мэнд*

**Тохиолдол-7:** «Өвчтөн, нийгмийн төлөөллийн зөвлөл» ТББ-аас Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлд холбогдуулан «Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, гепатитын вирусийг эрт илрүүлэх, оноилох, эмчлэх удирдамжид орсон эмийг үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад бүрэн хамруулж, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн 40-өөс багагүй хувийн хөнгөлөлт үзүүлэхийг даалгах» шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргажээ. Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн бол, давж заалдах болон хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзэж хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ<sup>59</sup>. Улмаар хэрэг анхан шатны шүүхэд ирсний дараа нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага нь «захиргааны хэм хэмжээний акт» гаргуулах байгаа тул уг маргаан нь анхан шатны шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан биш гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзсан шийдвэр гаргасныг нэхэмжлэгч эс зөвшөөрч гомдол гаргаагүй байна.

*Нийтийн эрүүл мэндийн тухай ойлголт: Үндсэн хуулийн үндэслэл ба салбарын хуульд тусгагдсан байдал*

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн бүр «эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй», түүнчлэн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн

<sup>59</sup> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2016.10.21, №814, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 2017.01.18, №0066, Улсын дээд шүүхийн хяналтын захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2017.04.23, №122 <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/787/view>

эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна» гэж зааснаар Засгийн газар, захиргааны бусад байгууллага нь иргэний эрүүл мэндийг хамгаалах, түүнд чиглэсэн үр нөлөөтэй цогц арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн. Нөгөө талаас Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн «эрүүл мэндээ хамгаалах» журамт үүрэгтэй байдаг бөгөөд нийгмийн гишүүн болсон иргэн бүр өөрийн эрүүл мэндийг захиргааны байгууллагаас өгсөн зөвлөгөө, чиглэмжийн дагуу хамгаалах арга хэмжээг хувьдаа авч байх, мөн хууль тогтоомж, төрийн бодлогын хүрээнд бий болгосон эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх механизмыг ашиглаж, өөрийн эрүүл мэндийг хамгаалах учиртай байна.

Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг хянах, өвчлөлийн аюултай байдал, хортой үр дагаврыг сурталчлан, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, бататган бэхжүүлэх зорилгоор УИХ-аас 2011 онд Эрүүл мэндийн тухай хуулийг<sup>60</sup> баталсан байна. Тус хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах явдал.

Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад эрүүл мэнд, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хэмээх ойлголтуудыг дараах байдлаар тодорхойлжээ:

- а/ «Эрүүл мэнд» гэж хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг;
- б/ «Эрүүл мэндийг хамгаалах» гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг;

---

<sup>60</sup> <http://www.legalinfo.mn/law/details/49?lawid=49>



в/ «Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ» гэж нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэжээ.

Дээрх хуулийн тодорхойлолтуудаас харвал, нийтийн эрүүл мэнд гэх ойлголтыг шууд тодорхойлоогүй ч агуулгын хувьд нийгмийн гишүүн бүрийн эрүүл энх амьдрал, түүнийг хамгаалах цогц арга хэмжээ, тусламж үйлчилгээг энэ хуулиар бататган бэхжүүлэхээр хуульчилж, «нийгмийн эрүүл мэнд» хэмээх томъёоллоор илэрхийлсэн болох нь харагдаж байна. Түүнчлэн, УИХ-аас 2001 оны 81 дүгээр тогтоолоор «Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого<sup>61</sup>»-ыг баталсан байна. Тус бодлогоос үзвэл:

- Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь байгаль, хүн, нийгмийн зохицлыг хангаснаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.
- Нийгмийн эрүүл мэндийг төлөвшүүлэх гэж хүний амьдралын чанарын түвшинд сөргөөр нөлөөлж, өвчин, эмгэг, осол, гэмтэлд хүргэж буй нийгэм, эдийн засаг, орчны хүчин зүйлээс сэргийлэх, шалтгаан, үр дагаврыг арилгах, хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийгмийн нөөц, бололцоог зүй зохистой ашиглах үйл ажиллагааг хэлнэ.
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг зөвхөн өвчин эмгэгийг эрт илрүүлэх, төгс эмчлэх төдийгүй, эрүүл хүнд хандуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх нь хүний хөгжлийн чухал хэсэг болох нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл болно гэж заажээ.

Мөн Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлохдоо:

---

<sup>61</sup> <http://www.legalinfo.mn/annex/details/3330?lawid=6389>



- хувь хүн, гэр бүл, хамт олонд хүртээмжтэй, энгийн арга хэлбэрээр өөрсдийг нь оролцуулах замаар эрүүл мэндийн анхны тусламжийг хөгжүүлэх;
- хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэдэг зан үйлтэй болгох ажиллагааг бүх талаар хөгжүүлэх;
- хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- эрүүл мэндийн салбарын тогтолцоог нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглүүлэн боловсронгуй болгож нийгмийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын шинэчлэлийг хийх хэмээсэн байна.

Энэ бүхнээс үзэхэд, нийтийн эрүүл мэнд гэдэг нь нэг талаар нийгмийн гишүүн бүрийн эрүүл энх амьдрал ба нөгөө талаар тэрхүү эрүүл энх амьдралыг бий болгоход чиглэсэн үр нөлөө бүхий цогц үйл ажиллагаа болох нь харагдаж байна.

*Нийтийн эрүүл мэндийн тухай ойлголт:*

*Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт*

Нийтийн эрүүл мэнд хэмээх ойлголтыг тодорхойлох оролдлогыг дэлхийн олон орны эрдэмтэд хийсэн байх бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, түүний гишүүн орнуудаас гаргасан нийтийн эрүүл мэндийн нөхцөл байдлын тайланд хамгийн олон удаа эш татагдаж, хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтуудыг энэ хэсэгт авч үзэв.

- 1/ Эрдэмтэн Винсловын 1920 онд хийсэн тодорхойлолтын хүрээнд авч үзвэл «Нийтийн эрүүл мэнд гэдэг нь нийгмийн гишүүн бүрийн амьдралд эрүүл байдлыг хэвээр хадгалах механизмыг бий болгож хөгжүүлэхийн тулд аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа, мөн өвчний илрэлийг эрт оношлох эмнэлгийн болон сувилгааны үйлчилгээ бүхий байгууллага, хүн бүрт эрүүл ахуйн үндсэн зарчмыг зааж, мэдлэг олгох байгууллага, нийгэмд бий болж буй халдваруудыг хянах, хүрээлэн буй орчны эрүүл ахуйн байдлын төлөөх зохион байгуулалттай нэгдсэн байгууллагуудаар тус тус дамжуулж бие махбодийн эрүүл чийрэг байдал болон түүний үр дагаврыг сурталчлах, мөн

амьдрах насыг уртасгах, өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжлэх ухаанч цогц үйл ажиллагаа юм»<sup>62</sup> гэжээ.

Дээрхээс үзвэл, нийтийн эрүүл мэнд гэдгийг:

- а/ аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа;
  - б/ бүх төрлийн эрүүл мэндийн байгууллага, сувилал, эрүүл мэндийн боловсролын байгууллага, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны хяналтын байгууллагын зохион байгуулалттай сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа;
  - в/ амьдрах насыг уртасгах, өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжлэх ухаанч үйл ажиллагаа хэмээн «цогц үйл ажиллагаа» болохыг тодорхойлсон байна.
- 2/ Эрдэмтэн Доналд Ачесоны 1988 онд хийсэн тодорхойлолтын хүрээнд авч үзвэл, «Нийтийн эрүүл мэнд гэдэг нь тусгай зохион байгуулалттай байгууллагуудаар дамжуулан өвчнөөс урьдчилан сэргийлэх, амьдрах насыг уртасгах болон эрүүл амьдралыг сурталчлах шинжлэх ухаанч үйл ажиллагаа»<sup>63</sup> гэжээ. Дээрхээс үзвэл, тус тодорхойлолт нь Винсловын хийсэн тодорхойлолттой харьцуулахад явцуу боловч агуулгын хувьд адил байдлаар авч үзсэн нь ойлгомжтой харагдаж байна.
- 3/ Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан нэр томъёоны тодорхойлолтоос үзвэл «Нийтийн эрүүл мэнд: Энэ нь бүхэлдээ нийгмийн эрүүл мэндийн тухай асуудлыг хамарч байгаа ойлголт юм. Нийтийн эрүүл мэндийн үндсэн гурван чиг үүрэг бол:
- а. Эрүүл мэндэд учирч буй асуудлыг гаргаж ирэхийн тулд нийгмийн эрүүл мэндийн байдлыг хянаж шалгах;
  - б. Үндэсний болон бүс нутгийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхийн тулд бодлого боловсруулах;
  - в. Хүмүүсийг зүй зохистой болон боломжийн үнэ бүхий эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжоор хангах. Үүнд:

<sup>62</sup> A SYSTEMATIC APPROACH TO PUBLIC HEALTH OPERATIONS AND SERVICES: Towards positive coordination with health care and other services. Dr Jose M. Martin-Moreno, 2011, WHO

<sup>63</sup> Мөн тэнд

эрүүл ахуйн байдлыг сурталчлах, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээ мөн тухайн үйлчилгээний үр өгөөжтэй байдлыг үнэлэх зэрэг багтана»<sup>64</sup> гэжээ.

Үүнээс үзвэл, нийтийн эрүүл мэнд гэдэг ойлголтын хүрээнд нийгмийн хүн амын эрүүл мэндийн асуудал, түүн дотроо эрүүл байх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээний үр өгөөжтэй, хяналт шалгалтын механизм үр нөлөөтэй, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах талаар төрийн бодлого оновчтой, тодорхой байх тухай ойлголт яригддаг болох нь тодорхой байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон түүний хүлээн зөвшөөрсөн тодорхойлолтуудыг Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль болон Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлоготой харьцуулан үзвэл нийтийн эрүүл мэнд гэх ойлголтыг агуулгын хувьд адил байдлаар авч үзсэн байна гэж дүгнэж болохоор байна.

*Нийтийн эрүүл мэндийн зөрчил ба түүнийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн хамгаалалт*

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасны дагуу нийтийн (нийгмийн) эрүүл мэндийг хамгаалах дүрмийн зорилготой төрийн бус байгууллага нь Монгол Улсын захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй:

а/ аливаа өвчнөөс хүн амыг урьдчилан сэргийлэх ажиллагаа;

б/ төрийн өмчит бүх төрлийн эрүүл мэндийн байгууллага, сувилал, эрүүл мэндийн боловсролын байгууллага, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны хяналтын байгууллагын зохион байгуулалттай сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа;

в/ амьдрах насыг уртасгахад чиглэсэн үйл ажиллагаа нь нийтийн эрүүл мэндийг хамгаалахад хангалтгүй, үр нөлөөгүй байна, эсхүл авч хэрэгжүүлж буй арга хэмжээ (шийдвэр, үйл ажиллагаа) нь хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжуудыг зөрчсөн байна гэж үзвэл тухайн шийдвэр,

<sup>64</sup> WHO Centre for Health Development Ageing and Health Technical Report Volume 5, A GLOSSARY OF TERMS FOR COMMUNITY HEALTH CARE AND SERVICES FOR OLDER PERSONS 2004

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

үйл ажиллагааны эсрэг Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган, зөрчлийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлж болох юм. Тухайлбал, сэргийлэх үзлэгийн төлбөрийг хэт өндөр тогтоосон тохиолдолд тэр нь хууль ёсны бөгөөд бодит нөхцөл байдалд нийцэж буй эсэхийг тогтоолгохоор Захиргааны шүүхэд хандах, Монголчуудын дунд сүүлийн жилүүдэд хамгийн түгээмэл тохиолдож байгаа зүрх судас, хорт хавдар, амьсгалын замын халдварт өвчин, мэдрэлийн эмгэг өвчин зэргийг эмчлэхэд зориулсан эм, тарианы үнэ хэт өндөр байгаа тохиолдолд эмийн даатгалд хамруулах хууль зүйн үндэслэлтэй эсэхийг хянуулахаар Захиргааны хэргийн шүүхэд хандах, эсхүл эмийн даатгалд хамруулах үүргийг хүлээсэн боловч одоог хүртэл зохих шийдвэр гаргахгүй байгаа захиргааны байгууллага байгаа бол эс үйлдэхгүйг хууль бус болохыг нь тогтоолгож, эмийн даатгалд хамруулахыг даалгах нэхэмжлэлийг Захиргааны шүүхэд гаргах гэх мэтээр нийтийг хамарсан асуудлаар буюу нийтийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн асуудлаар холбогдох нэхэмжлэл гаргах боломжтой байна.

### *Г. Нийтийн өмч*

Хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэндийг хамгаалах талаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэгч гаргах явдал харьцангуй түгээмэл байж болох бол харин нийтийн өмчийг хамгаалах тухай ойлголт нь нийтийн өмчийн тухай Үндсэн хуулийн болон Иргэний хуулийн зохицуулалтуудаас үзэхэд ярвигтай байдлыг бий болгож болзошгүй юм.

**Тохиолдол-8:** *«Шинэ эвлэл орон нутгийн сэтгүүлчдийн холбоо», «Алтай бидний шүтээн» төрийн бус байгууллагуудаас Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид холбогдуулан «Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 75, 76, 77 дугаар тогтоолуудыг хүчингүй болгуулах» шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэгч нар «Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 75, 76, 77 дугаар тогтоолоор 6 ширхэг орон сууцыг хувьчилж улсын хөрөнгийг*

*хууль бусаар зарцуулсан» хэмээн шүүхэд нэхэмжлэл гаргаснаас үзвэл уг нэхэмжлэл нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нийтийн өмчийг хамгаалах асуудлаар гаргасан нэхэмжлэл байна.*

*Анхан шатны шүүх нэхэмжлэгч төрийн бус байгууллагууд нь ЗХШХШтХ-ийн §18.3-т заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэснийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна<sup>65</sup>.*

*Нийтийн өмчийн тухай ойлголт: Үндсэн хуулийн үндэслэл*

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын нэг шинэ элемент бол өмчлөх эрх хийгээд түүний объект болсон өмчийн асуудлыг авч үзэхдээ дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл чиг хандлагатай нийцүүлсэн буюу нийтийн болон хувийн өмчийн хэлбэрийн аль алиныг нь хүлээн зөвшөөрч Үндсэн хуулийн суурь зарчим болгон эрх зүйн хамгаалалт хийж өгсөн явдал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт «Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна», мөн зүйлийн 2 дахь хэсэгт «Төр нь *нийтийн* болон хувийн *өмчийн* аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална» хэмээн зааж өгсөн байх бөгөөд үүнээс үзвэл өмч хэмээх эдийн засгийн болоод хууль зүйн ойлголтыг Үндсэн хуулийн хүрээнд бэхжүүлэн, түүн дотроо нийтийн өмчийн асуудлыг орхигдуулалгүй тогтоож өгсөн ач холбогдолтой. Гэвч сүүлийн жилүүдэд хувийн өмчийг бэхжүүлэн хамгаалах асуудалд төрийн бодлого, хууль тогтоомжийн үзэл баримтлал хэт хэлбийснээс өмчийн нэг чухал хэлбэр болох нийтийн өмчийг тогтоох, удирдах, хамгаалах асуудал иргэний нийгмийн хувьд ч, төрийн засгийн хувьд ч орхигдож ирснийг олон жишээ нотолж байна.

Энэхүү нөхцөл байдлыг хууль тогтоогч илрүүлэн тогтоосноор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн


<sup>65</sup> Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, 2018.02.07, №125/ШЗ2018/0042, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол, 2018.03.06, №0221/ШТ2018/0155

хүрээнд нийтийн өмчийг хамгаалах асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас гадна нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд тодруулбал, төрийн бус байгууллагад шүүхэд нэхэмжлэл гаргах эрх олгосноор цаашид нийтийн өмчийг хамгаалах талаар заасан Үндсэн хуулийн суурь зарчим, үзэл баримтлалыг амьдралд хангах бодитой үндэс бий болгож өгсөн гэж дүгнэж болох юм.

Нийтийн өмчийг хувийн өмчөөс ялгах гол шалгуур нь тухайн өмч хөрөнгийн зориулалт нь нийтийн байх шинжтэй байдгаар тодорхойлогдоно<sup>66</sup>.

*Нийтийн өмч: Иргэний хуулийн үндэслэл*

2002 онд батлагдсан Иргэний хуулийн<sup>67</sup> 99 дүгээр зүйлд өмчийн төрөл, хэлбэрийг хуульчилсан болно. Тус хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт «Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна», мөн зүйлийн 99.2 дэх хэсэгт «Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна», 99.4 дэх хэсэгт «Нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбэрээр байж болно» хэмээн Үндсэн хуулийн суурь үндэслэлийг бататган бэхжүүлж өгсөн. Үүнээс үзвэл, нийтийн өмч, түүнд хамаарах хэлбэрийг төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байхаар хуульчилжээ. Үүнийг зургаар дүрсэлбэл:



<sup>66</sup> Franz-Joseph Peine, Allgemeines Verwaltungsrecht, 7. Auflage. 2004, ISBN 3-8114-9017-6.

<sup>67</sup> <http://www.legalinfo.mn/law/details/299?lawid=299>

Түүнчлэн Иргэний хуулийн §100.1-д «Хуульд өөрөөр заагаагүй бол төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, иргэн болон хуулийн этгээд өмчлөгч байна» гэж өмчлөгч этгээдийг хуульчилсан байдаг бол өмчлөх эрх, түүнд хамаарах эрхийн элементүүдийг тус хуулийн §101.1-д «Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй» гэж заасан байна.

Нийтийн өмчид хамаарах төрийн болон орон нутгийн өмчийн хэлбэр, түүнийг тогтоох, удирдах, хамгаалах эрх зүйн асуудлыг 1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (ТБОНӨТХ)-иар<sup>68</sup> зохицуулсан. Харин нийтийн өмчид хамаарах шашны болон олон нийтийн өмчийн хэлбэр, түүнийг тогтоох, удирдах, хамгаалах эрх зүйн асуудлыг зохицуулсан хууль өнөөдрийг хүртэл Монгол Улсад байхгүй байгаа болно.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн<sup>69</sup> хүрээнд сүм, хийдийн өмч, аж ахуйн харилцааг зохицуулсан нэг зүйл байгаа<sup>70</sup> хэдий ч хэт ерөнхий, зарим талаар шашны өмч хэмээх ойлголтоос гадуур байхаар хуульчлагдсан байдгийг анхаарах учиртай. Тухайлбал, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт «Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд байгаа газраас үл салах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд, дурсгалын талаарх мэдээллийг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ» гэж зааснаас үзвэл Гандантэгчинлэн хийдийн хашаан дотор түүх, соёлын үл хөдлөх дурсгал олдсон гэж төсөөлөхөд тэрхүү олдвор нь шашны өмч биш, харин тухайн хийдийн буюу Гандантэгчинлэн хийдийн өмч байх мэтээр ойлгогдож байгаа нь шашны өмчийг сүм, хийдийн өмчөөс хэрхэн зааглах хууль зүйн шалгуурыг тодорхой болгох бодитой шаардлага байгааг нөхцөлдүүлж байгаа болно. Тэгж гэмээнэ

<sup>68</sup> <http://www.legalinfo.mn/law/details/492?lawid=492>

<sup>69</sup> <http://www.legalinfo.mn/law/details/485?lawid=485>

<sup>70</sup> Тус хуулийн 11 дүгээр зүйлийг үзнэ үү.

сүм, хийдийн өмчөөс шашны өмчийг тусгаарлан ойлгох, улмаар шашны өмчийг хамгаалах талаар нийтийн ашиг сонирхлын өмнөөс нэхэмжлэл гарган маргах явдлыг тодорхой болгох боломжтой болно.

Дээрхтэй адил олон нийтийн өмч гэдэгт юуг хамааруулан ойлгох, түүнийг төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчөөс хэрхэн зааглан ялгах талаар өнөөдрийг хүртэл Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаанд болон практикт тогтсон үзэл баримтлал, судалгаа шинжилгээний цогц бүтээл байхгүй байна.

*Төрийн болон орон нутгийн өмч: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зохицуулагдсан байдал*

ТбОНӨтХ-иар төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахыг зорьсон. Тус хуулийн системчлэлийг үзвэл, төрийн болон орон нутгийн өмч гэсэн хоёр үндсэн хэсэгтэй бөгөөд 3 дугаар зүйлд төрийн өмчийн зүйлс, түүний ангилал, 74 дүгээр зүйлд орон нутгийн өмчийн зүйлс, түүний ангиллыг тус тус тогтоож өгсөн.

Нэг. ТбОНӨтХ-ийн 3 дугаар зүйлд зааснаар төрийн өмч нь төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмчөөс бүрдэнэ. Төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмч нь Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөд хуваагдана.

А. Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ (ТбОНӨтХ §4.1). Төрийн нийтийн зориулалттай өмчид 1/ иргэдэд өмчлүүлснээс бусад газар; 2/ газрын хэвлий, түүний баялаг; 3/ ус, түүний доторх баялаг; 4/ ой, түүний дагалдах баялаг; 5/ ургамал, ан амьтны нөөц; 6/ түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал; 7/ археологийн болон палеонтологийн олдвор; 8/ хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө хамаарахаар заасан байна (ТбОНӨтХ §4.2).



Дээрхээс үзвэл, төрийн нийтийн зориулалттай өмчийг хамгаалах асуудлын хүрээнд төрийн бус байгууллага захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд тухайн нэхэмжлэлийн шаардлагын объект нь иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, түүний доторх баялаг, ой, түүний дагалдах баялаг, ургамал, ан амьтны нөөц, түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал, археологийн болон палеонтологийн олдвор, хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгөтэй холбоотой байхыг шаардахаар байна. Гэхдээ ТБОНӨТХ-д заасан төрийн нийтийн зориулалттай өмчид хамаарч байгаа иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, түүний доторх баялаг, ой, түүний дагалдах баялаг, ургамал, ан амьтны нөөц нь «байгаль орчин» гэх ойлголттой давхцаж байгааг анхаарах шаардлагатай.

Судлаачдын үзэж байгаагаар хүрээлэн байгаа сав шим ертөнц буюу хүний гараар бүтээгдээгүй, аяндаа бий болсон зүйл (чулуун мандал, усан мандал, агаар мандал, шим мандал)-д хамаарах төрийн нийтийн зориулалттай өмчийг «байгаль орчин» гэсэн ойлголтод хамааруулж, харин хүний гараар бүтээгдсэн нийтээр ашиглах зориулалттай, тодруулбал ТБОНӨТХ-д заасан хөрөнгө, эд юмсыг «нийтийн өмч» гэх ойлголтод хамааруулж үзэх нь зүйтэй болов уу.

Б. Төрийн өөрийн өмчид тус хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох эд хөрөнгө хамаарах бөгөөд тэдгээрт 1/ төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө; 3/ төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө; 4/ улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан; 5/ төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц; 6/ хуульд заасан бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө тус тус хамаарна (ТБОНӨТХ §5.1).

Эндээс харахад, төр өөрийн өмчийг хамгаалах асуудлын хүрээнд төрийн бус байгууллага нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах гэж буй тохиолдолд тухайн нэхэмжлэлийн шаардлага нь төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгөтэй холбоотой байх, төрийн өмчит үйлдвэрийн газарт

эзэмшүүлсэн эд хөрөнгөтэй холбоотой байх, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгөтэй холбоотой байх, төрийн тусгай сангийн хөрөнгөтэй холбоотой байх, төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөцтэй холбоотой байх, хуульд заасан бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөтэй холбоотой байхыг шаардана.

Харин улсын төсвийн хөрөнгө нь ТБОНӨТХ-ийн дагуу хэдийгээр нийтийн өмчид тодруулбал, төрийн өөрийн өмчид хамаарч байгаа боловч улсын төсвийн хөрөнгө бүхэлдээ нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргах нэхэмжлэлийн шаардлагад хамаарах уу гэдэг асуудлыг зайлшгүй тодруулах шаардлагатай болно.

**Тохиолдол-9:** *«Онч шийдэл» ТББ-аас Үндэсний аудитын газарт холбогдуулан «Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас гаргуулж хохиролд олгосон мөнгийг буруутай этгээд болох Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Засаг даргаас гаргуулах үүргээ биелүүлэх талаарх өргөдөлд хариу өгөхгүй байгаа нь хууль бус болохыг тогтоож 2.7 тэрбум төгрөгийг гаргуулах акт тогтоохыг даалгах тухай» шаардлага бүхий нэхэмжлэл гаргасныг шүүх хүлээн авч захиргааны хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.*

Мөн төрийн нийтийн зориулалттай өмч болон төрийн өөрийн өмчийг хувьчлах үйл ажиллагаанд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх хязгааргүй хүрээнд нээлттэй байх уу, эсхүл тодорхой хязгаартай хэрэгжих үү гэдгийг зааглан тогтоох шаардлагатай. ТБОНӨТХ-ийн 32 дугаар зүйлд «Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн энэ хуульд заасан арга хэлбэр, нөхцөлийн дагуу хувийн өмчид шилжүүлэхийг төрийн өмч хувьчлах (цаашид энэ хуульд «хувьчлах») гэнэ» хэмээн зааж өгсөн. Мөн хуулийн §33.1-д «Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах арга хэмжээг Засгийн газар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын саналыг авч, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкиг хувьчлах арга хэмжээг Засгийн газар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын

саналыг авч Монголбанктай хамтран баталсан хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ», §33.2-т «Хөтөлбөрт хувьчлалын зорилго, үе шат, арга, хэлбэр, хувьчлах объектын жагсаалт зэргийг тусгасан байна», §33.3-т «Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх хугацаа, арга хэлбэр, байгууллагын жагсаалтыг Засгийн газар, УИХ-ын Нийгмийн бодлогын болон Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн жил бүр батална» гэж тус тус заажээ.

Дээр дурдсан хуулийн заалтуудыг Засгийн газар зөрчсөн тохиолдолд нийтийн өмчийг хамгаалах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий төрийн бус байгууллага захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган Засгийн газрын хууль бус шийдвэр, үйл ажиллагааг шүүхээр хянуулах боломжтой байна. Харин тус хуулиар өмч хувьчлалын асуудлаар захиргааны байгууллагад сонгох боломж олгосон бөгөөд тэрхүү сонгох боломжийн хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагаа бүрийг нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүхээр хянуулах боломжгүй юм<sup>71</sup>.

Хоёр. ТбОНӨтХ-ийн §74.1-д зааснаар «Орон нутгийн өмчийн зүйлс нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ» гэжээ. Тодруулбал, орон нутгийн өмч нь орон нутгийн нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ<sup>72</sup>. Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгө хамаарна (ТбОНӨтХ §74.2). Тухайлбал, сумын хүн амыг дулаанаар хангадаг уурын зуух, сумын хүн ам нийтээрээ хэрэглэдэг зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт. Үүнээс үзэхэд, орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбоотойгоор нийтийн ашиг сонирхлын үүднээс Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байна.

<sup>71</sup> Тухайлбал, ТбРНӨтХ §34.1-д заасан хувьчлах арга, түүнийг тодорхойлохтой холбоотой асуудалд захиргааны байгууллагад сонгох боломж олгосон байна. Үүнд, нийтийн ашиг сонирхлын үүднээс маргаан үүсгэх боломжгүй.

<sup>72</sup> Үндсэндээ төрийн өмчийн хөрөнгийн ангилалтай яв цав адил.

Орон нутгийн өмчид 1/ энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1-4, 6 дахь заалт, 6.2, 6.3 дахь хэсэгт заасан хэлбэрээр бий болсон эд хөрөнгө<sup>73</sup>; 2/ төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилж шилжүүлсэн эд хөрөнгө; 3/ орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох ашгаар олж авсан эд хөрөнгө; 4/ хуульд заасан бусад үндэслэлээр бий болсон эд хөрөнгө хамаарахаар хуульчилсан байна. Иймд дурдсан эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбоотой асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээлттэй байна гэж үзнэ.

*Нийтийн өмчийн талаар гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт*  
ХБНГУ-ын хувьд манай улс шиг «нийтийн өмч» гэсэн ойлголт байдаггүй бөгөөд харин түүнийг «нийтийн эд юмс» хэмээх ойлголтын хүрээнд авч үздэг байна<sup>74</sup>. Захиргааны байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд хүний нөөцөөс гадна тодорхой эд зүйлийг ашиглах нь зөвшөөрөгдөнө гэж үздэг бөгөөд тэрхүү эд юмс нь гагцхүү нийтийн зориулалттайгаар ашиглагдах боломжтой байдаг байна<sup>75</sup>. Үүгээрээ хувийн өмчийн хөрөнгөөс ялгагдана. Тухайлбал, нийтийн эд юмст захиргааны байгууллагын

<sup>73</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. 6 дугаар зүйл. Төрийн өмчид эд хөрөнгө олж авах

1. Төрийн өмчид эд хөрөнгийг дараах хэлбэрээр олж авна:

1/ энэ хууль хүчин төгөлдөр болох үед төрийн өмчлөлд байсан эд хөрөнгө;

2/ үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө;

3/ эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө;

4/ хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө;

5/ хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу нийгэмчилсэн, дайчлан буюу хураан авсан эд хөрөнгө.

6/ концессын гэрээний дагуу шинээр бий болсон эд хөрөнгө.

2. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

3. Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр төрийн болон орон нутгийн өмчид хамааруулна.

<sup>74</sup> Hans J.Wolff/ Otto Bachof, Verwaltungsrecht I, 9. Auflage, C.H.Beck Verlag, München, 482-523 дахь тал

<sup>75</sup> Hans J.Wolff/ Otto Bachof, Verwaltungsrecht I, 9. Auflage, C.H.Beck Verlag, München, 483 дахь талд

албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өрөө тасалгаа, бичиг хэргийн материал, техник хэрэгсэл, албаны унаа хөсөг, багшийн хувьд сургуулийн өрөө, анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүнүүд, холбоо, муж, коммунуудад хамаарах ой мод, цэцэрлэгт хүрээлэн, усан сан, театр, нийтээр хэрэглэдэг зам, талбай, гудамж, усны шугам гэх мэт зүйлс хамаарна<sup>76</sup>.

Манай улсын хувьд ТбОНӨтХ-ийн дагуу улсын төсвийн хөрөнгө нь нийтийн өмчид тодруулбал, төрийн өөрийн өмчид хамаарах бол ХБНГУ, Австри зэрэг манай оронтой эрх зүйн тогтолцооны хувьд нэг бүлд багтдаг орнуудын үзэл баримтлалаас харвал улсын төсвийн хөрөнгөд хамаарах санхүүгийн хөрөнгийг<sup>77</sup> улсын хөрөнгөд хамааруулдаг боловч нийтийн эд юмст багтаан авч үздэггүй байна<sup>78</sup>. Өөрөөр хэлбэл, улсын төсвийн санхүүгийн хөрөнгөд хамаарах асуудлыг нийтийн өмчийн асуудал гэж үздэггүй байна. Учир нь, санхүүгийн хөрөнгө нь нийтийн зориулалтад шууд хамаардаггүй бөгөөд нийтийн зорилгод шууд үйлчилдэггүй, харин хөрөнгийн үнэ цэнэ, ашиг орлогын тусламжтайгаар төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад гарсан зардлыг нөхөх зорилготой байдаг тул нийтийн эд юмст хамааруулдаггүй байна<sup>79</sup>.

Дээрх ойлголт, үзэл баримтлал нь эдийн засгийн болон хууль зүйн шинжлэх ухааны хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, үндэслэл бүхий ойлголт байх тул улсын төсвийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбоотой ямар ч асуудлаар нийтийн ашиг сонирхлын өмнөөс захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой хэмээн ойлгох нь явцуу ойлголт байж болох юм.

ХБНГУ-ын Иргэний кодексын 90 дүгээр зүйлд заасан эд хөрөнгөөс гадна эдийн бус хөрөнгө жишээлбэл, агаар, эрчим хүч, задгай нуур тэнгис далай гэх мэт зүйлс нийтийн эд юмст хамаарах бөгөөд нийтийн эд юмсыг дараах хэд хэдэн бүлэгт ангилдаг байна. Үүнд:

<sup>76</sup> Hans J. Wolff/ Otto Bachof, *Verwaltungsrecht I*, 9. Auflage, C.H.Beck Verlag, München, 484-485 дахь тал

<sup>77</sup> Санхүүгийн хөрөнгө гэдэгт бизнесийн үйл ажиллагаанаас олсон хөрөнгө, хөрөнгийн зах зээлээс босгосон хөрөнгө, шаардах эрх, ногдол ашиг, алтны худалдаанаас олсон ашиг, үнэт цаас гэх мэт хамаарна.

<sup>78</sup> Paul Laband, *Das Staatsrecht des Deutschen Reiches*, Band II, 1891, S. 854 f.

<sup>79</sup> Мөн тэнд

- 1/ Иргэд нийтээр ашигладаг нийтийн эд юмс:
  - а/ Коммунд ашигладаг нийтийн эд юмс - нийтийн зам, талбай гэх мэт
  - б/ Тусгай хэрэгцээнд ашигладаг нийтийн эд юмс - нийтийн усан сан гэх мэт
  - в/ Албан газрын хэрэгцээнд ашигладаг нийтийн эд юмс - нийтийн захиргааны байгууллагад харьяалуулсан эд хөрөнгө гэх мэт
- 2/ Захиргааны байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашигладаг нийтийн эд юмс - албан хаагчийн үзэг, өрөө тасалгаа, бичиг хэргийн материал, албаны унаа гэх мэт.
- 3/ Сүм хийдийн зүгээс нийтийн хэрэгцээнд ашигладаг эд юмс - сүмийн хонх гэх мэт<sup>80</sup>.

#### **3.4. Хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд нэхэмжлэл гаргах**

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах тусгайлан эрх олгогдсон этгээдэд ЗХШХШТХ-ийн §18.3.1, §18.3.2-т заасан «нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх», «дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх» шаардлага тавигдахгүй бөгөөд тухайн хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно гэсэн үг.

Бусад салбарын хуулийн зохицуулалтаас үзэхэд иргэний нийгмийн буюу төрийн бус байгууллага төдийгүй хувь иргэн, цаашлаад захиргааны байгууллагад өөрийн хувийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамааралгүй асуудлаар нэхэмжлэл гаргах эрхийг олгосон байна. Үүнийг доорх хүснэгтэд харуулбал:

<sup>80</sup> Creifelds Rechtswörterbuch, ...

№	Субъект	Хамаарах асуудал	Хуулийн заалт
1.	Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн	Хүний эрх, эрх чөлөө	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль §17.1. Комиссын гишүүн гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: §17.1.1. аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах;
2.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	Өрсөлдөөн	Өрсөлдөөний тухай хууль §15.1. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар чиг үүргийнхээ дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: §15.1.7. өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчиж гаргасан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг холбогдох дээд байгууллага, албан тушаалтан, захиргааны хэргийн шүүхэд гаргаж шийдвэрлүүлэх;
3.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	Хэрэглэгчийн эрх	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль §16.1. Төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхтэй: §16.1.7. хэрэглэгчийн эрхийг ноцтой хохироосон тухай үндэслэл бүхий албан ёсны шаардлага хүлээн авсан боловч арга хэмжээ аваагүй албан тушаалтанд зохих арга хэмжээ ногдуулах тухай саналыг холбогдох хяналтын байгууллагад тавих буюу шүүхэд нэхэмжлэл гаргах.
4.	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, баг, сум, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан	Хүүхдийн эрх	Хүүхдийн эрхийн тухай хууль §19.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, баг, сум, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан нь хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд хүсэлт, шаардлага гаргаж болно.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

5. Иргэн	Байгаль орчин	<p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль 4 дүгээр зүйлийн 1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараах эрхийг эдэлнэ:</p> <p>§2/ ...байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;</p>
6. Сум, дүүргийн Засаг дарга	Байгаль орчин	<p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль 17 дугаар зүйлийн 2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>§8/ байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах;</p> <p>§9/ энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх;</p>
7. Төрийн бус байгууллага, Байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл	Байгаль орчин	<p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль 32 дугаар зүйлийн 1. Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:</p> <p>§1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;</p>
8. Төрийн бус байгууллага	Байгаль орчин (Ой)	<p>Ойн тухай хууль</p> <p>§25.1. Ойн баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу ойг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг явуулж болно:</p> <p>§25.1.1. Ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;</p>



9.	Сав газрын захиргаа	Байгаль орчин (Ус)	<p>Усны тухай хууль</p> <p>§17.1. Сав газрын захиргаа нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг тухайн сав газартаа хэрэгжүүлнэ:</p> <p>§17.1.9. Ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;</p>
10.	Оюуны өмчийн улсын хяналтын алба, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	Зар сурталчилгаа	<p>Зар сурталчилгааны тухай хууль.</p> <p>§24.3. Оюуны өмчийн улсын хяналтын алба, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>§24.3.5. Зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргах;</p>
11.	Прокурор	Хязгаарлалт байхгүй	<p>Прокурорын тухай хууль.</p> <p>§20.1. Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно.</p>

Салбарын хуулиудад дээрх байдлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг тусгайлан олгосон нь ЗХШХШтХ-д тодорхойлсноор нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх агуулгатай нэхэмжлэл гаргах эрх олгогдсон гэж үзэхээр байна. Гэхдээ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хуулиар төрийн бус байгууллагад, Усны тухай хуулиар Сав газрын захиргаанд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх олгогдсон ч уг эрх нь «хохирлыг нөхөн төлүүлэх, барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах» хэмээн явцуу хүрээнд олгогдсоноос үзвэл тухайн төрийн бус байгууллага, Сав газрын захиргаа нь захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлын талаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байх бөгөөд харин төрийн бус байгууллага нь бусад

асуудлаар (үүнээс өөр нэхэмжлэл гаргах тохиолдолд) захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд ЗХШХШТХ-ийн §18.3-т заасан шаардлага тавигдахаар байна.

**Тохиолдол-10:** *«Хөвсгөл нутгаа хамгаалъя» ТББ-аас байгаль орчныг хамгаалах асуудлаар Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг шүүх уг ТББ нь 2016 онд байгуулагдсан тул хуулийн шаардлага хангахгүй байна гэж үзэн нэхэмжлэлийн хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ<sup>81</sup>.*

### **3.5. Байгаль орчныг хамгаалах асуудлаар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон Засаг дарга нэхэмжлэл гаргах нь**

Одоогийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг тусгайлан олгосон зохицуулалт байхгүй байна. Харин Байгаль орчныг хамгаалах тухай хууль (БОХТХ)-ийн §17.2.9-д зааснаар сум, дүүргийн Засаг даргад «байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргээ хэрэгжүүлэх хүрээнд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх тусгайлан олгогдсон байна.

Иймд юуны түрүүнд «байгалийн нөөц» гэсэн ойлголтыг авч үзэх нь зүйтэй. Монгол Улсын хууль тогтоомжид «байгалийн нөөц» гэсэн ойлголтыг тайлбарласан тодорхойлолт байхгүй ч шинжлэх ухааны тогтсон тайлбараар бол «байгалийн нөөц» гэдэг нь хүний гараар бүтээгдээгүй, байгальд байдаг, хүмүүсийн оршин тогтнох хэрэгсэл юм. Байгалийн нөөцийг хам бүрдлээр нь «ойн, усны, амьтны, газрын, уур амьсгалын, ургамлын, хөрсний, эрдсийн, эрчим хүчний» зэргээр, хэрэглэгдэх байдлаар нь шавхагдах нөөц, үл шавхагдах нөөц гэж ангилдаг байна. Шавхагдах нөөцийг нөхөн сэргээгдэхгүй (дахин бий болохгүй ба бий болохдоо хүний ашиглах хурдаас удаан бий болдог газрын хэвлийн баялаг буюу бүх төрлийн ашигт малтмал), нөхөн сэргээгдэх (ургамал, амьтны, хөрсний

<sup>81</sup> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1353 дугаар захирамж.

г.м) ангилдаг. Мөн байгалийн нөөц нь гэсэн үг нь «байгалийн баялаг», «байгалийн нөөцийн баялаг» гэсэн үгнүүдтэй ижил утгаар хэрэглэгддэг байна.

БОХТХ-ийн §3.2.7-д «байгаль орчныг хамгаалах» гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна» гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолтод буй «байгалийн баялаг» гэсэн ойлголт нь «байгалийн нөөц» гэсэн ойлголтыг илэрхийлж байна.

Дээрхээс үзэхэд байгалийн нөөцийг хамгаалах үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны салшгүй хэсэг байх тул БОХТХ-ийн §17.2.9-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргад байгаль орчныг хамгаалах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх тусгайлан олгогдсон гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

**Тохиолдол-11:** *Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг дарга болон бусад нэр бүхий иргэд хамтран Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргад холбогдуулан «хариуцагчийн 2010 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 930 дугаар шийдвэр, түүнийг үндэслэн олгосон МҮ-015651 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл, 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 294 дүгээр шийдвэр, МҮ-020624 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг илт хууль бус болохыг тогтоолгох» шаардлага бүхий нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн үндэслэлээ «Ашигт малтмалын газар 2010 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14, 11.1.16, 25.1.7-д заасныг зөрчсөн. Нутгийн иргэд, оршин суугчид өөрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлэхэд оролцох ганц боломжид нь халдаж олборлох эрх олгохдоо хуульд үндэслээгүй. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14, 11.1.15-д заасан чиг үүргийг огт хэрэгжүүлээгүй. Гол, мөрний*

*урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг болон дагаж мөрдөх журмын тухай хуулийг бүхэлд нь зөрчсөн. Тусгай зөвшөөрөлтэй талбайн багахан хэсгийг буцааж өгсөн нь дахин өөр тусгай зөвшөөрөл үүсгэх үндэслэл болохгүй, ямар нэгэн шийдвэргүйгээр шинэ тусгай зөвшөөрөл бий болгох нь Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, 11.1.16, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4.2 дахь заалтыг зөрчсөн» гэж тайлбарлажээ.*

Анхан болон давж заалдах шатны шүүх Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргад Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах түүний баялгийг зохистой ашиглах, биелэлтэд хяналт тавих, 2.4-д сумын Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бүрэн эрхтэй» гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авч, улмаар нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ. Улсын дээд шүүх «Анхан болон давж заалдах шатны шүүхүүд Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгаль орчныг хамгаалах талаар бүрэн эрхийг тодорхойлсон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1, Сум, дүүргийн Засаг даргын байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлын хүрээнд бүрэн эрхийг нь тодорхойлсон мөн зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарыг дээрх асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй гэж дүгнэсэн нь буруу байна. Учир нь, байгаль орчныг хамгаалах талаар тухайн албан тушаалтнуудын бүрэн эрхийг нь тодорхойлсон дээрх хуулийн зохицуулалтыг шүүхэд төлөөлөн нэхэмжлэлийг гаргах үндэслэл болгосон нь Захиргааны

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан «...хуульд заасан бол захиргааны байгууллагаас ...», 3 дугаар зүйлийн 3.1.3-д «нэхэмжлэл гэж... тусгайлан заасан бол...захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдож үүссэн маргааны шийдвэрлүүлэхээр» гэж заасантай тус тус нийцэхгүй болно» гэж дүгнэн Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна<sup>82</sup>.

Дээрх тохиолдлоос үзэхэд Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг дарга нь «нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн буюу байгаль орчныг хамгаалах» агуулгаар нэхэмжлэл гаргасан гэж үзэхээр байна. БОХТХ-ийн §17.2.9-д заасны дагуу сумын Засаг даргад байгалийн нөөцийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл эрх тусгайлан олгогдсон байхад анхан болон давж заалдах шатны шүүх сумын Засаг даргад шүүхэд нэхэмжлэл гаргах эрх олгогдсон хуулийн заалтыг зөв зааж хэрэглээгүй боловч нэхэмжлэлийг хүлээн авч, шийдвэрлэсэн, хяналтын шатны шүүх сумын Засаг даргад шүүхэд нэхэмжлэл гаргах хуулиар тусгайлан олгогдоогүй, улмаар сумын Засаг даргын нэхэмжлэлийг «нийтийн эрх зүйн чиг үүрэгтэйгээр холбогдуулан гаргасан нэхэмжлэл» гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

### **3.6. Нийтийн өмчийг хамгаалах асуудлаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэхэмжлэл гаргах нь**

ТбОНӨТХ-ийн §77.1-д «Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна», Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн<sup>83</sup> §18.1.3.а-д зааснаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь «орон нутгийн өмчийн зүйлсийн

<sup>82</sup> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.06.07, №448, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, 2017.10.04, №221/МА2017/0710, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2017.12.18, №532 <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3758/view>

<sup>83</sup> <http://legalinfo.mn/law/details/343?lawid=343>

өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ» гэж тус тус заасан байна.

Өмчлөх эрхэд тухайн хөрөнгийг «эзэмших, ашиглах, захиран зарцуулах» эрх багтдаг бөгөөд өмчлөгч нь өмчөө аливаа халдлагаас хамгаалах, өмчлөх эрх нь ямар нэгэн байдлаар зөрчигдсөн гэж үзвэл уг зөрчлийг арилгуулах, эсхүл өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байгаа үйлдлийг зогсоохыг эрх зөрчигчөөс шаардах эрхтэй байдаг<sup>84</sup>. Иймд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өөрийн өмчлөлдөө буй нийтийн өмчтэй холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд үүнийг субьектив эрхийн маргаан гэж үзэх үү? эсхүл объектив эрх зүйн буюу нийтийн ашиг сонирхлын маргаан гэж үзэх үү? гэсэн асуулт үүсэж байна.

Хэрэв өмчлөгч гэсэн шууд утгаар нь авч үзвэл уг маргаан нь субьектив эрхийн маргаан болно. Гэхдээ хувийн хөрөнгийн өмчлөгчөөс ялгаатай нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь өмчлөх эрхээ нийтийн буюу тухайн орон нутгийнхаа хүн амын тусын тулд хэрэгжүүлэх учиртай. Иймд уг асуудлыг эх үндсээр нь авч үзвэл уг маргаан нь нийтийн ашиг сонирхол буюу нийтийн өмчийг хамгаалах агуулгатай нэхэмжлэл байж болохоор байна. Энэ тохиолдолд Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нийтийн өмчийн өмчлөгчийн хувиар өмчөө хамгаалах, өмчлөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж үзэхээс өөр аргагүй бөгөөд үүнийг нийтийн ашиг сонирхлын маргаанд хамааруулах нь зүйтэй.

**Тохиолдол-12:** *Хөвсгөл аймгийн Түнэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд холбогдуулан «Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах» шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргахдаа нэхэмжлэлийн үндэслэлээ «Түнэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн*

<sup>84</sup> Иргэний хуулийн 101, 106 дугаар зүйлийг үзнэ үү.

26 дугаар тогтоол хүчинтэй байхад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 104 дүгээр тогтоол гарч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын «Ж», 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн Түнэл-Илч орон нутгийн өмчит үйлдвэрийг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож, компанийн дүрмийг хавсралтаар батлан компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 2017 оны 01 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулахыг үүрэг болгож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 99 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтуудыг зөрчиж байна. Түнэл сумын уурын зуух 1980-аад оны сүүлээр ашиглалтад орсон боловч 1990-ээд оны эхэн үеэс үйл ажиллагаа нь зогссон. 2007 онд шугам сүлжээ, уурын зуухаа сэргээн ашиглалтад оруулснаар үйл ажиллагаагаа дахин явуулж эхлээд 10 жил болж байгаа. Энэ хугацаанд өөрсдийн ашгаар нэхэмжлэлд дурдагдсан нийтийн үйлчилгээний олон ажлуудыг хавсарч хийж явсан. Цэвэр усаар хангах, хог цэвэрлэгээ, сумын төвийн гэрэлтүүлэг, ахуйн үйлчилгээ, халуун усны үйлчилгээ зэргийг явуулж байсан. Түнэл сумын дэд станц, халаалтын зуухыг хүлээж авах комиссыг 1994 онд байгуулж, эзэнтэй болгож тухайн үед сумын Засаг даргын захирамж гаргаад хариуцуулаад явж байсан. УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолын хавсралтад уурын зуух нь сумын өмч биш аймгийн өмч гэж тусгайлан заасан зүйл байхгүй» гэж тайлбарлажээ.

Дээрх тохиолдолд Хөвсгөл аймгийн Түнэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн буюу тухайн орон нутгийн нийтийн өмчийн өмчлөгчийн хувьд «нийтийн өмч»-ийг хамгаалах, өмчлөх

эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гаргасан нэхэмжлэл гэж үзэж болохоор байна. Харин давж заалдах шатны шүүх «захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх»-тэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл гэж үзэн ИНХ-д нэхэмжлэл гаргах эрх хуулиар тусгайлан олгогдоогүй гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсаныг хяналтын шатны шүүх хэвээр үлдээж шийдвэрлэжээ<sup>85</sup>.

### **3.7. Прокурор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох асуудал**

Өмнө нь үйлчилж байсан буюу 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн §55.1-д «Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцох бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргана» гэж заасан байсан. Харин Улсын Их Хурлаас ЗХШХШТХ-ийг батлахдаа прокурорыг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн ЗХХША-д оролцох талаар ямар нэгэн зохицуулалтыг оруулаагүй байна. Энэ нь тус хуулиар нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах эрхийг нээсэнтэй холбоотой болов уу.

Харин УИХ-аас 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Прокурорын тухай хууль (ПтХ)-ийн шинэчилсэн найруулгыг батлахдаа тус хуулийн §20.1-д «Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно» гэж заасан.

**Тохиолдол-13:** *«Эс Си Интернэшнл» ХХК, «Тэнүүн зоргол» ХХК, «Фалько экологи» ХХК, «Альянс минерал» ХХК-ийн*

<sup>85</sup> Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.05.30, №00015, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, 2017.08.30, №0626, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2017.11.21, №478, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1651/view>



*нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох захиргааны хэрэгт Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга нэр бүхий прокурорыг томилон Прокурорын тухай хуулийн §20.1-д заасны дагуу уг захиргааны хэрэгт прокурор оролцуулах тухай» хүсэлт гаргасныг шүүх бүрэлдэхүүн хэлэлцээд захиргааны хэргийн шүүхийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг бүхэлд нь журамлан зохицуулсан шинэчлэн найруулагдаж, хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж буй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах зохицуулалтгүй байна» гэсэн үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон байна<sup>86</sup>.*

Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүх ЗХШХШТХ-ийн зохицуулалтын хүрээнд прокурор ЗХХША-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гуравдагч этгээдээр оролцох боломжгүй гэж үзсэн байна. Харин дээрх тохиолдлыг шийдвэрлэсэн шүүхийн тогтоолын үндэслэл хэсгээс үзвэл «Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлага хангасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн хувьд «хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах» асуудлаар прокурор нэхэмжлэгчээр оролцохоор нэхэмжлэл гаргаагүй» талаар тэмдэглэжээ.

ПтХ-ийн §20.1-д «зохигч» гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Гэтэл «зохигч» гэсэн нэр томъёо нь иргэний процессын эрх зүйд хэрэглэгддэг ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §26.1-д «Хэргийн зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд хамаарна» гэж заасан. Харин ЗХШХШТХ-д «зохигч» гэсэн нэр томъёог хэрэглээгүй байна. Өөрөөр хэлбэл, прокурор ЗХШХШТХ-ийн §18.3-т «хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд» нэхэмжлэл гаргаж болно гэж заасны

<sup>86</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 08 өдрийн 221/ШТ2017/0788 дугаар тогтоол.

дагуу ПтХ-ийн §20.1-д заасныг үндэслэл болгон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж боломжтой эсэх нь тодорхой бус байна.

Прокурорын үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, хүний хувь заяатай салшгүй холбоотой байдаг. Иймд судлаачдын үзэж байгаагаар прокурор нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах болон зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх (ялангуяа хохирогчийн эрхийн асуудал), гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байх нь зүйтэй гэж үзэж байна.

#### **4. Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа**

##### **4.1. Нийтийн ашиг сонирхлын маргааныг хянан шийдвэрлэсэн байдал**

Төрийн бус байгууллагууд ЗХШХШТХ хэрэгжиж эхэлснээс хойш нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн 17 нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхэд гаргасан байна.

	<b>Шүүх</b>	<b>Тоо</b>
1.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	14
2.	Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1
3.	Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1
4.	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1
	<b>Нийт</b>	<b>17</b>

Захиргааны хэргийн шүүх дээрх 17 нэхэмжлэлээс 5-ыг хүлээн авахаас татгалзаж, 1-ийг бүрдүүлбэр хангуулж ирүүлээгүй үндэслэлээр буцааж, 11 нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэсэн байна. Захиргааны хэрэг үүсгэсэн 11 хэргийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа-4, шийдвэрлэгдсэн-7 хэрэг байна.





График 1-ээс харахад, төрийн бус байгууллагуудаас байгаль орчныг хамгаалах асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах явдал бусад салбартай харьцуулахад харьцангуй их байна. Энэ нь нийтийн эрүүл мэнд ялангуяа нийтийн өмчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага төдийлөн олон биш байгаатай холбоотой болов уу.


Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан үндэслэлүүдийг судлан үзэхэд захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус-1, тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус-1, нэхэмжлэгч төрийн бус байгууллага нь ЗХШХШТХ-ийн §18.3-т заасан шаардлагыг хангаагүй-3 тус тус байна.

**График 2. ТББ-уудаас нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэлийг хүлээн авсан байдал**



- Нэхэмжлэлийг хүлээн авсан
- Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан
- Нэхэмжлэлийг буцаасан

**График 3. Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэсэн байдал**



- Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан
- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан
- Дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн
- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн

Шүүхээр шийдвэрлэгдсэн 7 хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан-1, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан-2, дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн-1, хялбаршуулсан

журмаар шийдвэрлэгдсэн-3 тус тус байна. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн 3 хэргийн хувд эвлэрсэн-1, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн-2 байна. Одоогийн байдлаар шүүхээс төрийн бус байгууллагуудаас нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тохиолдол гараагүй байна.

Харин нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага нь хариуцагч захиргааны байгууллагын чиг үүрэгтэй хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй, нэхэмжлэлийн шаардлага тодорхой бус байхад хэргийг шийдвэрлэсэн гэсэн үндэслэлээр дээд шатны болон анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан тохиолдол гарч байна. Энэ нь төрийн бус байгууллага нь анхнаасаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаг алдалгүй, нэг мөр шийдвэрлүүлэх үүднээс нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлээ зөв тодорхойлох шаардлагатай байгааг харуулж байна.

#### **4.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлжүүлэлт, түүний үр дагавар нийтийн ашиг сонирхлын маргаантай холбогдох нь**

Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй холбоотой ЗХШХШТХ-д дараах байдлаар тусгажээ. Үүнийг өмнөх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалттай харьцуулан авч үзье.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль §3.1.7. (2002 он)	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль §3.1.3. (2016 он)
«нэхэмжлэл» гэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актыг улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг хэлнэ.	«нэхэмжлэл» гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг хэлнэ.

Дээрхээс үзэхэд өнгөрсөн хугацаанд үйлчилж байсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэн, хуулийн этгээд зөвхөн өөрийнх нь субъектив эрх захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагаанаас шууд шалтгаалан зөрчигдсөн гэж үзвэл тэрхүү зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр захиргааны хэргийн шүүхэд хандах шаардлага тавигддаг байсан<sup>87</sup>-ыг харж болно. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаан дахь Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаанд *objective* буюу ерөнхий эсхүл *subjective* буюу тодорхой эрхийн зөрчлөөс үл хамааран нэхэмжлэгчид субъектив эрхийн зөрчил үүссэн байх шаардлага тавьж ирсэн нь онол, практикийн хувьд зөрчил, маргаан үүсгэх эх үүсвэр болж байсан<sup>88</sup>. Гэхдээ заримдаа нэхэмжлэгчийн эрхийн зөрчлийг биш хуулийн зөрчлийг үндэслэн<sup>89</sup>, түүнчлэн хуульд тусгайлан заасан этгээд нэхэмжлэл гаргасан тохиолдолд хуулийн зөрчлийг биш эрхийн зөрчлийг үндэслэн<sup>90</sup> шийдвэрлэдэг ойлгомжгүй тохиолдлууд шүүхийн практикт гардаг байсан.

Тэгвэл ЗХШХШТХ-иар Захиргааны акт (захиргааны гэрээ, хэм хэмжээний акт)-тай холбоотой маргаан буюу тодорхой субъектийн эрхийн зөрчлөөс үүдсэн маргааныг (1) Хянан шийдвэрлэх ажиллагаа-наас гадна, объектив эрх зүйн (нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх, хуулиар тусгайлан маргах эрх олгогдсон этгээд, түүнчлэн захиргаа хоорондын нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн) маргааныг (2) Хянан шийдвэрлэх ажиллагааг төрөлжүүлэн зохицуулсан байна<sup>91</sup>.

<sup>87</sup> Ц.Цогт «Захиргааны хэргийн шүүх-хүний эрх» Хүний эрх сэтгүүл, УБ., 2005 №4, 23 дахь тал.

<sup>88</sup> Ц.Цогт «Захиргааны эрх зүйн өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл» УБ., 2016, 36 дахь тал.

<sup>89</sup> Г.Банзрагч «Монгол Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухайд» Шүүх эрх мэдэл сэтгүүл УБ., 2016 №1, 119 дэх тал

<sup>90</sup> Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015.09.30-ны өдрийн 220 дугаар тогтоол. 2015 онд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар Төрийн өмчийн хороонд холбогдуулан «Төрийн өмчийн хороог Улсын циркийн хувьчлалыг хэлэлцүүлэх зорилгоор хуралдуулахыг, хувьчлалыг хүчингүй болгох тухай шийдвэр гаргахыг тус тус Төрийн өмчийн хороонд даалгах тухай» шаардлага бүхий нэхэмжлэл гаргасныг хяналтын шатны шүүх Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хуулиар тусгайлан олгогдсон атал нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нэг үндэслэлээ Төрийн өмчийн хорооны шийдвэрийн улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй» гэж тайлбарлажээ. <http://shine.shuukh.mn/zahirgaahyanalt/90/view>

<sup>91</sup> Ц.Цогт «Захиргааны эрх зүйн өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл» УБ., 2016, 35 дахь тал.

Объектив буюу захиргааны шийдвэрийн үйлчлэл тодорхой субъектийн эрхийн зөрчил үүсгэсэн эсэхээс үл хамааран хуулиар маргах эрх олгогдсон этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй тохиолдолд шүүх тэрхүү этгээд тухайн асуудлаар «маргах, шаардах эрхтэй» эсэхийг субъектив хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны адил судалж, шалгах шаардлагагүй, уг маргааныг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд хэн нэгэн этгээдийн эрх ашиг сэргэсэн, хамгаалагдсан байх биш, харин захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн зөрчил арилсан байх явдал байдаг<sup>92</sup>. Өөрөөр хэлбэл, нийтийн ашиг сонирхлын маргааны хувьд нэхэмжлэгчийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн эсэхийг шүүх дүгнэх, улмаар энэ (субъектив эрх нь зөрчигдөөгүй) үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхгүй.

**Тохиолдол-14:** *Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар «Журам боловсруулж танилцуулах тухай» 10 дугаар тогтоолыг гаргасан бөгөөд, уг тогтоолоор «Архидан согтуурч нийгмийн хэв журам алдагдуулсны улмаас захиргааны журмаар баривчлагдсан болон саатуулагдсан иргэдийг орон нутгийн иргэдийн тусын тулд хөлсгүйгээр хөдөлмөр эрхлүүлэх тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор удаа дараа архидан согтуурч, баривчлагдан саатуулагдсан төрийн албан хаагчийг албан үүргээс нь чөлөөлөх тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, малчид мал бүхий иргэдийн эрхийг хамгаалах, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд малын хулгайчдыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд таниулах тухай журмуудыг тус тус хуульд нийцүүлэн мэргэжлийн байгууллага Прокурор, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран боловсруулж, 2016 оны 02 дугаар*

<sup>92</sup> Мөн тэнд 35-37 дахь тал.

сарын 20-ны өдрөөс өмнө аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг даргад даалгасан» байна.

Дээрх тогтоолыг хүчингүй болгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд 24 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ<sup>93</sup>. Ингэхдээ шүүх «Захиргааны хэргийн шүүх нь хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны акттай холбогдуулан хэрэг үүсгэн, нэхэмжлэгчийн тодорхой эрхэд шууд хамааралтай эсэхийг шалгаж, тухайн шийдвэрийн улмаас субъектив эрх нь хөндөгдсөн иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд, ирээдүйд ямар акт гарахыг урьдчилан дүгнэлт хийх боломжгүй юм. Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 20- ны өдрийн «Журам боловсруулах тухай» 10 дугаар тогтоол нь нийтийн эрх зүйн хүрээнд тодорхой нэг тохиолдлыг зохицуулаагүй, эрх зүйн үр дагавар шууд бий болгоогүй, дээрх актын улмаас нэхэмжлэгчийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй байна» гэж дүгнэжээ.

Хэдийгээр шүүхийн Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 20- ны өдрийн «Журам боловсруулах тухай» 10 дугаар тогтоол нь захиргааны акт биш гэсэн дүгнэлт нь үндэслэлтэй байж болох боловч үүний улмаас нэхэмжлэгчийн өөрийнх нь субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй гэж дүгнэсэн буруу байна.

**Тохиолдол-15:** «Өвчтөн, нийгмийн төлөөллийн зөвлөл» ТББ нь Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар,

<sup>93</sup> <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/1457/view>



*Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлд холбогдох захиргааны хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхдээ «Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5.1-д заасны дагуу нэхэмжлэгч буюу «Өвчтөн, нийгмийн төлөөллийн зөвлөл» НҮТББ-ын эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, тэрхүү зөрчигдсөн эрхээ шүүхээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлд заасан аль шийдвэрийг гаргуулж, хэрхэн сэргээлгэх гэж байгааг тодруулах», хяналтын шатны шүүх «тухайн тохиолдолд, захиргааны байгууллага тус бүр ямар хууль бус үйл ажиллагаа явуулсан, үүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн талаар үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй» зэргээр анхан шатны шүүхийн шийдвэрийг буруутгасан байна<sup>94</sup>.*

Дээрх тохиолдлуудаас үзэхэд энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхдээ шүүхээс нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт хийж маргааныг шийдвэрлэсэн, мөн дээд шатны шүүх нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт хийгээгүй, зөрчигдсөн эсэх нь тодорхойгүй зэргээр доод шатны шүүхийг буруутгасан байгааг цаашид анхаарах шаардлагатай.

### **4.3. Зөрчигдөж болзошгүй нийтийн ашиг сонирхлыг хамгаалах**

2002 оны ЗХХШтХ-иар зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлын талаар шүүхэд хэрхэн мэдүүлэх нь тодорхой хуульчлагдаагүй<sup>95</sup> байсан бол одоогийн ЗХШХШтХ-иар захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн тогтоох бус «зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхол»-ыг хамгаалахад чиглэгдэхээр зохицуулагдсан.

<sup>94</sup> <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/787/view>

<sup>95</sup> Ц.Цогт «Байгаль орчныг хамгаалах асуудалд захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо <http://legaldata.mn/buteel/pdf?id=141>

ЗХШХШТХ-ийн §106.3.10-т «Захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох» гэж заасан бөгөөд уг хэм хэмжээний дагуу захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн төдийгүй, зөрчигдөж болзошгүй байвал шүүх уг захиргааны шийдвэрийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох боломжтой байна. Иймд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд нь нийтийн ашиг сонирхлыг зөрчигдсөний дараа сэргээн тогтоохоор нэхэмжлэл гаргахаас илүүтэй, зөрчигдөж болзошгүй байвал урьдчилан сэргийлж хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргах нь илүү ач холбогдолтой юм.

#### **4.4. Шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа тооцох асуудал**

ЗХШХШТХ-ийн §14.5-д «Захиргааны байгууллагын гаргасан захиргааны акт, байгуулсан захиргааны гэрээ илт хууль бус болох, эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох болон захиргааны хэм хэмжээний акттай холбоотой нэхэмжлэлд хөөн хэлэлцэх хамаарахгүй» гэж заасан. Өөрөөр хэлбэл, захиргааны илт хууль бус акт, гэрээ болон захиргааны хэм хэмжээний актын улмаас нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн бол нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд нь хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүйгээр нэхэмжлэл гаргах боломжтой байна.

Харин эрх зүйн зөрчилтэй захиргааны акт, эсхүл захиргааны гэрээний улмаас нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн бол хөөн хэлэлцэх хугацааг хамаарахгүйгээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээд нь нэхэмжлэл гаргаж болох талаар заагаагүй байна. Хэрэв энэ тохиолдолд ялгаагүй хөөн хэлэлцэх хугацааг тооцно гэж үзвэл нэхэмжлэгчийг уг эрх зүйн зөрчилтэй захиргааны акт, гэрээг хэзээ мэдсэн гэдгийг тогтооход түвэгтэй болно. Учир нь захиргааны байгууллага захиргааны актыг зөвхөн харьяалагдсан этгээд болон уг актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдэд мэдэгдэх үүрэгтэй, мөн захиргааны гэрээг тодорхой этгээдтэй байгуулдаг бөгөөд энэ талаар бусад иргэн, аж

ахуйн нэгжид тухайлан мэдэгдэх үүрэггүй байдаг.

Мөн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээд нь нэгээр тогтохгүй олон байх боломжтой тул нэхэмжлэгчийг хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг өөр бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээдээс гаргасан нэхэмжлэл дээр адилтган хэрэглэж болох уу? гэсэн асуудал үүснэ. Нөгөөтэйгүүр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээд нь эрх зүйн зөрчилтэй захиргааны акт, гэрээний хувьд ч ялгаагүй хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзвэл урьдчилан шийдвэрлэх ажиллагааны ач холбогдлыг алдагдуулах, мөн захиргааны үйл ажиллагааг хууль ёсны гэдэгт итгэн үйл ажиллагаагаа явуулж байгаа иргэдийн итгэлд сөргөөр нөлөөлөхийг анхаарах шаардлагатай. Одоогийн байдлаар шүүхийн практикт нийтийн ашиг сонирхлын маргаан дээр хөөн хэлэлцэх хугацааны асуудал дээр маргаантай байдал гараагүй ч цаашид хөөн хэлэлцэх хугацааны асуудал маргаантай ойлгомжгүй байдал үүсгэж магадгүй юм.

#### **4.5. Нэхэмжлэгчийн эрхэд тавигдах хязгаарлалт**

ЗХШХШтХ-ийн §20.3-т «Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно» гэж заасан. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчмаас гажсан зохицуулалт ч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хувийн ашиг сонирхлыг нийтийг ашиг сонирхлоос дээгүүр тавих эрхгүй гэсэн үзэл санаанаас үүдэлтэй. Нөгөө талаас, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээдээр дамжуулан шүүхийг ямар нэгэн ашиг сонирхлын талбар болгохоос сэргийлэх, шүүхэд зохиомол ачаалал бий болгохгүй байх үүднээс авч үзвэл ийнхүү хязгаарлалт тавьсан нь ач холбогдолтой юм<sup>96</sup>.

<sup>96</sup> ЗХШХШтХ-ийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед уг хуулийн төслийг хэлэлцүүлэх ажлын хэсгийн дарга «Нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргаж тоглох эрх төрийн бус байгууллагуудад байхгүй ээ. Нэхэмжлэл гаргасан бол гаргасан

#### **4.6. Захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийг субъектив эрхийн зөрчлөөс үүссэн нэхэмжлэлээс зааглах нь**

Захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэл бүрийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэл гэж шууд үзэх нь учир дутагдалтай. Тухайлбал, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн хүний эрх, чөлөө зөрчигдсөн ямар ч асуудал (нэг хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн болон хүний эрх, эрх чөлөө нийтлэг байдлаар зөрчигдсөн)-аар шүүхэд нэхэмжлэл гаргах, Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчиж гаргасан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын ямар ч шийдвэр (тодорхой этгээд рүү чиглэсэн болон нийтлэг хэм хэмжээ тогтоосон)-ийг хүчингүй болгуулахаар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, баг, сум, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтанд хүүхдийн эрх зөрчигдсөн ямар ч асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хуулиар олгогдсон мэт харагдаж байна.

Хэдийгээр захиргааны байгууллагад шүүхэд нэхэмжлэл гаргах эрх тусгайлан олгогдсон ч захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа тодорхой этгээд рүү хаяглагдсан, эсхүл тодорхой этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн тохиолдолд тухайн этгээд нь шүүхэд нэхэмжлэл гаргаагүй байхад «хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд» нь захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах, улмаар шүүх уг нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах нь «субъектив эрхийн маргаан»-ыг шийдвэрлэх ажиллагааны зорилготой нийцэх эсэхийг анхаарах шаардлагатай. Харин «хүүхдийн эрх»-ийн асуудлын хувьд хүүхэд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

---

шиг гаргаад явах хэрэгтэй. Нэхэмжлэл гаргаад дараа нь хариуцагчтай тохироод нэхэмжлэлээсээ татгалздаг явдал сүүлийн жилүүдэд ихэссэн байгаа. Зүгээр л мөнгөний төлөө нэхэмжлэл гаргадаг. Явцуу эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргадаг. Яг нийтийн эрх ашгийн төлөө явах гэж байгаа бол явсан шиг яв. Энд цаана нь олон хүний бүхэл бүтэн ард түмний эрх ашиг байгаа юм. Энэ бол хувийн эрх ашгийн асуудал биш гэдэг үүднээс энэ заалтыг оруулж өгсөн гэж ойлгож манай ажлын хэсгийнхэн нэгдсэн» гэж тайлбарлаж байжээ.

боломжгүй байдаг тул тухайн хүүхдийн эрхийг хамгаалахаар хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд нь нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзэх нь зүйтэй болов уу.

**4.7. Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэлээс ялгах нь**

**Тохиолдол-16:** Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн нэхэмжлэлтэй, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд холбогдох «Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 31 тоот «Усны үнэ тогтоох тухай» тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгуулах тухай» шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргажээ. Нэхэмжлэгч нэхэмжлэлийн үндэслэлээ «...тус зөвлөл нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д «цэвэр бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах нийтлэх» гэж заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2014 оны 57 тоот тогтоолоор Дундговь аймгийн «Дундговь ус» ОНӨААТҮГ-ын хүн ам, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, суурь хураамжийг баталсан бөгөөд Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дээр дурдсан тариф суурь хураамжийг 2017.06.30-ны өдрийн 80 тоот тогтоолоор шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2017.07.21-ний 3755 дугаарт бүртгүүлээд байна. Энэхүү тогтоолыг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.14-т «Зохицуулах зөвлөлийн шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгч дагаж мөрдөнө» гэж заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан суманд үйл ажиллагаагаа явуулж буй хангагч аж ахуйн нэгж болох ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ

эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч «Дундговь Ус» ОНӨААТҮГ болон нийт хэрэглэгчид болох хүн ам, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага дагаж мөрдөх ёстой. «Дундговь Ус» ОНӨААТҮГ-ын 2017.06.02-ны өдрийн 93 тоот «Санал хүргүүлэх тухай» албан бичгийн дагуу тус Зохицуулах зөвлөлийн 2017.06.08-ны 01/214 тоот албан бичгээр Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг зөрчиж, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэтрүүлэн гаргасан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 31 дүгээр тогтоолоо хүчингүй болгож, 2017.07.08-ны дотор хариу мэдэгдэхийг шаардсан. Гэвч Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд ямар нэгэн шийдвэр гаргаагүй бөгөөд одоог хүртэл уг тогтоолоо хүчингүй болгоогүй байна. Иймд Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 31 тоот «Усны үнэ тогтоох тухай» тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгож өгнө үү» гэж тайлбарлажээ. Улмаар хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч тогтоолоо хүчингүй болгосон байна<sup>97</sup>.

Захиргааны байгууллагаас нэхэмжлэл гаргахдаа ЗХШХШТХ-ийн §52.5.4-т заасан «захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэлийн хувьд ямар хууль зөрчигдсөн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн» гэсэн үндэслэлээр гаргасан нэхэмжлэл үү? эсхүл §52.5.5-т заасан «нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж

<sup>97</sup> Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн «Хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай» шийдвэр, 2018.02.07, №01 <http://new.shuukh.mn/zahirgaanhan/4342/view>

болзошгүй» гэсэн үндэслэлээр гаргасан нэхэмжлэл гаргаж байна уу? гэдгээ тодорхой зааж маргах, нөгөө талаас шүүх ч нэхэмжлэлийн төрлийг зөв тодорхойлох шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагаас нийтийн ашиг сонирхлыг хамгаалах агуулгатайгаар гаргасан нэхэмжлэлийг шүүх тодруулалгүйгээр өөрийн чиг үүрэгтэйгээ холбогдуулан гаргасан нэхэмжлэл гэж тодорхойлж шийдвэрлэж байгаа тохиолдол шүүхийн практикт гарч байна.

**Тохиолдол-17:** *Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын 4, 5-р багийн Иргэдийн Нийтийн Хурал, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Бүрэнхаан багийн Иргэдийн Нийтийн Хурлаас Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний хөгжлийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан эдгээр байгууллагаас гаргасан тодорхой шийдвэрүүдийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн үндэслэлээ «уурхайн ашиглалтын болон хайгуулын лицензүүдийг хууль зөрчин олгож, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, нутгийн иргэдээр хэлэлцүүлээгүй, тус бүс нутгийн олон мянган жил хуралдан тогтсон мөнх цэвдэг хайлж, гадаргын болон гүний усны баланс алдагдаж, ширгэж үгүй болох эрсдэлтэй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүйгээр, тусгай зөвшөөрөл авсан эсэх нь тодорхойгүй компанитай концессын гэрээ хийгдэж төмөр зам баригдсанаар иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах, гадаргын усны урсац, булаг шанд, нууруудын цутгал голуудад сөргөөр нөлөөлөх, ан амьтны шилжилт хөдөлгөөн, үржлийг хаах, нүүдлийн зүйл усны шувууд амьтдыг үргээх, дайжаах гэх мэт байдлаар байгаль орчин, эх орноо хамгаалах эрх ашгийг зөрчихөөр байна» гэх зэргээр тайлбарлажээ. Үүнээс үзэхэд уг нэхэмжлэл нь «нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн буюу байгаль орчин»-ыг хамгаалахтай холбоотой нэхэмжлэл байхад шүүх «захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх»-тэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл гэж үзэн Иргэдийн Нийтийн Хуралд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх*



хуулиар тусгайлан олгогдоогүй гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ<sup>98</sup>.

**Тохиолдол-18:** Дээр дурдсан Хөвсгөл аймгийн Түнэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд холбогдуулан «Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах» шаардлага бүхий нэхэмжлэлийн үндэслэл нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн өмчийг өмчлөгчийн хувьд «нийтийн өмч»-ийг хамгаалахтай холбоотойгоор гаргасан нэхэмжлэл байхад давж заалдах шатны шүүх «захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх»-тэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл гэж үзэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хуулиар тусгайлан олгогдоогүй гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсаныг хяналтын шатны шүүх хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

**Тохиолдол-19:** Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг дарга болон бусад нэр бүхий иргэд хамтран Ашигт малтмалын газрын Геологи уул уурхайн кадастрын хэлтсийн даргад холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн үндэслэл нь «нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн буюу байгаль орчныг хамгаалах» агуулгатай байхад анхан болон давж заалдах шатны шүүх Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргыг нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзсэн атал мөн л уг нэхэмжлэл нь ЗХШХШтХ-ийн §52.5.4 эсхүл §52.5.5-т заасан нэхэмжлэл үү гэдгийг тодорхойлж дүгнээгүй<sup>99</sup>. Улмаар хяналтын шатны шүүх

<sup>98</sup> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, 2017.08.04, №4937

<sup>99</sup> Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоож шийдвэрлэхдээ ЗХШХШтХ-ийн §106.3.2 (захиргааны акт, захиргааны гэрээ нь илт хууль бус болохыг тогтоох)-г заасан шүүхээс гаргах шийдвэрийн төрлийг сонгосон байх бөгөөд давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн энэ хэсэгт өөрчлөлт оруулаагүйгээс үзвэл шүүх уг маргааныг бүхэлд нь нийтийн ашиг сонирхлын маргаан гэж үзээгүйг харуулж байна. Учир нь шүүх



*уг нэхэмжлэлийг «нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан» гаргасан нэхэмжлэл гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.*

Эхний тохиолдолд дурдсан Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн нэхэмжлэл нь ЗХШХШТХ-ийн §52.5.4-т заасан нийтийн эрх зүйн чиг үүрэгтэйгээ холбогдуулж гаргасан нэхэмжлэл байна. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь нэхэмжлэлээсээ бүрэн буюу хэсэгчлэн татгалзах эрхгүй бол захиргааны байгууллага өөрийн чиг үүрэгтэйгээ холбогдуулан гаргасан нэхэмжлэлээсээ хэдийд ч татгалзах эрхтэй байдгаараа энэ хоёр маргаан ялгаатай бөгөөд онцлогтой. Энэ нь цаашид захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагаас нэхэмжлэл гаргахдаа нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар эсхүл өөрийн чиг үүрэгтэйгээ холбогдуулан нэхэмжлэл гаргаж байна уу? гэдгээ тодорхой заасан эсэхийг нягтлан шалгаж, анхнаасаа нэхэмжлэлийн төрлийг зөв тодорхойлох шаардлагатайг харуулж байна.

## **5. Дүгнэлт, зөвлөмж**

### **5.1. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох хүрээнд**

1. «Нийтийн ашиг сонирхол» гэдгийг тодорхойлох урьдчилсан нөхцөлийг тодорхой нэг тохиолдолд хууль тогтоогчоос тогтоосон хуулийн агуулга, зорилгыг цогцоор нь тайлбарлах замаар шүүхээс тогтооно. Ингэхдээ юуны өмнө, нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлын эсрэг тодорхойлох буюу нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тухай ойлголт болохын зэрэгцээ нийтийн байх шинж чанар нь агуулгын болоод тооны бүрдүүлбэртэй, гэхдээ тооны бүрдүүлбэрийг ердийн арифметик

---

энэ тохиолдолд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргаас гаргасан нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэл гэж үзэж, улмаар захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоох шийдвэрийг гаргах тохиолдолд ЗХШХШТХ-ийн §106.3.10 (захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох)-ыг баримтлах учиртай.

тоогоор тооцох боломж байдаггүй байна.

2. «Нийтийн ашиг сонирхол», «нийтийн сайн сайхан» хэмээх ойлголтууд нь агуулгын хувьд зарчмын томоохон зөрүүгүй байх ба хэрэглээний түвшинд хувийн өмчийг хураан авах шаардлагатай тохиолдолд түүнийг үндэслэдэг нийтийн ашиг сонирхлыг нийтийн сайн сайхан хэмээн нэрлэдэг байна

3. Нийтийн ашиг сонирхлын либерал концепци дэлхий нийтийн олонх хүлээн зөвшөөрсөн чиг хандлага биш байна хэмээн дүгнэж болохоор байна. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээдэд нийгэмлэг буюу холбоодыг хамааруулан тооцож, хуулиар тэдэнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах эрхийг олгож байгаа манай улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §18.3-т заасан зохицуулалт нь ардчилсан-плюралист концепцийн агуулгад хамаарч байна. Мөн хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар зохицуулсан нь төр төвтэй нийтийн ашиг сонирхлын концепцийн агуулгад хамаарч байна.

4. Монгол Улсын Үндсэн хуульд «нийтийн ашиг сонирхол» гэх ойлголт хэрэглэгдээгүй ч «хүн амын эрүүл мэндийн ашиг сонирхол», «байгаль хамгааллын ашиг сонирхол», «үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол», «нийгмийн ашиг сонирхол», «хувь хүний ашиг сонирхол», «гэр бүлийн ашиг сонирхол», «эх нялхсын ашиг сонирхол», «хүүхдийн ашиг сонирхол», «хууль ёсны ашиг сонирхол», «нийт иргэн, улсын ашиг сонирхол», «төрийн ашиг сонирхол» зэрэг ойлголтуудыг хэрэглэсэн нийтийн ашиг сонирхол гэх ойлголтыг илэрхийлж, түүнд дүйж байна.

5. Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд «нийтийн ашиг сонирхол» хэмээх ойлголтыг оруулсан боловч агуулгыг нь тайлбарлаагүй байна. Ийнхүү тайлбарлахгүй байх үндэслэл, шалтгаан нь «нийтийн ашиг сонирхол» гэдэг нь хуулиар шууд тодорхойлон заах боломжгүй ойлголт учраас хууль тогтоогч шууд болон тодорхой тайлбар хийхээс татгалзаж, нээлттэй орхисон гэж үзэхээр байна.

## **5.2. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалтын хүрээнд**

1. Захиргааны хэргийн шүүх нь дээд шатны захиргаа биш буюу, уг шүүхийн зорилго нь захиргааг хянах бус харин захиргааны хууль бус үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтоох явдал байдаг тул хувь этгээдийн өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбогдолгүйгээр үүсэж явагддаг нийтийн ашиг сонирхлын маргааныг хэт нээлттэй биш, хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрдөг байна.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §18.3-т буй «хүрээлэн байгаа орчин» гэх ойлголт нь үг зүйн хувьд «байгаль орчин» гэх ойлголтоос илүү өргөн хүрээтэй ойлголт байх боловч уг хуулийг батлахад хууль тогтоогч «хүрээлэн байгаа орчин» гэдгийг «байгаль орчин» гэсэн ойлголттой адилхан утгаар ойлгож байсан байна.

3. Манай улсын эрүүл мэндийн тухай хууль тогтоомжид туссан «нийгмийн эрүүл мэнд» гэсэн ойлголт нь «нийтийн эрүүл мэнд» гэх ойлголтыг илэрхийлж байна.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан төрийн нийтийн зориулалттай өмчид хамаарч байгаа иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, түүний доторх баялаг, ой, түүний дагалдах баялаг, ургамал, ан амьтны нөөц нь «байгаль орчин» гэх ойлголттой давхцаж байна. Иймд шүүхийн практикт хүрээлэн буй сав шим ертөнц буюу хүний гараар бүтээгдээгүй, аяндаа бий болсон зүйл (чулуун мандал, усан мандал, агаар мандал, шим мандал)-ийг «байгаль орчин» гэсэн ойлголтод хамааруулж, харин хүний гараар бүтээгдсэн нийтээр ашиглах зориулалттай, тодруулбал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан хөрөнгө, эд юмсыг «нийтийн өмч» гэх ойлголтод хамааруулж хэрэглэхийг зөвлөмж болгож байна.

5. ХБНГУ, Австри зэрэг манай оронтой эрх зүйн тогтолцооны хувьд нэг бүлд багтдаг орнуудын үзэл баримтлалаас харвал, улсын төсвийн хөрөнгөд хамаарах санхүүгийн хөрөнгийг улсын хөрөнгөд

хамааруулдаг боловч нийтийн эд юмст багтаан авч үздэггүй байна. Харин манай улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар улсын төсвийн хөрөнгө нь нийтийн өмчид тодруулбал, төрийн өөрийн өмчид хамаарч байгаа боловч улсын төсвийн хөрөнгө бүхэлдээ нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргах нэхэмжлэлийн шаардлагад хамаарах уу? гэдэг асуудлыг цаашид тодорхой болгох шаардлагатай байна.

6. Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх тусгайлан олгогдоогүй ч уг байгууллага нь тухайн орон нутгийнхаа нийтийн өмчийн «өмчлөгчийн хувьд» өмчлөх эрхээ хэрэгжүүлэх буюу «нийтийн өмчийг хамгаалах» тэгэхдээ зөвхөн өөрийн өмчлөлд байгаа хөрөнгөтэй холбоотой асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж үзэхээр байна.

7. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хуулиар төрийн бус байгууллагад, Усны тухай хуулиар Сав газрын захиргаанд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх олгогдсон ч уг эрх нь «хохирлыг нөхөн төлүүлэх, барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах» хэмээн явцуу хүрээнд олгогдсон байна. Иймд цаашид эдгээр хуулиудад зөвхөн үр дагавар буюу хохирлын асуудлаар бус нийтийн ашиг сонирхлыг зөрчигдсөнийг сэргээх, зөрчигдөж болзошгүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байхаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвлөмж болгож байна.

8. Байгалийн нөөцийг хамгаалах үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны салшгүй хэсэг байх тул Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн §17.2.9-д зааснаар сум, дүүргийн Засаг даргад тухайн орон нутгийнхаа байгаль орчныг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрх тусгайлан олгогдсон гэж үзэхээр байна.

9. Прокурор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гуравдагч этгээдээр оролцох боломжгүй, харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах асуудал тодорхой бус байна. Иймд Прокурорын тухай хуульд «прокурор хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн

шүүхэд нэхэмжлэл гаргах эрх»-ийг олгох нь зүйтэй бөгөөд энэ нь прокурорын чиг үүрэгтэй бүрэн нийцэхээр байна.

### **5.3. Нийтийн ашиг сонирхлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд**

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар субъектив эрхийн зөрчлөөс үүдсэн маргаанаас гадна, тодорхой субъектийн эрхийн зөрчлөөс хамааралгүйгээр үүсдэг объектив эрх зүйн маргааныг төрөлжүүлэн зохицуулсан бөгөөд нийтийн ашиг сонирхлын маргаан нь объектив эрх зүйн маргаанд хамаарч байна.

2. Захиргааны хэргийн шүүх объектив эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгчийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн байхыг шалгах, улмаар энэ талаар дүгнэлт өгөх шаардлагагүй байдаг ч шүүхийн практикт ийнхүү дүгнэлт өгч хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдол гарч байна. Иймд цаашид захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаанд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэлээр үүссэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, онцлог, нэхэмжлэгчид тавигдах нөхцөл, шаардлага, уг маргааныг шийдвэрлэхэд шүүхээс тавих хяналтын цар хүрээг зөв тодорхойлж хэвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §18.3.2-т заасан «дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх» шаардлагыг захиргааны хэргийн шүүхүүд нэг мөр, нэгдсэн ойлголттойгоор хэрэглэж хэвших нь зөв гэж үзэж байна.

4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээгээд зогсохгүй, зөвхөн нийтийн ашиг сонирхол зөрчигдсөний дараа бус нийтийн ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй тохиолдолд нэхэмжлэл гаргах эрхийг нээсэн нь ач холбогдолтой байна.

5. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах сонирхолтой байгууллагууд олон байдаг тул эрх зүйн зөрчилтэй захиргааны актын улмаас нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн

тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх тодорхой, нэгэн ижил түвшинд зохицуулах нь захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, иргэний итгэлийг хамгаалахад тус дөхөмтэй болох тул нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй этгээд нь эрх зүйн зөрчилтэй захиргааны акт батлагдсан, захиргааны гэрээ байгуулснаас хойш 1 жилийн дотор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвлөмж болгож байна.

6. «Хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд»-ээс гаргаж байгаа нэхэмжлэлийг «субъектив эрх»-ийн зөрчлөөс үүсэх нэхэмжлэлээс зааглан авч үзэх асуудлыг цаашид анхаарах шаардлагатай. Харин «хүүхдийн эрх»-ийн асуудлын хувьд уг асуудлыг ялгамжтайгаар авч үзэх нь зүйтэй байна.

7. Хуулиар тусгайлан эрх олгогдсоны дагуу захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэл нь өөрийн чиг үүрэгтэйгээ холбогдуулж гаргасан нэхэмжлэл байж болохоос гадна нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр нэхэмжлэл гаргасан байж болохоор байна. Иймд захиргааны байгууллагаас нэхэмжлэл гаргахдаа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §52.5.4-т заасан «захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэлийн хувьд ямар хууль зөрчигдсөн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн» гэсэн үндэслэлээр гаргасан нэхэмжлэл үү? эсхүл §52.5.5-т заасан «нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй» гэсэн үндэслэлээр гаргасан нэхэмжлэл үү? гэдгийг тодорхой зааж маргах, нөгөө талаас шүүх нэхэмжлэлийн төрлийг зөв тодорхойлж, шүүхийн практикт хэвшүүлэх шаардлагатай байна.

## **ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХҮҮХДИЙН ЭРХ, АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛСАН БАЙДАЛ**

*Д.Эрдэнэчимэг (Хууль зүйн магистр)  
М.Сувд (Хууль зүйн ухааны доктор)  
М.Ариунаа (Хууль зүйн магистр)*

### **Удиртгал**

Сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал болон нийгмийн хөгжлийн бусад хүчин зүйлийн нөлөөллөөр гэрлэгчдийн боловсролын ялгаа, хамтын амьдралын явцад бэрхшээлийг даван туулах сэтгэл зүйн бэлэн байдал, гэр бүлийн өмч, хөрөнгө санхүүгийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, цалин орлого, амьдралын баталгаа, шилжилт хөдөлгөөн, гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт зэргээс шалтгаалан гэр бүл цуцлах явдал нэмэгджээ. Үүнтэй холбоотойгоор гэрлэгчдийн дунд эд хөрөнгийн маргаан үүсэн шүүхэд хандан шийдвэрлүүлэх явдал мөн өссөн байна. Энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хэрхэн хамгаалж байгааг хяналтын шатны шүүхийн шийдвэрт хууль зүйн дүн шинжилгээ хийх замаар судлан шинжлэхийг зорилоо.

2017 оны эхний хагас жилд иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 2402 буюу 9.8 хувийг эзэлж байна. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэрлэлт цуцлах маргаан 247 хэргээр буюу 20.7 хувиар, эцэг тогтоох хэрэг 32 хэргээр буюу 16.7 хувиар, эцэг, эх байх эрх хасах хэрэг 5 хэргээр буюу 62 хувиар, хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан 223 хэрэг буюу 58 хувиар тус

тус өсжээ. Эндээс гэр бүлийн эрх зүйн маргаан, тэр дундаа гэрлэлт цуцлахтай холбоотой шийдвэрлэсэн хэргийг судлах, ийнхүү судлахдаа хүүхдийн өмчлөх эрх болон бусад эрхийг шүүхээс хууль зүйн үндэслэлтэйгээр шийдвэрлэж буй эсэхэд дүн шинжилгээ хийх хэрэгцээ, шаардлага, ач холбогдол өсөж байна.

Уг судалгаагаар 2012-2018 онд улсын хэмжээнд шийдвэрлэсэн иргэний эрх зүйн маргааны зарим төрөл болох гэрлэлт цуцлах, хүүхдийн тэтгэлэг, асрамж тогтоолгох, гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгийг хуваах, эцэг тогтоолгох, эцэг, эх байх эрхийг хасахтай холбоотой маргааныг шийдвэрлэсэн нийт 150 орчим хэргийн 80 шийдвэр, магадлал, тогтоолд дүн шинжилгээ хийсэн болно.

Гэр бүлийн эрх зүйн хүрээнд гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоох зэрэг маргааныг шүүхээс хянан шийдвэрлэх явцад хүүхдийн эрхийг хэрхэн хангадаг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргадаг хууль хэрэглээний нийтлэг алдааг тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ, санал, зөвлөмж дэвшүүлээ.

## **1. Судалгааны арга зүй, судалгааны түүвэр**

### **1.1. Судалгааны зүйл, арга зүй**

Судалгаагаар гэр бүлийн хэрэг маргааныг анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг судалгааны объект болгон бодит байдал дээр хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэж, гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа, үүссэн үйл баримтаас (факт) эрх зүйн үйл баримтыг хэрхэн ялган салгаж байгаа, хуулийн зүйл заалт болон онолыг хэрхэн бүрэн дүүрэн ашиглаж байгаа болон бодитой, зүй зохистой үндэслэл бүхий дүгнэлтийг гаргаж байгаа эсэхийг үнэлэх зорилго тавьж ажиллалаа.

Судалгааны зорилгын хүрээнд:

- Гэрлэлт цуцлах;
- Хүүхдийн тэтгэлэг тогтоолгох;
- Хүүхдийн асрамж тогтоолгох;
- Эцэг тогтоох;



- Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийг хуваах;
- Эцэг, эх байх эрхийг хасах

гэж бүлэглэн хууль хэрэглээ, хууль тайлбарлах явцад илэрсэн алдаа, зөрчлийн талаар нэгтгэн дурдаж, гэр бүлийн эрх зүйн онол үзэл баримтлалын асуудлыг хөндөн цаашид шүүгч нарын зайлшгүй анхаарвал зохих асуудлыг тодорхойлох, шүүхийн шийдвэрийг судалгааны эргэлтэд оруулах зорилт тавьсан болно.

Судалгааны арга зүйн хувьд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргын хүрээнд холбогдох шүүхийн шийдвэрийг нийслэл, орон нутгаар нь ангилж тус бүр тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо. Шүүхийн шийдвэрийг хууль хэрэглээний хувьд хууль зүйн үндэслэлтэй, шударга ёс, процессын болон материаллаг эрх зүйн зарчим, хэм хэмжээнд нийцсэн агуулга, хэлбэртэй байлгах, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцүүлэх үүднээс дүн шинжилгээ хийлээ.

Шийдвэрийг түүвэрлэх явцад зохигчдын нууцтай холбоотойгоор шүүхээс гаргаж буй шийдвэр, магадлал, тогтоол цахимаар нийтэд нээлттэй биш байсан тул Монгол Улсын Дээд шүүхэд шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолтой танилцах хүсэлт гаргахад Шүүхийн Ерөнхий зөвлөлд хандах зөвлөгөө өгсөн. Харин Шүүхийн Ерөнхий зөвлөлд хандахад хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг өгөх боломжгүй гэсэн хариулт өгсөн болно. Иймд судалгааны хамрах хүрээг өргөтгөж, цаг хугацааны хувьд 2012 оноос хойш шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолуудыг [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтаас түүвэрлэн сонголоо.

Гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах болон хяналтын шатны магадлал, тогтоолын хамт түүвэрлэн дараах асуудлаар асуулга, удирдамж боловсруулан процессын зөрчил болон хууль хэрэглээний нийтлэг алдаа, зөрчлийг илрүүлж, дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хангаж чадсан эсэх, хүүхдээс мэдүүлэг авахдаа хүүхдийн эрхтэй холбоотой гаргаж буй нийтлэг зөрчлүүд;
2. Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан эвлэрүүлэх арга хэмжээг авахдаа гаргасан нийтлэг алдаа;


## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

3. Гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн талаарх Иргэний хуулийн 126, 127 дугаар зүйлийг хэрэглэхдээ хүүхдийн өмчлөх эрхийг хангасан эсэх;
4. Гэрлэлт цуцлах маргааныг шийдвэрлэхдээ Хүүхдийн эрхийг хамгаалах конвенц, хүүхдийн эрхийг хамгаалах хуулийг шүүхийн шийдвэрт үндэслэдэг эсэх;
5. Гэрлэлтээ цуцлуулаад тусдаа амьдарч байгаа эцэг, эхтэй нь уулзуулах асуудлыг шийдвэрлэж буй практик;
6. Хүүхдийн тэтгэлгийн асуудлыг шийдвэрлэсэн шийдвэрийн хууль зүйн үндэслэл болон хууль хэрэглээний нийтлэг алдаа;
7. Хүүхдийн эрхийг зөрчдөг, гэр бүлийн хүчирхийлэлд байдаг хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасаж шийдвэрлэхдээ хууль хэрэглээний болон хүүхдийн эрхийн зөрчил гаргадаг эсэх зэрэг болно.

### 1.2. Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргааны төрөл, тоон үзүүлэлт

2017 оны байдлаар иргэний хэргийн анхан шатны шүүхэд Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4566 буюу 10.1 хувийг эзэлжээ. Хянан шийдвэрлэсэн хэрэг маргаанаас Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 108 хэргээр буюу 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 1. Шийдвэрлэсэн хэрэг (хуулиар)<sup>100</sup>



Эх сурвалж: Монгол Улсын шүүхийн тайлан, 2017

<sup>100</sup> Шүүхийн Ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан (2017) дэлгэрэнгүйг <http://www.judcouncil.mn/main/7022--2017.html>-ээс харна уу.

**Хүснэгт 1. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн төрөл<sup>101</sup>**

№	Маргааны төрөл	Он		Өөрчлөлт	
		2016	2017	Тоо	хувь
1	Эцэг эх байх эрх хасах	17	24	+7	41.5
2	Эцэг тогтоох	450	467	+17	3.8
3	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	1006	1056	+50	5
4	Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах	47	50	+3	6.4
5	Гэрлэлт цуцлах	2602	2791	-189	6.3

Эх сурвалж: Монгол улсын шүүхийн тайлан, 2017

Хүснэгт 1-ээс харахад зөвхөн 2017 онд Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэргээс эцэг тогтоолгох болон хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргүүд энэ төрлийн бусад хэргээс 9-44 хувиар олон байна. Түүнчлэн шийдвэрлэсэн хэргийн дотор гэрлэлт цуцлуулахтай холбоотой хэрэг хамгийн олон буюу 2791 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 189 хэргээр буюу 6.3 хувиар өсжээ. Харин 2017 оны Хяналтын шатанд Гэр бүлийн тухай хуулиар 47 хэргийг хянан шийдвэрлэжээ<sup>102</sup>.

Нийт түүвэрлэсэн хэргүүдээс харахад гэр бүл цуцлах асуудлыг тэтгэлэг гаргуулах, хүүхдийн асрамж тогтоолгох маргаантай хамтатган шийдвэрлэх, хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан нь эцэг тогтоолгох маргаантай хамтатган шийдвэрлэх явдал нийтлэг байна.

<sup>101</sup> Шүүхийн Ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан (2017) дэлгэрэнгүйг <http://www.judcouncil.mn/main/7022--2017.html> ээс харна уу

<sup>102</sup> Монгол Улсын Дээд шүүхийн тайлан, 2017. Дэлгэрэнгүйг [http://www.supremecourt.mn/uploads/files/5a40bfa41325a\\_2017.12.23.pdf](http://www.supremecourt.mn/uploads/files/5a40bfa41325a_2017.12.23.pdf) аас харна уу.

## **2. Шүүхийн шийдвэрийн агуулга, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ**

*Нэг. Шүүхийн шийдвэрийн агуулгын шинжилгээ*

### **2.1.1. Гэрлэлт цуцалсан шийдвэрийн дүн шинжилгээ**

Гэрлэлт цуцлах болсон шалтгаан нөхцөлд юу хамаарах талаар Гэр бүлийн тухай хуульд тусгайлан заагаагүй боловч шүүх гэрлэлт цуцлуулахаар гаргасан нэхэмжлэлийн шаардлага дахь гэрлэгчдээс гэр бүлийн харилцаагаа цаашид хэвийн үргэлжлэх боломжгүйд хүргэсэн объектив болон субъектив нөхцөл байдлыг тогтоож улмаар гэрлэгчид болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгод нийцүүлж шийдвэрлэнэ. Шүүх гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хүлээн авч хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтооно.

---

Гэрлэлт цуцлах болсон дараах нийтлэг шалтгаанууд нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн хариу тайлбар, шүүхийн шийдвэрт дурдагдсан байна. Үүнд: гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, хонуут өнжүүтээр ирдэггүй учир хамт амьдрах итгэлгүй болсон, гэр бүлээс гадуур харилцаа тогтоосон, гадаадад болон дотоодод удаан хугацаагаар хол байж ажиллаж амьдардаг болон гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн буюу зан харилцааны хувьд хоорондоо таарамжгүй зэрэг шалтгаануудыг дурдаж болохоор байна.

---

Гэрлэлт цуцлах хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад гэрлэгсдийг эвлэрүүлэх арга хэмжээ авна. Энэ нь гэрлэгч тус бүртэй ганцаарчлан уулзах, зөвлөгөө өгөх, гэрлэлт цуцлуулах болсон шалтгааныг нарийвчлан судалж, үндэслэлтэй эсэхийг тогтоох, гэрлэлт цуцлуулснаас үүсэх эрх зүйн үр дагавар, хүүхдийн эрх ашиг, хүмүүжилд муугаар нөлөөлөх байдлуудыг таниулан ойлгуулах, шаардлагатай тохиолдолд сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгчдийг татан оролцуулах зэрэг гэрлэгчдийг эвлэрүүлэхэд чиглэсэн бүхий л ажиллагаа багтана.

Гэрлэгчид эвлэрэх боломжгүй гэж шүүх үзсэн бол эвлэрүүлэх хугацаа өгөхгүйгээр гэрлэлтийг цуцалж болохоор Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.-т заажээ. «Гэрлэгчид эвлэрэх боломжгүй» гэдэгт цаашид хамтран амьдрах бодит нөхцөл байхгүй болохыг ойлгоно. Уг ойлголтод хэн нэг нь согтуурах болон мансуурах бодис байнга хэрэглэдэг, бэлгийн харьцаа тохирохгүй байх, гэр бүлийн гишүүдийг өөрийн эрхшээлд байлгахаар хүч хэрэглэж, биед нь халдах, айлгах, сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөж мөшгөх, гэр бүлийн дундын өмчийг дангаар захиран зарцуулах зэргээр сэтгэл санаа, бие махбодь, эдийн засгийн байнгын хүчирхийлэл, дарамт үзүүлснээр гэр бүлийн бусад гишүүн, ялангуяа хүүхдэд ноцтой хор хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй байхыг хамааруулна.

---

Судалгаанд хамрагдсан шүүхийн шийдвэрүүдэд анализ хийж үзэхэд гэр бүл цуцлах болсон шалтгаан нь гэр бүлийн доторх бие махбодийн хүчирхийлэл, хардалт, зодуур, сүрдүүлэг байгаа тохиолдолд талуудыг эвлэрүүлж шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байна.

---

Гэрлэгчдийн хэн нэг нь эсхүл хоёулаа бусадтай гэр бүлийн харилцаатай болсон байх нь тэдний хоорондоо эвлэрэх боломжийг багасгаж байгаа хэдий ч бүрэн үгүйсгэх үндэслэл болохгүй байгаа нь шүүхийн шийдвэрүүдээс харагдаж байна. Гэрлэгчдийн хэн нэг нь өөр хүнтэй гэр бүлийн харилцаатай болсон байдлыг шүүхүүд гэрлэлтийг шууд цуцлах үндэслэл болгодоггүй алдаатай практик нь бүртгүүлсэн гэр бүлийн нэр хүнд, ач холбогдлыг бууруулаад зогсохгүй гэрлэлтээ цуцлуулаагүй атлаа өөр бусадтай гэр бүлийн харилцаанд орох дутагдлыг өөгшүүлэх хортой үр дагавар үүсгэж буйг анхаарах нь зүйтэй.

---

Гэр бүлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвдсөн тохиолдолд гэрлэлт цуцлахыг хориглосон байдаг ч үүнийг зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдол байна. Жишээ нь: гэрлэгчдийн нэг нь өвчтэй байхад, хүүхэд нэг нас хүрээгүй байхад гэрлэлтийг цуцалсан алдаатай шийдвэр гарсан байна.

---

## **2.1.2. Хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоосон шийдвэрийн шинжилгээ**

Гэр бүл бол хүүхэд амьдрах, хөгжих, төлөвших анхдагч орчин байдаг. Тиймээс хүүхэд хамгааллын асуудлыг гэр бүлийн орчин, эцэг эхийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн бусад гишүүний оролцооноос салган үзэх боломжгүй билээ. Түүнчлэн хүүхэд гэр бүлдээ, эцэг эх, гэр бүлийн бусад гишүүнтэй хамт байх нь тэдний эрх ашигт дээд зэргээр нийцдэг. Иймээс хүүхэд хамгааллын бодлого, стратеги нь хүүхдийг гэр бүлд нь, боломжгүй тохиолдолд түүнийг эцэг эхийн хэнийх нь асрамжид үлдээх талаар шүүх үндэслэл бүхий шийдвэр гаргах нь чухал юм.

Нөгөө талаар, хүүхэд нь гэр бүлийн эрх зүйн харилцааны бие даасан субъект учир тухайн маргааныг хянан шийдвэрлэх гол нөхцөл нь хүүхдийн өөрийнх нь эрх ашиг болно. Шүүх гэрлэлтийг цуцалж гэрлэлтийн харилцааг дуусгавар болгохтой зэрэгцэн эрх зүйн өөр харилцаа шинээр үүсдэг. Тухайлбал, хүүхдийн асрамж, тэтгэлэг буюу асран хамгаалалт, харгалзан дэмжих, тэжээн тэтгэх зэрэгтэй холбоотой харилцаа талуудын дунд шинээр үүсдэг болно.

Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.-т зааснаар эцэг, эх нь хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх, үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох, хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслахаас гадна хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэгтэй байна. Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах үед хүүхдийг хэний асрамжид үлдээх талаар гэрээгээр тохиролцож чадаагүй бол шүүх Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7-д зааснаар хүүхдийн нас, эцэг эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг харгалзан асрамжийг тогтоохоор зохицуулсан.

2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн 03 тоот зөвлөмжид бага насны болон насанд хүрээгүй хүүхэд гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийнхээ хэнтэй нь амьдрахыг тогтооход дараах нөхцөл байдал баримтаар тогтоогдсон байх учиртайг дурджээ. Үүнд:

- хүүхэд эцэг, эх, ах, дүү, гэр бүлийн бусад гишүүнд ээнэгшин дассан байдал;
- хүүхдийн нас (хүүхэд насны онцлогоосоо шалтгаалан орчныг болон эцэг, эхийн хоорондын харилцааг зөв хүлээн авч, ойлгон ухамсарлах чадвар, бусдын халамж, үйлчилгээ шаардагдах онцлог);
- эцэг, эхийн ёс суртахууны болон хувийн шинж чанарууд;
- хүүхэд болон эцэг, эхийн хооронд тогтсон харилцаа;
- хүүхэд хүмүүжүүлэх, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломж;
- эцэг, эхийн оршин сууж буй газрын нөхцөл байдал зэрэг болно.

Хүүхэд 7 ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ түүний саналыг харгалзан үзэхээр Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасан байдаг. Энэ нөхцөлд сурган хүмүүжүүлэгч эсвэл сэтгэл зүйч, хүүхдийн байгууллагын төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Харин хүүхдийн гаргаж буй санал нь тухайн хүүхдийн жинхэнэ хүсэл зоригийнх нь илэрхийлэл болж чадаж байгаа эсэхийг шүүхээс онцгой анхаарах ёстой боловч тэр нь хүүхдийн асрамжийг тогтоох шийдвэрлэх цорын ганц үндэслэл болохгүй тул өөр бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж шийдвэрлэнэ.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн гишүүн улсууд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллага, шүүхээс зохих хууль, журмыг үндэслэн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хүүхдийг хүсэл зоригийнх нь эсрэг эцэг эхээс нь салгахгүй байх үүрэг хүлээнэ гэж заажээ. Ийм шийдвэрийг эцэг эх хүүхдэдээ хэрцгийгээр харьцах, анхаарал, халамжгүй орхих, эсхүл эцэг эх нь тусдаа амьдардаг зэрэг тохиолдолд гаргадаг байна. Мөн энэ шийдвэрийг гаргахдаа өөрийн үзэл бодолтой байх насанд хүрсэн хүүхдийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх боломжоор хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодлыг зохих байдлаар харгалзаж үзнэ гэж заажээ.

Судалгаанд хамрагдсан шүүхийн нийт 80 шийдвэр, магадлал, тогтоолын 90 хувьд нь хүүхдийн асрамжийн асуудлыг

шийдвэрлэсэн байна. Эдгээр шийдвэрийн үндэслэх болон тогтоох хэсгийг шинжлэн судлахад шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ хэрэглэвэл зохих хууль тогтоомжийг хэрэглэхгүй байх, эсхүл буруу тайлбарлаж хэрэглэх, хүүхдийн эрх ашгийг гэхээсээ илүү эцэг эх, эмэг эх, өвөг эцгийн саналыг харгалзах, зохигчдын тайлбар, шинжээчийн дүгнэлтийг хэрэгт авагдсан бусад баримттай харьцуулан дүгнэхгүйгээр асрамжийг тогтоох зэрэг нийтлэг алдаа гаргаж байна. Үүнээс гадна хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ хүүхдийн саналыг авдаггүй, авсан ч харгалзаж үзэхгүйгээр шийдвэрлэдэг хандлага цөөнгүй харагдаж байна.

Хэдийгээр хүүхдийн саналыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох талаар хуульд заагаагүй боловч хүүхдийн асрамжийг шийдвэрлэхэд шүүх Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7-д заасан шаардлагыг үндэслэл болгох ёстой. Харин хүүхдийн санал энэ үндэслэлийг тогтооход ач холбогдолтой нотолгооны нэг л хэрэгсэл юм. Тийм ч учраас хүүхдийн саналыг «харгалзана» гэж хуульд заасан байдаг.

Гэр бүлийн тухай хуулийн 14.6-д хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуй нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг хэний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

Хүүхдийн асрамжийг шийдвэрлэх явцад эцэг, эхийн орлогын байдал болон хүүхэд өсөж бойжих орон байрны асуудал чухал үүрэгтэй боловч ёс суртахууны хувьд хүүхдэд сөрөг нөлөөлөх нөхцөл болох эцэг, эхийн хувийн зан чанарыг хөрөнгө, орлогоос илүүтэй харгалзаж үзэх шаардлагатай гэж үзэж байна. Гэтэл дээр дурдсан нөхцөл, байдлыг харгалзахгүйгээр хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэж байгаа нь нийтлэг байна.

---

Жишээ нь: 10 настай хүүхэд «...аав архи уудаг, зоддог, би аавтайгаа байхаас айж байна...» гэсэн тайлбар хэлсээр байтал нөхцөл байдлыг тал бүрээс нь бодитойгоор үнэлж, дүгнэлгүйгээр «...аавын хүчирхийлэлд байдаг гэж нотлогдохгүй байна.» гэсэн үндэслэлээр хүүхдийг эцгийн асрамжид үлдээх шийдвэр гаргасан байна.

---



Хүүхдийн тэтгэлэг тогтоох асуудлын хувьд Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д зааснаар хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг удаа, 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний 50 хувиар, 11-16 нас (суралцаж байгаа бол 18 нас)-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшний хэмжээгээр тус тус олгохоор заасан байдаг. Гэтэл шүүхийн шийдвэрт хүүхэд тус бүрт бус, дунд нь тэтгэлэг тогтоон шийдвэртээ бичсэн нийтлэг алдаа ажиглагдаж байна.

---

Судалгааны явцад хүүхдийн тэтгэлгийн зориулалтыг шүүхийн шийдвэрт дурдаж, зориулалтын дагуу зарцуулахыг эцэг, эхэд үүрэг болгосон шийдвэр хэд хэд байгааг дурдаж, ийнхүү шийдвэрлэж байгааг сайшааж байна. Гэхдээ зориулалтын дагуу зарцуулах үүргийг огт дурдаагүй шийдвэр ч цөөнгүй байна.

---

Гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар эцэг, эх хүүхэд хоорондын харилцаа нь хүүхэд төрснөөр, хүүхдийг үрчлэн авснаар, дагавар хүүхэд, хойт эцэг, хойт эхийн хооронд эцэг, эх хүүхдийн харилцаа үүсдэг хууль зүйн зохицуулалттай боловч дагавар хүүхдэд тэтгэлэг тогтоох асуудлыг орхигдуулан шийдвэрлэж байна.

### **2.1.3. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийг хуваасан шийдвэрийн дүн шинжилгээ**

Гэр бүлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д зааснаар Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг Иргэний хуулиар зохицуулдаг ба Иргэний хуулийн өмчийн харилцааг зохицуулсан Арван хоёрдугаар бүлгийн гуравдугаар дэд бүлэгт гэр бүлийн хөрөнгийн эрхтэй холбоотой зохицуулалтыг тусгажээ.

Иргэний хуулийн 126 дугаар зүйлд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчид ямар хөрөнгө хамаарахыг тодорхойлсон байна. Энэ хөрөнгөд энэ зүйлийн 126.2.5-д заасан буюу онцгой тохиолдолд гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт өмчөө хамтран өмчлөх дундын хөрөнгөд шилжүүлэхээс бусад тохиолдолд

энэ зүйлийн 126.1-126.2.4, 126.3, 126.4-т зааснаар хуулийн дагуу олж авсан байна. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийг хамтран өмчлөгч нь гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн байх бөгөөд гэр бүлийн гишүүн бус гуравдагч этгээд хамтран өмчлөгч байх боломжгүй гэж үзнэ.

Гэр бүлийн гишүүн гэсэн ойлголтыг Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т «Гэр бүлийн гишүүн гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садангийн хүнийг ойлгоно» гэсэн тул Иргэний хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3-т заасан «гэр бүлийн гишүүн» гэдэгт гэрлэгчид, тэдгээрийн төрсөн, дагавар, үрчилсэн хүүхдүүдийг багтаасан бол мөн зүйлийн 129.4-т заасан «гэр бүлийн гишүүн» гэдэгт гэрлэгчид, тэдгээрийн хүүхдүүд орохгүй. Харин гэр бүлийн бусад гишүүн болох төрлийн болон садангийн буюу гэрлэгчдийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ, мөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхэд байж болох юм. Энэхүү зохицуулалт нь хөрөнгө бий болох үед гэрлэгчидтэй байнгын хамтын амьдралтай байсан, улмаар гэр бүлийн дундын хөрөнгийг бий болгоход хувь нэмэр оруулсан этгээд байхыг шаарддаг байна. Ийнхүү гэр бүлийн гишүүдийг зөв тодорхойлсноор хуулийн дээрх зохицуулалтад заасан нөхцөлийг харгалзан, тэдгээрт ногдох хөрөнгийн хэмжээг өөрөөр тогтоох эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно.

---

Гэр бүлийн гишүүний хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүдэд ногдох хэсгийг тодорхойлохдоо дагавар хүүхдийг гэр бүлийн гишүүнээс хасах, гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс түүнд хуваарилахгүй орхих тохиолдол нийтлэг байна.

---

Шүүх энэ асуудлыг шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т «гэр бүлийн гишүүн» гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг» хамруулахаар заасны зэрэгцээ мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т «Дагавар хүүхэд хойд эцэг, хойд эхийн хооронд эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг үүснэ». Мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т «Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн

болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохыг хориглоно» гэсэн зохицуулалтуудыг анхаарч хэрэглэх ёстой.

Гэрлэгчдийг хамтран амьдарснаас хойш, эхнэр, нөхрийн хэн нэг нь гэр бүлийн гишүүнээс өөр этгээдтэй хамтран бий болгосон эд хөрөнгийг гэр бүлийн гишүүдэд хуваах шаардлагыг шүүхэд гаргасан бол зөвхөн тухайн гишүүнд ногдох хэсэгт хамааралтай байж болох юм. Гэхдээ энэ тохиолдолд маргааны зүйл болж буй хөрөнгийг бий болгоход өмчлөгч нараас оруулсан хувь хэмжээг зөв тогтоох нь гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн эрхийг хангах, хамгаалахад чухал ач холбогдолтой.

Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн гишүүнд ногдох дундын хөрөнгийн хэсгийг тодорхойлоход гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс, түүнчлэн дундын хөрөнгөө зүй бусаар ашигласан, нуусан, гэрлэлт цуцалсан нь түүний буруутай үйлдлээс шалтгаалсан нь тогтоогдсон нөхцөлд шүүх Иргэний хуулийн 129.3-т заасны дагуу шийдвэрлэнэ.

Гэрлэгчдийн хэн нэг нь өөрийн хуваарьт хөрөнгийг Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.2.5-д заасны дагуу хамтран өмчлөх дундын өмчлөлд шилжүүлэхээр тохиролцоогүй байхад «орон сууцанд их засвар хийсэн, шинэчилсэн, өөрчлөн тоноглогсны улмаас үнэ нь үлэмж нэмэгдсэн, эсхүл анх гэр бүл болоход нь зориулагдсан (орон сууц, гэр, хашаа, байшин)» зэрэг үндэслэл зааж гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх хөрөнгөд тооцож болох хэдий ч Иргэний хуулийн 126.3-т заасан аль нөхцөл шаардлагад хамаарч байгаа байдлыг шүүхийн шийдвэрт дүгнэх шаардлагатай.

---

Шүүх үндсэн болон сөрөг нэхэмжлэлд байхгүй шаардлагыг тухайлбал, зохигчдоос шаардлага гаргаагүй байхад дундын хөрөнгийг шүүх өөрийн үзэмжээр хувааж хянан шийдвэрлэсэн нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчимд харшилж байгааг анхаарах нь зүйтэй. Жишээ нь: Нэхэмжлэлийн шаардлагад хамааралгүй, гэрлэгчдийн дундын хөрөнгөө хуваасан гэрээний заалтыг шүүхийн шийдвэрт тусгасан зөрчил байна.

---

Гэр бүлийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу Хүүхдийн тэтгэлэг төлөх хугацаа хожимдуулсан тохиолдолд гэрээгээр буюу шүүхийн шийдвэрийн үндсэн дээр алданги төлүүлэх боломжийг шүүх хэрэгжүүлж, шийдвэрлэж байгаа нь хүүхдийн өмчлөх эрхийг хангаж, эцэг, эхийн хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх нэг хэлбэр болж байгаа нь харагдаж байна.

2015 оны Дээд шүүхийн Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар гаргасан тоймд Гэр бүлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д «Тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болно» гэсэн зохицуулалтын «тэтгэлэг төлөгч» гэдэгт шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тэтгэлэг төлж буй этгээд хамаарахаар заасан байхад шүүх нэхэмжлэл гаргахаас өмнөх хугацааны тэтгэлгийг нөхөн гаргаж байгаа нь буруу болно гэж дурджээ.

Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх эрхтэй гэж заасан. Дүн шинжилгээ хийсэн шийдвэрүүдээс өв залгамжлалын маргаантай 2 хэргийн шийдвэрээс харахад гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн ямар хэмжээнд нь өв нээгдсэн талаар маргаан гарсан байна.

---

Жишээ нь: Нэхэмжлэгч Ц.Л-ийн хувьд тухайн 1 өрөө орон сууц нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд Д.Н болон Б.А нарын өмчлөх эрхэд бүртгэлтэй байсан учир эд хөрөнгийн 50 хувьд өв нээгдсэн хэмээн үзжээ. Харин хариуцагч Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.2.4-т зааснаар тухайн эд хөрөнгийн Д.Н, Б.А нараас гадна Н.Н, Н.М нар төрснөөс хойш худалдан авсан тул гэр бүлийн гишүүд болох нийт 4 хүний хамтран өмчлөх дундын хөрөнгөд тооцогдож, эд хөрөнгийн 25 хувьд өв нээгдсэн хэмээн маргажээ. Анхан, давж заалдах, болон хяналтын шатны шүүх хариуцагчийн тайлбарт дурдсан маргаан бүхий эд хөрөнгө нь Д.Н болон Б.А нарын хамтран өмчлөх дундын хөрөнгө байсан уу, эсхүл тэдний 2 хүүхдийг оролцуулан 4 хүний дундын

эд хөрөнгө байсан эсэх талаар эрх зүйн дүгнэлт өгөөгүй нь хүүхдийн эд хөрөнгийн өвлөх эрхийг хангаагүй шийдвэр болсон байна.

Учир нь тухайн эд хөрөнгийг Д.Н болон Б.А нар гэр бүл болж хүүхэд төрүүлснээс хойш худалдан авсан болохыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт дурдсан боловч хэргийг шийдвэрлэхдээ эд хөрөнгийн хувьд өвлөх эрх бүхий хүүхдүүдийг орхигдуулж, Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.2.4-г заасан «гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад эд хөрөнгө» нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө байна гэсэн зохицуулалтыг зөрчиж, хүүхдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлээгүй байна. Хариуцагч хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо шүүх Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.2.4 дэх заалтыг хэрэглээгүйгээс Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай хуулиар хамгаалагдсан эд хөрөнгийн эрхэд хохирол учруулж байгаа талаар тусгайлан маргасан хэдий ч Улсын дээд шүүх ч энэ талаар эрх зүйн дүгнэлт өгөөгүй байна.

---

Давж заалдах болон хяналтын шатны шүүх тухайн маргаан бүхий эд хөрөнгийн 50 хувьд өв нээгдсэн хэмээн үзэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 520 дугаар зүйлд зааснаар нас барагчийн эд хөрөнгөөс түүний 2 хүүхдийг өвлөх эрхтэй хэмээн үзсэн хэдий ч тэдний хууль ёсны төлөөлөгч Б.А нь тэдний нэрийн өмнөөс эд хөрөнгийг өвлөх эрхээс татгалзсан хэмээн үзжээ. Хүүхдийн эд хөрөнгийн эрхэд хохиролтой байдлаар төлөөлөх эрхийг хэрэгжүүлэх явдал манай улсад шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болж байгаа нь эндээс харагдаж байна. Цаашид эд хөрөнгө өвлөх эрх, өмчлөх эрхтэй холбоотой маргаан өсөх хандлагатай байна гэж судлаачдын зүгээс дүгнэж байна.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн харилцаанд хүүхдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах, нас барагчийн эд хөрөнгийг өвлөх талаарх хүүхдийн эдийн эрх, хүүхдийн хууль ёсны төлөөлөгч хүүхдийн эд хөрөнгийн эрхэд хохиролтой байдлаар төлөөлөх эрхийг

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

хэрэгжүүлсэн тохиолдолд хүүхдийн эд хөрөнгийн эрхийг хэрхэн хамгаалах, хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч нь хүүхдийн эд хөрөнгийг түүний нэрийн өмнөөс эзэмших, захиран зарцуулах аливаа гэрээ, хэлцэл хийхдээ хүүхдэд хохиролтойгоор төлөөлөх эрхийг хэрэгжүүлж байгааг хянах үр дүнтэй эрх зүйн механизм нэн шаардлагатай байна

### 2.1.4. Эцэг тогтоосон шийдвэрийн дүн шинжилгээ

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 7 дугаар зүйлд «...хүүхэд төрмөгцөө бүртгүүлэх, төрсөн цагаасаа нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрх эдэлнэ» гэж заасан байна. Гэр бүлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.-т «Хүүхдийн эцэг, эхийг тогтооход хариуцагч хүүхдийн эцэг эхтэй эр, эмийн харилцаатай байсныг нотлох баримт, эмнэлгийн шинжилгээ, бусад баримтыг үндэслэнэ» гэснээр шүүх хүүхдийн биологийн эцэг, эх хэн болохыг тогтооно. Хүүхдийн эцэг биш гэж хариуцагч маргаж байгаа тохиолдолд зохигчдын хүсэлтээр шүүгч захирамж гарган «эцэг тогтоох» шинжилгээ хийлгэхээр Шүүхийн шинжилгээний Үндэсний төвийн Шүүх эмнэлгийн хэлтсийг шинжээчээр томилно. Гэр бүлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, төрөл, садангийн хүн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага буюу 14 нас хүрсэн хүүхдийн хэн нэгний хүсэлтийг үндэслэн эцэг, эхийг шүүх тогтооно. Эцэг, эхийг тогтооход хүүхдийн эцэг эхтэй эр, эмийн харилцаатай байсныг нотлох баримт, эмнэлгийн шинжилгээ, бусад баримтыг үндэслэнэ.

---

Судалгаанд хамрагдсан шүүхийн шийдвэрт эх тогтоосон шийдвэр байхгүй, харин эцэг тогтоох шийдвэр 3 байна. Гэрлэлтээс гадуур төрсөн хүүхдэд тэтгэлэг тогтоох маргааныг шийдвэрлэхдээ эцэг нь хүүхдээ мөн эсэхэд эргэлзэж байхад шинжилгээ хийж эцэг тогтоолгүйгээр тэтгэлэг тогтоож шийдвэрлэсэн байна.

---

### 2.1.5. Эцэг, эх байх эрхийг хассан шийдвэрийн дүн шинжилгээ

Гэр бүлийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан (хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлүүлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр), хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасаж болно. Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т «шүүх эцэг, эх байх эрхээ хасуулсан хүнээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах асуудлыг шийдвэрлэнэ» хэмээн зохицуулжээ.

Эцэг, эх байх эрхийг хасуулах нэхэмжлэлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр цахим мэдээллийн санд байх боловч шийдвэрийн агуулга бүрэн хэмжээгээр харагддаггүй, эсхүл энэ төрлийн маргааны ангилалд өөр төрлийн маргаан шийдвэрлэсэн шийдвэр, магадлал оруулсан байдал цөөнгүй байна.

Судалгаанд эцэг, эх байх эрхийг хассан нийт 2 шийдвэрт дүн шинжилгээ хийсэн болно. Тухайлбал, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар эцэг байх эрхийг хасах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

---

Хэргийн үйл баримтаас дурдвал эхнэрээ жирэмсэн байхад нь зоддог байснаас хүү И нь 7 сар гаруйтай дутуу төрж, эх нялхсын эмнэлэгт 40 гаруй хоног инкубаторт байж хүн болсон. Улмаар нөхөр нь эхнэр, хүүхдээ хээр хөдөө аваачин энэ хүүхдийг алсан ч чадна, энэ хүүхэд гарснаас хойш амьдралд гай болж байна гэх мэтээр айлган сүрдүүлж байсан. Мөн эцэг нь шүүхэд гаргасан тайлбартаа «...хүүхдэдээ тусламж үзүүлж байгаагүй, боломжгүй, эцэг байхаас татгалзаж байна, гэрчилгээнд нь миний нэр байдаг бол хасуулья, би мөнгө төлөх ямар ч боломж байхгүй...» гэсэн тайлбарыг өгч, эцгийн үүргээ гүйцэтгэхээс санаатайгаар зайлсхийсэн байхад эцэг байх эрхийг нь хасаагүй буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

---

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Мөн энэ шийдвэрээс харахад, шүүх уг хэргийг үнэн бодитоор тал бүрээс нь шинжлэн судлах үүргээ гүйцэтгээгүй болох нь харагдаж байна. Учир нь хариуцагч эцэг байхаас татгалзсан байхад энэ талаар ямар нэгэн эрх зүйн дүгнэлт хийгээгүй байна.

Ховд аймгийн анхан шатны шүүхийн шийдвэрээр эцэг байх эрхийг хасуулах нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ. Хэргийн үйл баримтаас дурдвал хүүхдээ төрснөөс хойш нэг ч удаа холбоо бариагүй, тэжээн тэтгэх үүргээ биелүүлж байгаагүй иргэний эцэг байх эрхийг хасаж шийдвэрлэжээ. Энэ тохиолдолд шүүх Үндсэн хуулийн 17.2 дахь хэсэг болон Гэр бүлийн тухай хуулийн 30, 35 дугаар зүйлүүдийг удирдлага болгон шийдвэрээ гаргажээ.

Гэр бүлийн тухай хуулийн 31-р зүйлийн 31.2 дахь хэсэгт заасны дагуу эцэг, эх байх эрхийг хасуулсан хүнээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах асуудлыг шийдвэрлэх ёстой боловч судалгаанд хамрагдсан шийдвэрийн хүрээнд хүүхдийн тэтгэлгийн асуудлыг дүгнээгүй, шийдвэрлээгүй байна.

### *Хоёр. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүн шинжилгээ*

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн онцгой үйл ажиллагааны эцсийн үр дүн бөгөөд зөрчигдсөн эрхийн хамгаалалтын илэрхийлэл болсон шүүхийн шийдвэрийг хууль хэрэглээний эрх зүйн актын хувьд хууль зүйн үндэслэлтэй, шударга ёсонд нийцсэн, процессын болон материаллаг эрх зүйн зарчим, хэм хэмжээнд зохицсон агуулга, хэлбэртэй байх, шүүн таслах ажиллагаанд бүх шатны шүүхээс гарч буй аливаа шийдвэрийг хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх хуулийн шаардлагад нийцсэн байх ёстой. Шүүхийн шийдвэрийн агуулга, хэлбэр, бүтцийн талаар хуульд заасан шаардлагуудыг бүх шатны шүүхийн шүүгчид хэлбэрэлтгүй баримталж, шүүхээс гарч буй аливаа эрхийн актын боловсруулалт, найруулгад онцгой анхаарч ажиллах үүрэгтэй байдаг.

Судалгааны хүрээ, зохигчдын нууцын асуудалтай холбоотойгоор шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол бүхэлдээ буюу зарим хэсэг нь харагдахгүй байгаагаас хамааралтайгаар магадлал, тогтоолын бүтэц хууль ёсны байгаа эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй



байв. Харин бичвэрийн хувьд үг үсэг, найруулгын алдаатай байх, зохигчдын мэдээлэл (овог нэр, төрсөн он, сар өдөр, регистрийн дугаар зэрэг) хоорондоо зөрөх, шүүх бүрэлдэхүүний нэрийг алдаатай бичих зэрэг алдаа мэр сэр ажиглагдаж байна.

Үүнээс гадна хуулийн нэр томьёог буруу хэрэглэсэн тохиолдол байна.

---

Жишээ нь: Говьсүмбэр, Дорноговь аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 09 сарын 03-ны өдрийн шүүх хуралдааны тэмдэглэлд «сөрөг нэхэмжлэлийн нэхэмжлэгч, хариуцагч, сөрөг нэхэмжлэлийн нэхэмжлэгчийн өмгөөлөгч, сөрөг нэхэмжлэлийн хариуцагчийн өмгөөлөгч» гэж, шийдвэрийн үндэслэх хэсэгт «гэрлэлтийн баталгаа салгуулах нэхэмжлэл», «гэрлэлт цуцлах»-ыг «гэр бүл салах» гэх мэт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд томьёологдоогүй нэршил бичигдсэн алдаа гаргасан. Мөн хүүхдийн «тэтгэлэг»-ийг хүүхдийн «тэтгэвэр» гэж нэрлэх, хууль зүйн хувьд өөр агуулга бүхий нэр томьёо хэрэглэсэн утгын алдаатай шийдвэр гарсан.

---

Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэх ажиллагааны үед хүүхдээс санал авах ажиллагааг хийхдээ хүүхдийн хуульд заасан насыг харгалзахгүйгээр санал авах, эсхүл огт санал авахгүй байх зэрэг алдаа судалгааны явцад илэрсэн болно. Гэрлэлт цуцлах болон хүүхдийн асрамж шийдвэрлэхтэй холбоотой маргааны үед шинжээчийн дүгнэлт гаргуулах тохиолдол байгаа боловч уг дүгнэлтийг шүүгч шүүхийн шийдвэр гаргахдаа төдийлөн харгалзахгүй шийдэх байдал ажиглагдаж байна.

Хүүхдийн эцэг тогтоох маргаан нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 135.2.12-т заасан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг байхад түүнийг ердийн журмаар шийдвэрлэсэн зөрчил гарсан байна. Мөн Гэр бүлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан гэрлэлт цуцлахыг хориглосон үндэслэлийг харгалзахгүйгээр гэрлэлтийг цуцалж шийдвэрлэсэн тохиолдол гарсан байна. Жишээ нь, гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвдсөн, эхнэр нь жирэмсэн, хүүхэд нэг нас хүрээгүй байхад гэрлэлтийг цуцалсан нийтлэг алдаа байна.

## Дүгнэлт

Судалгаа хийх явцад хүүхдийн өмчлөх эрх нь эцэг эхийн гэрлэлт цуцлах, улмаар хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс хувь тогтоолгох, өв залгамжлах явцад зөрчигддөг болох нь харагдаж байна.

Иргэний эрх зүйн маргааны нэг төрөл болох гэр бүлийн холбогдолтой хэрэг, маргааныг шүүхээр шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийхэд шүүхээс хууль хэрэглээний дараах нийтлэг дутагдлууд ажиглагдлаа. Үүнд:

- Анхан шатны шүүхээс гэрлэлт цуцлах, хүүхдэд асрамж тогтоох, хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн насны байдлыг хуульд зааснаар тодорхойлох, хүүхдийн тэтгэлгийн хэмжээг настай нь уялдуулан Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар тогтоох, гэрлэлт цуцлахыг хориглосон мөн хуулийн 12 дугаар зүйлийг нягтлан тогтоож, түүнийг шийдвэрлэх хууль зүйн үндэслэлийг ханган ажиллах шаардлага байгааг энэ төрлийн маргаан шийдвэрлэсэн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ харуулж байна.
- Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт хийсэн дүгнэлтээр гэр бүл цуцлалтыг шийдэхдээ хүүхдийн тэтгэлгийг нэхэмжлээгүй бол шийдвэрлэхгүй орхигдуулдаг байна. Хүүхэд нь гэр бүлийн эрх зүйн харилцааны онцгой субьектийн хувьд хүүхдийн тэтгэлэг шаардсан эсэхээс үл хамаарч гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хүүхэд бүрт тэтгэлэг тогтоодог зохицуулалт шаардлагатай байна.
- Гэрлэлт цуцлах нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд хүүхдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, өр, төлбөр, тооцоо, хүүхдийн ирээдүйд амьдрах нөхцөл бололцоо зэргийг судалж үздэггүй, энэ талаар шүүхийн шийдвэрт дурдахгүй байна.
- Харин хүүхдийг эцэг, эхийн хэн нь асрамжлах талаар маргалдахад эдийн засгийн байдлыг л харгалзан үздэг хандлага давамгайлж, харин хүүхдийн ёс зүй, төлөвшилд илүүтэй сайнаар нөлөөлөх эцэг, эхийн хувийн шинж чанарт

дүгнэлт хийдэггүй байдал ажиглагдаж байна.

- Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ 7-оос дээш насны хүүхдийн саналыг авах ажиллагааг хийгээгүй нь Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн заалт болон Хүүхдийн эрхийн тухай конвенцийг зөрчсөн байна.
- Хүүхдийн саналыг авсан боловч харгалзаж үзэлгүй шийдвэрлэсэн хэрэг хүүхдийн асрамж шийдвэрлэсэн нийт хэргийн 10 хувь байна. Хүүхдийн саналыг шүүхийн шийдвэрийн үндэслэл заавал болгохгүй, харин харгалзаж үзэх үндэслэл болох ч хүүхэд саналаа хэлэхдээ гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг тухай дурдсан бол түүнийг харгалзаж үзэх, эсвэл дахин тодруулах арга хэмжээг шүүх авах үүрэгтэй байх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.
- Шүүхээр тогтоосон хүүхдийн тэтгэлгийг Гэр бүлийн тухай хуульд зааснаар «гагцхүү хүүхдийн хэрэгцээнд зарцуулна» гэсэн заалтыг хүүхдийн тэтгэлэг тогтоосон анхан шатны шүүхийн шийдвэрт заавал дурдаж, тэтгэлэг хүлээн авагч эх, эцэгт үүнийг үүрэг болгосон заалтыг шийдвэрт тусгаж байгаа нь сайшаалтай байна.
- Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг шийдвэрлэлгүй орхигдуулж байгаа алдаа нийтлэг байна.
- Хүүхдийн асрамж тогтоосон шүүхийн шийдвэрт хүүхдийн эцэг эхтэйгээ уулзах, эцэг эхийн зүгээс хүүхдээ хүмүүжүүлэхэд оролцох эрхийг хэрхэн хангах тухай дурдаагүй, дүгнээгүй шийдвэрүүд ажиглагдаж байна.
- Анхан шатны шүүх нь хүүхдийн тэтгэлгийн асуудлыг шийдвэрлэхдээ хүүхэд тус бүрийн насны байдлыг харгалзан тэтгэлгийн хэмжээг ялгамжтай зөв тогтоогоогүй эсхүл хүүхэд тус бүрт тогтоогоогүй байдал цөөнгүй ажиглагдлаа.
- Хүүхдийн тэтгэлэг тогтоосон шүүхийн шийдвэрт тэтгэлгийг төлж байх өдрийг тодорхой хугацаа заахгүй байгаа нь Гэр бүлийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд

- тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги төлнө гэсэн журмыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.
- Хүүхдийн тэтгэлэг тогтоох асуудлын хувьд Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д зааснаар хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг удаа, 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний 50 хувиар, 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшний хэмжээгээр тус тус олгохоор заасан байдаг. Гэтэл шүүхийн шийдвэрт хүүхэд тус бүрт бус, дунд нь тэтгэлгийг тогтоож, шийдвэртээ бичих нийтлэг алдаа ажиглагдаж байна.
  - Гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар эцэг, эх хүүхэд хоорондын харилцаа нь хүүхэд төрснөөр, хүүхдийг үрчлэн авснаар, дагавар хүүхэд, хойт эцэг, хойт эхийн хооронд эцэг, эх хүүхдийн харилцаа үүсдэг хууль зүйн зохицуулалттай боловч дагавар хүүхдэд тэтгэлэг тогтоох асуудлыг орхигдуулан шийдвэрлэж байна.
  - Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийг хуваах маргааныг шийдвэрлэх явцад шүүх, дундын хөрөнгийг тодорхойлох болон хуваахдаа хуулийг буруу тайлбарлан хэрэглэх явдал гарч байна. Тухайлбал, өвөлжөөний газрыг гэрлэгчдийн дундын эд хөрөнгө гэж анхан шатны шүүх дүгнэснийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн байна. Энэ нь Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.7-д «Өвөлжөө, хаваржааны доорх газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно.» гэсэн заалтыг зөрчсөн шийдвэр болжээ.
  - Гэр бүлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан гэрлэлт цуцлахыг хориглосон үндэслэлийг харгалзахгүйгээр цуцалж шийдвэрлэсэн тохиолдол гарсан байна. Жишээ нь, гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвдсөн, эхнэр нь жирэмсэн, хүүхэд нэг нас хүрээгүй байхад гэрлэлтийг цуцалсан нийтлэг алдаа байна.

## Ном зүй

### Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ.1992 он
2. Монгол Улсын Иргэний хууль УБ.2002 он
3. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль УБ.1999 он
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002
5. Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар Дээд шүүхийн тойм. УБ. 2013
6. Гэр бүлийн болон Иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 46 дугаар тогтоол, 2008
7. Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар Дээд шүүхийн тойм. УБ. 2017

### Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Алтанцэцэг Ц, Дугармаа А. Гэр бүлийн эрх зүй. УБ. 2007 он
2. Баасандорж С. Гэр бүлийн эрх зүй. УБ. 2011 он
3. Буянхишиг Б. Иргэний эрх зүйн удиртгал. УБ. 2012 он
4. Дугармаа А. Монгол Улсын гэр бүлийн эрх зүй. УБ.2005 он
5. Зундуй Д. БНМАУ-ын хөдөлмөр, гэр бүлийн хуулийг хэрэглэх зарим асуудал. УБ. 1980 он.
6. Мөнхжаргал Т. Гэр бүлийн эрх зүй. УБ. 1995 он
7. Мөнхжаргал Т. Бүгд Найрамдах хятад Ард улсын иргэний хууль, түүнд холбогдох хуулиудын эмхэтгэл. УБ. 2010 он
8. Мөнхжаргал Т. Өв залгамжлалын эрх зүй. УБ. 2002 он
9. Наранчимэг Д. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. УБ. 2002
10. Отгонтуяа О. Амарсайхан О. Монгол Улсын гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт. УБ. 2009 он
11. Оюунтунгалаг Ж. Харьцуулсан иргэний эрх зүй. УБ. 2013 он
12. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар УБ.2007 он  
<http://www.shuukh.mn/>  
[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)  
<http://www.judcouncil.mn/file/argazui.pdf>

## **ГЭМ БУРУУГУЙ НЬ ТОГТООГДОЖ ЦАГААТГАГДСАН ХЭРГҮҮД БА ТҮҮНИЙ УЛМААС ХОРИГДСОН ИРГЭДИЙН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛБӨР**

*Б.Мэргэн (Хуульч, ХЗШУ-ы магистр)*

*Г.Байгальмаа (Хуульч, ХЗШУ-ы магистр)*

*Э.Хашчулуун (Хуульч, ХЗШУ-ы магистрант)*

### **Удиртгал**

Энэхүү судалгааны зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдан хоригдож байгаад шүүхээс гэм буруугүйг нь тогтоож цагаатгагдсан иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн боломж, шүүхийн практикийн өнөөгийн нөхцөл байдлыг судалж дүгнэлт, зөвлөмж боловсруулахад оршино. Судалгааны хүрээнд:

- Шүүхээр цагаатгагдсан иргэдийн хэдэн хувьд нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаарх бодит мэдээлэлтэй болох;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдан хоригдож байгаад шүүхээс гэм буруугүйг нь тогтоож цагаатгагдсан иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикийг олон улсын туршлагатай харьцуулан судлах зорилтууд тавьсан болно.

*Судалгааны мэдээллийн эх сурвалж, арга зүй*

Судалгааны ажлын сэдэв, хүрээг тодорхойлохдоо гэмт хэрэгт шалгагдаж буй этгээдийн эрх, эрх чөлөөг хамгийн хүндээр хязгаарладаг, олон талаар хохироодог, нийгэмд түгээмэл байгаа зэргийг харгалзан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж, шүүхийн шатанд цагаатгагдсан иргэдийн хохирлын

асуудлыг хамруулахыг зорьсон болно. Судалгааг дараах аргуудыг ашиглан гүйцэтгэлээ. Үүнд:

**Баримт бичгийн судалгаа:** Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (2002), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенц, эрх зүйн сэдэвт онолын ном, судалгааны бүтээл, нийтлэл, судалгааны ажлын тайлан, сэдэвтэй холбоотой улс орнуудын холбогдох хууль, онолын зарим бүтээлийг судаллаа.

**Түүвэрчилсэн судалгаа:** Шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим сангаас ([www.shuukh.mn](http://www.shuukh.mn)) сэдвийн хүрээнд хамаарах хууль бусаар цагдан хоригдож шүүхээс цагаатгагдсан эрүүгийн хэргийн цагаатгах шийдвэр, магадлал, тогтоолуудыг авч үзэв. Түүнчлэн, хууль бусаар цагдан хоригдсоны улмаас учирсан гэм хорын хохирол гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийн шийдвэр, магадлал, тогтоолуудыг сонгон судлахдаа шүүхийн шийдвэрийн олдоц, судалгааны ажлын ач холбогдлыг нэмэгдүүлэх үүднээс цаг хугацааны хувьд 2013-2017 оны хооронд шийдвэрлэгдсэн хэргүүдийг түүвэрлэн сонгосон болно.

**Анкетын судалгаа:** Цагдан хоригдсоны улмаас хохирлоо нөхөн төлүүлсэн эсэх, хохирол нөхөн төлүүлэх талаарх мэдлэг мэдээлэл, хэрэгцээ шаардлагыг тогтоох зорилгоор гэм буруугүй нь тогтоогдож цагаатгагдсан иргэдээс тусгайлан боловсруулсан анкетын аргаар судалгаа авав.

**Ярилцлагын судалгаа:** Гэм буруугүйг нь тогтоож цагаатгагдсан иргэдээс цагдан хорих хангалттай үндэслэл байсан эсэх, гэмт хэрэгт шалгагдаж цагдан хоригдсон болон цагаатгагдсанаас хойших хугацаанд гарсан амьдралын өөрчлөлт, хохирсон байдал, хохирлоо нөхөн төлүүлсэн эсэх талаар бодит мэдээлэл олж авах зорилгоор ганцаарчилсан ярилцлага хийсэн болно.

*Судлагдсан байдал*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цагдан хорих арга хэмжээ нь хүний эрхийг ноцтой хөнддөг талаар эрдэмтэн судлаачид ном товхимол, өгүүлэл нийтлэлдээ цөөнгүй дурддаг. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос ч энэ талаар цөөнгүй судалгаа шинжилгээ хийж илтгэл хэлэлцүүлжээ. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний хүрээнд судлагдсан байдлыг авч үзвэл Ж.Бямбаа «Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд» 2008 он, «Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тайлбар толь» 2000 он, «Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд» 1998 он, С.Алтай «Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь яллахаас татгалзах тухай ойлголт, мөн чанар, хууль зүйн учир холбогдол» сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээл (2011 он, МУИС-ХЗС), Д.Уранчимэг «Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шүүхийн шатанд шийдвэрлэх асуудал» (2012 он, МУИС-ХЗС), Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн «Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт» бодлогын судалгааны тайлан 2014 он зэрэг судалгааны бүтээлийг дурдаж болно. Түүнчлэн, Иргэний эрх зүйн хэм хэмжээний хүрээнд судлагдсан байдлыг авч үзвэл Б.Буянхишиг «Иргэний эрх зүйн тусгай анги», Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судлаачдын «Төрийн байгууллага албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгаж байгаа байдал» 2009 он, Ж.Оюунтунгалаг «Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал» (2002 он, МУИС-ХЗС), Э.Золзаяа «Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал» (2016 он, МУИС-ХЗС), Д.Мөнхбаатар «ЭБША-ны явцад иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал» (2016 он, МУИС-ХЗС) зэрэг магистрын зэрэг горилсон судалгааны ажлуудыг дурдаж болохоор байна.

## **1. Цагдан хорих арга хэмжээ ба олон улсын туршлага**

Монгол Улс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг түгээмэл хэрэглэдэг.



Энэ арга хэмжээ нь хүнийг тодорхой хугацаанд нийгмээс тусгаарлаж, эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа хүнд төрлийн албадлагын арга хэмжээ юм. Цагдан хорих арга хэмжээ нь прокурор мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт, нотолгоо бий болсныг үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэгдэн яллагдагчаар татагдсан этгээд болон шүүгдэгчийг мөрдөн байцаалт, шүүхээс оргон зугтаалгахгүй, хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулахад саад учруулахгүй, цаашид гэмт хэрэг дахин шинээр үйлдэх бололцоо олгохгүй байх зорилгоор тэдний хууль бус үйлдэл, зан үйлтэй тэмцэхэд чиглэгдсэн байдаг. Гэсэн хэдий ч энэхүү албадлагын арга хэмжээ нь гэм буруугүй сэжигтэн, яллагдагч болон бусад таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх боломжтой этгээдийн эрхийг ноцтой зөрчих утгаараа түгээмэл хэрэглэхийг судлаачдын зүгээс шүүмжилдэг.

Бидний судалгааны ажлын зорилго нь гэм буруугүйгээр цагдан хоригдсон этгээдийн хохирол арилгуулах нөхөн төлүүлэх асуудлыг судлахад чиглэгдэж байгаа хэдий ч цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний талаарх онолын ойлголтыг дурдахгүйгээр судалгааны ажил үр дүнтэй болох боломжгүй юм.

### **1.1 Цагдан хорих үндэслэл**

Цагдан хорих арга хэмжээ нь хүний халдашгүй байх, эрх чөлөөтэй байх салшгүй эрхийг хөнддөг учраас үндэсний төдийгүй олон улсын түвшинд эрх зүйн хамгаалалт тогтоодог. НҮБ-ын 1945 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйлд «Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй», 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9.1-д «...Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй» гэж заасан. Түүнчлэн НҮБ-аас «Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц»-ийг 1984 онд, «Цагдан хорих болон хорих ял эдэлж байгаа хүмүүсийг хамгаалах зарчмууд»-ыг 1988 онд тус тус батлан гаргажээ. Энэ байдлыг Монгол Улсын Үндсэн хуулийн

16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт «Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, цагдан хорих, мөрдөн мөшгих эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно» гэж заасан.

Цагдан хорих нь гагцхүү өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авах боломжгүй тохиолдолд хэрэглэдэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албадлагын эцсийн арга хэмжээ<sup>103</sup> юм. Түүнчлэн, цагдан хорих нь хүний хувийн эрх чөлөөг хязгаарлаад зогсохгүй, сэтгэл санаа болон бие махбодийн эрүүл мэнд, нэр төр, ажил амьдрал, гэр бүлийн байдалд сөргөөр нөлөөлдөг бөгөөд хүнийг хамгийн их хохироодог албадлагын арга хэмжээ билээ.

Иймээс хэрэг хянан шийдвэрлэх явцад аль болох цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаас татгалзаж бусад төрлийн албадлагын арга хэмжээ хэрэглэх замаар гэмт хэргийг илрүүлдэг болох нь чухал юм. Энэ нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруугүй тохиолдолд хүний үндсэн эрхийн ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлэх, учруулах хохирлын хэмжээг тодорхой хэмжээнд бууруулах сайн талтай.

Манай улсын хувьд шүүхээс дараах үндэслэлийн аль нэг нь байвал яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргаж байна. Үүнд<sup>104</sup>:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан
- Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;
- Гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;
- Урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй зэрэг болно.

<sup>103</sup> «Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт» бодлогын судалгааны тайлан 2014 он, 9 дэх тал

<sup>104</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 зүйлийн 1 дэх хэсэг

Шүүхийн статистик тайлан мэдээнээс үзэхэд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих үндэслэлүүдээс хамгийн түгээмэл хэрэглэж байгаа нь «оргон зайлж болзошгүй» гэсэн үндэслэл байдаг<sup>105</sup>. «Оргон зайлсан, оргон зайлахыг завдсан» гэх үндэслэлийг нарийвчилж заасан тодорхойлолт, хуулийн тайлбар байхгүй бөгөөд практикт дараах нөхцөл байдлыг авч үзэж байна. Үүнд:

- Сэжигтэн, яллагдагч нь тодорхой оршин суух хаяггүй;
- Оршин суух хаягийн өөрчлөлтийг мэдэгдээгүй;
- Урьд ял шийтгүүлж байсан этгээд;
- Ялтай байх хугацаандаа дахин гэмт хэрэгт холбогдсон;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхэд дуудсан цагт хүрэлцэн ирдэггүй;
- Гадаад улсад гарах магадлалтай (өөр улс руу явах билет захиалсан, авсан) зэрэг болно.

## 1.2 Цагдан хорих хугацаа

Шинээр батлагдан хэрэгжиж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байхаар заажээ. Хорьж мөрдөх хугацааг сунгахдаа мөрдөн байцаагч тогтоол үйлдэн, прокурор 24 цагийн дотор шийдвэр гаргана. Шүүгч нь прокурорын саналыг хүлээн авч 24 цагийн дотор захирамж гаргах бөгөөд хорьж мөрдөх хугацааг нэг удаа 1 сар хүртэл сунгаж болно. Яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сар, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй гэжээ. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах), 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах), 19.6 (Хорлон сүйтгэх), 29.5 дугаар зүйлд (Төрлөөр устгах) заасан гэмт хэргийн яллагдагчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас илүү хугацаагаар

<sup>105</sup> «Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт» бодлогын судалгааны тайлан 2014 он, 10 дахь тал

цагдан хорих шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно. Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан; нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. 24 цаг хүртэл баривчлагдсан хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцохоор хуульчилсан байна. Цагдан хоригдсон хугацааг шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолд заавал дурддаг бөгөөд ингэж дурдах нь шүүгдэгчийн эрхийн хамгаалалтад чухал ач холбогдолтой юм.

### **1.3 Цагдан хорих арга хэмжээг өөрчлөх, дуусгавар болгох**

Аливаа таслан сэргийлэх арга хэмжээ нь тодорхой чиглэсэн зорилготой байдаг. Түүнийг цаашид хэрэглэх шаардлага арилсан бол хүчингүй болгох, эсхүл хэргийн нөхцөл байдлаас хамааран урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг чангатгах буюу хөнгөрүүлэн өөрчилж болно<sup>106</sup>. Таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох буюу өөрчлөх явдлыг прокурорын үндэслэл бүхий тогтоолоор, уг хэрэг шүүхэд шилжсэн бол шүүхийн үндэслэл бүхий тогтоол, шүүгчийн захирамжаар тус тус гүйцэтгэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9-д заасан үндэслэлүүд арилсан тохиолдолд цагдан хорих арга хэмжээг дуусгавар болсон гэж ойлгож болно. Мөн тухайн яллагдагчийн хувийн байдал бас үүнд хамааралтай. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дэх хэсэгт зааснаар энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3-г заасан таслан сэргийлэх арга хэмжээг дангаар болон давхардуулан авч болно. Энэ зүйлийн 1.4, 1.5, 1.6-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй

<sup>106</sup> Ж.Бямбаа, Г.Баясгалан «Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд» УБ, 1998 он

давхардуулж авахгүй. Жишээ нь, Гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээдийг мөрдөн байцаалтын шатанд хэрэг хянагдаж байх хугацаанд яллагдагчаар «цагдан хорих» таслан сэргийлэх арга хэмжээ авсан ч дахин «барьцаа авах» таслан сэргийлэх арга хэмжээг давхардуулан авахгүй гэсэн үг юм.

#### 1.4 Цагдан хорих арга хэмжээг хэрэглэх олон улсын туршлага

Харьцуулсан эрх зүй судлал бол эрх зүйн янз бүрийн тогтолцоог судлах, эрх зүйн нэг төрлийн институт, тэдгээрийн үндсэн зарчимд харьцуулалт хийхийг гол арга болгон ашигладаг хууль зүйн шинжлэх ухааны бие даасан хэсэг мөн<sup>107</sup>. Харьцуулсан эрх зүйн өөр нэг зорилт нь гадаад улс орнуудын эрх зүйн туршлагыг судалсны үндсэн дээр үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгоход чиглэдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийн эрхийг хамгаалах нь хүний эрхийн тулгуур асуудлуудын нэг бөгөөд үүнийг дэлхийн улс орнууд дотоодынхоо хууль тогтоомжид үндэслэн янз бүрээр зохицуулсан байдаг.

*Англи-Саксоны эрх зүйн бүлд багтдаг улс орнуудын цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний онцлог*

Дундад зууны үеийн Англид анх бий болж Америк, Канад, Австрали, Умард-Ирланд, Шинэ Зеланд зэрэг олон орныг багтаасан Англи-Саксоны эрх зүйн тогтолцоо нь шүүхийн хэвшүүлэн хэрэглэх хэм хэмжээг (шүүхийн прецедент) эрх зүйн эх сурвалж хэмээн хүлээн зөвшөөрдгөөрөө бусад эрх зүйн бүлүүдээс ялгаатай<sup>108</sup>. Энэхүү тогтолцоонд багтах АНУ-ын эрүүгийн байцаан шийтгэх (ЭБШ) ажиллагаанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн хэрэглэдэг талаар товч авч үзье.

АНУ нь бие даасан эрүүгийн байцаан шийтгэх хуульгүй бөгөөд ЭБШ эрх зүйн эх сурвалж нь шүүхийн байгууллагуудын гаргасан хууль тогтоомжийн акт, нийтийн эрх зүйн хэм хэмжээ болно. АНУ тавин муж улс тус бүртээ эрүүгийн багц хуультай, мөн Холбооны

<sup>107</sup> С.Нарангэрэл «Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо» 2001 он. УБ хот. 218 дахь тал

<sup>108</sup> С. Нарангэрэл «Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо» 2001 он. УБ хот. 227 дахь тал

муж улс нь ч бие даасан хуультай ажээ<sup>109</sup>. АНУ-д манай улсынхтай адил таслан сэргийлэх арга хэмжээ гэж байхгүй. Харин шүүхийн өмнөх шатны хорих ажиллагаа гэж байдаг. Сэжигтнийг оргон зугтаж магадгүй, эсхүл аюул занал учруулж болзошгүй гэж үзсэн тохиолдолд цагдан хорьж болдог байна. Цагдан хорьсон тохиолдолд цагдаа болон прокурор тухайн сэжигтнийг ар гэр, төрөл саданд нь мэдэгдэх үүрэг хүлээхгүй бөгөөд харин цагдан хоригдсон сэжигтэн өөрийн хүссэн хүнтэйгээ утсаар ярих эрхтэй. АНУ-д цагдан хорих хугацааны тодорхой хязгаар байдаггүй. Мөн хоригдож байгаа хүний нас хүйс болон хөгжлийн бэрхшээл, хөдөлмөрийн чадвараа алдсан зэргийг үл харгалздаг буюу хэн нэгэнд илүү, эсвэл ялгавартайгаар хандахыг хориглодог.

*Ром-Германы эрх зүйн бүлд багтдаг улс орнуудын цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний онцлог*

Ром-Германы эрх зүйн бүл нь Африкийн ихэнх орон, Латин америкийн бүх улс, эх газрын европын улс орнуудыг хамарсан байдаг. Дээрх бүлээс төлөөлөн Франц Улсын ЭБШ ажиллагаанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн хэрэглэдэг талаар авч үзье. Франц Улс нь эрүүгийн болон эрүүгийн процессын анхны төрөлжсөн хуулийг бүтээгч, эх газрын системийг үүсгэн хөгжүүлсэн орны хувьд гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны арвин баялаг туршлага, уламжлалтай орон. Тэр тусмаа шүүхийн өмнөх шатан дахь мөрдөн шалгах болон мөрдөн байцаалтын харьяалал, үе шатыг процессын нарийвчилсан нөхцөлүүдээр зохицуулах, эрүүгийн хэргийн нотлох ажиллагааг шүүхийн хяналт, эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд процессын хэлбэрүүдийг бий болгох талаар анхны жишиг журмуудыг нэвтрүүлж хэвшүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байдаг. Францын Үндсэн хууль, Европын холбооны хууль тогтоомж, Хүний эрхийн конвенц зэрэгт шүүх эрх мэдлийн суурь зарчмууд, хүний халдашгүй эрхийн баталгаа, процессын хязгаарлалт, хамгаалалтын тухай өгүүлсэн нь

<sup>109</sup> Б.Ширэндэв «Цагдан хорих ТСАХ-г хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал» магистрын дипломын ажил 28 дахь тал

бий. Францын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд «Хэнийг ч дур мэдэн эрх чөлөөг нь хасаж болохгүй. Хувийн халдашгүй эрхийг хамгаалагч шүүх эрх мэдэл нь хуулиар урьдчилан тогтоосон нөхцөлийг сахиулах үед энэ зарчмыг хүндэтгэн хангуулах ёстой<sup>110</sup>» гэж заажээ. Иргэний болон Хүний эрхийн тунхаглалын 7 дугаар зүйлд «Хуульд тусгайлан журам болгон зааснаас бусад ямар ч тохиолдолд хүнийг баривчлах буюу цагдан хорих, тэрчлэн яллах ажиллагааг явуулж болохгүй»; 9 дүгээр зүйлд «Хуулиар хатуу тогтоосон нөхцөл, журмын дагуу зайлшгүй хариуцлага хүлээх нь нотлогдсоноос бусад ямар ч тохиолдолд гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй» гэж заасан.

*Баривчлах, цагдан хорих ажиллагаа*

Баривчлах болон цагдан хорих ажиллагаа нь эрүүгийн процессын шүүхийн өмнөх шатан дахь онцгой тохиолдолд авдаг таслан сэргийлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм. Эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй хүнийг хэн гэдгийг нь олж тогтоох, биеийн байцаалтын мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлан тогтоох шаардлагаар 4 цаг хүртэлх хугацаанд баривчлах арга хэмжээ авна. Цагдаагийн офицер, комиссар зэрэг мөрдөлт явуулах эрх бүхий албан тушаалтан уг арга хэмжээг авах эрхтэй бөгөөд түүнээс дээш болон 24 цаг хүртэлх хугацаагаар баривчлах тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгээр түүний хяналт доор хэрэгжинэ. Мөрдөн мөшгих ажиллагааг үүсгэсэн тохиолдолд 48 цаг хүртэлх хугацаагаар баривчлах арга хэмжээ авч болох ба энэ тохиолдолд (24 цагаас дээш) шүүгчийн тогтоол, шийдвэрийг үндэслэнэ. Баривчлах үндэслэл нь тухайн хэрэгт сэжиглэгдэж байгаа нь тодорхой баримт, сэлтүүдээр нотлогдож, оргон зайлах нөхцлийг нь хааж таслан зогсоох бодит нөхцөл бий болсон зэргийг тодорхой харуулсан байдаг. Зохион байгуулалттай үйлдэгдсэн гэмт хэргийн хувьд 96 цаг хүртэлх хугацаагаар сунгаж баривчлах арга хэмжээ авч болно. Энэ тохиолдолд баривчилснаас хойш 48 цагийн дараа өмгөөлөгч авах эрхийг хангах журам үйлчилдэг.

<sup>110</sup> П.Эрдэнэбат «Гадаад орнуудын эрүүгийн процессын онцлог» 2018 он. УБ хот. Нийтлэл 2-9 дэх тал

Мөрдөн мөшгих ажиллагааг үүсгэж, мөрдөн байцаалтын хэрэг нээснээс хойш цагдан хорих арга хэмжээг хэрэглэх журмыг Франц Услын Эрүүгийн процессын хуулийн 145.1-р зүйлийн «d»-д тодорхой хуульчилж өгчээ. Тухайлбал, уг заалтаар Эрүүгийн хуульд 5 жилээс дээшгүй буюу наад зах нь 1 жилээс доошгүй хорих ял оногдуулахаар хуульчилсан гэмт хэрэг үйлдсэн байж болох этгээдийг 4 сар хүртэлх хугацаагаар цагдан хорих арга хэмжээ авч болно. Харин 10 жилээс доошгүй хорих ял эдлэхээр заагдсан хэргийн хувьд зайлшгүй үндэслэл бүхий онцгой тохиолдолд нэг жил хүртэлх хугацаагаар сунгаж цагдан хорих арга хэмжээ авч болно. Энэ нь зөвхөн зарим хүнд ноцтой гэмт хэргийн хувьд онцгой нөхцөлд хэрэглэгдэнэ. Гэхдээ цагдан хорих хугацааны дээд хязгаар 4 сар гэдэг нөхцөлийг мөрдөн байцаалтын практикт жишиг болгон хуульчилсан байна. Цагдан хорих арга хэмжээний үндэслэл нь гарцаагүй бөгөөд бодит нотолгоонд тулгуурлахаас гадна шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, хяналт дор тусгайлан хариуцсан шүүгчийн шийдвэрээр хэрэгжинэ.

ОХУ-ын хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг дараах тохиолдолд хэрэглэхээр тусгажээ. Үүнд:

- Хоёроос дээш жил хорих ял шийтгүүлэхээр заасан гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчид өөр хөнгөн төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд шүүхийн шийдвэрээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг.
- Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчид нь хүнд ба онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн тохиолдолд тэдэнд таслан сэргийлэх арга хэмжээг авч болно. Онцгой тохиолдолд насанд хүрээгүй сэжигтэн яллагдагч дунд зэргийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээ авна.
- Зайлшгүй цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахын тулд прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь баривчлах хугацаа дуусахаас 8 цагийн өмнө шүүхэд танилцуулах ёстой. Шүүгчийн гаргасан тогтоол нь санал гаргасан этгээд буюу прокурорт нэн даруй хүргэгдэж



сэжигтэн яллагдагчийг цагдан хорих арга хэмжээ хэрэгжинэ.

- Нэг этгээдийг өмнөх хэрэгт дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахаар санал гаргахдаа шүүхийн татгалзах тогтоол гарсны дараа шинээр үүсэж бий болсон нөхцөл байдалд үндэслэн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг авна.

ОХУ-ын ЭБШ хуулийн 109 дүгээр зүйлд цагдан хорих хугацааны<sup>111</sup> талаар заасан байна.

- Гэмт хэргийг мөрдөх үед цагдан хорих хугацаа 2 сараас илүүгүй байна.
- Гэмт хэргийн ээдрээ, түвэгтэй байдлыг харгалзан мөрдөн байцаагчийн саналыг зохих шатны прокурорын зөвшөөрснөөр тухайн шүүхийн шүүгч 12 сар хүртэлх хугацаагаар сунгаж болно.
- 12 сараас дээш хугацаагаар цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн яллагдагчид энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан шүүхийн шүүгч буюу тэдэнтэй адилтгах цэргийн шүүхийн шүүгч мөрдөн байцаагчийн гаргасан саналыг ОХУ-ын ерөнхий прокурор болон түүний орлогчийн зөвшөөрснөөр 18 сар хүртэл сунгаж болно.

*Турк Улсын цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний онцлог*

Туркийн ЭБШ хуулийн 104-131 дүгээр зүйлд хорих саатуулах ажиллагааны талаар тусгайлан зохицуулсан байдаг. Сэжигтнийг дараах үндэслэл байгаа тохиолдолд цагдан хорино. Үүнд:

- Гэмт хэрэгтэн ба сэжигтэн оргон зайлах, зугтах магадлал өндөртэй;
- Эд мөрийн баримт алга болох, солих, нуух, хохирогч болон гэрч этгээдүүдтэй тохиролцох, худал мэдүүлэг өгөхөөс татгалзах;
- Гэмт хэрэгтэн ба сэжигтний хаяг, оршин суугаа газар тодорхойгүй;
- Эрүүгийн хуульд заасан 7-оос дээш жилийн ял эдлэх гэмт

---

<sup>111</sup> Б.Ширэндэв «Цагдан хорих ТСАХ-г хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал» магистрын дипломын ажил он 31-33 дахь тал

хэрэг үйлдсэн тохиолдолд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ажээ.

Урьдчилан хорих тохиолдолд прокуророор дамжуулан шүүгч зөвшөөрөл олгодог бөгөөд прокурор нь цагдан хорих тогтоолыг сэжигтэн ба гэмт хэрэгтэнд бичгээр танилцуулж, эсвэл уншиж мэдэгдэнэ. Сэжигтэн болон гэмт хэрэгтнийг хоригдсон тухай түүний ойр дотнын хүмүүс, ах дүү нарт нь мэдэгдэх ба хохирогч өөрөө хүсвэл холбогдох этгээдэд мэдэгдэнэ. Хорих хугацаа нь байцаалтын үед 6 сар байх бөгөөд 2 жил хүртэлх хугацаагаар хорьж болдог байна.

*Монгол Улсын цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний онцлог*  
Манай улсын хувьд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг бөгөөд шүүх ЭХШХШтХуулийн 14.9 дүгээр зүйлд заасан дараах үндэслэлийн аль нэг нь байвал яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргана<sup>112</sup>:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан;
- Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;
- Гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;
- Урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй;
- Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 8 жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

<sup>112</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) 14.9 дүгээр зүйл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу цагдан хорих арга хэмжээ авагдсан хүмүүсийн дийлэнх олонх нь хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон байдаг бөгөөд тэдгээрийн ихэнх хувь нь «оргон зайлж болзошгүй», «оргон зайлахаар завдсан» гэсэн үндэслэлээр хоригдсон байдаг. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх болон 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын зохицуулалтыг үзэхэд оргон зайлахыг завдсан, оргон зайлж болзошгүй гэсэн үндэслэлийг тодорхойлоогүй боловч шүүхийн практикт түгээмэл хэрэглэж байгаа нь цагдан хорих арга хэмжээ нь зарим талаараа субъектив байдлаар хэрэгждэг болохыг харуулж байна.

### 1.5 Шүүхийн практик

*Эрүүгийн хэргийн шийдвэрүүдийг судалсан байдал*<sup>113</sup>:

2013-2017 онд мөрдөн байцаагч, прокурорын буруутай үйл ажиллагааны улмаас цагдан хоригдсон боловч шүүхийн шийдвэрээр цагаатгагдсан иргэдийн талаарх мэдээллийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж үзэхэд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан нийт 173 шийдвэр байна. Энэ шийдвэрүүд нь хувийн баталгаа гаргуулах, тодорхой үйл ажиллагаа явуулах болон албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хөдөлгөөний хязгаарлалт тогтоох, барьцаа авах, цагдан хорих, оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, эд хөрөнгө барьцаалах зэрэг хүсэлтэд үндэслэн гарчээ. Тэдгээрээс 45 хэргийн тогтоолд шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан болохыг дурджээ. Эндээс үзэхэд нийт цагаатгасан хэргийн 25 гаруй хувьд нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан болох нь тодорхой харагдаж байна (График 1-ийн харна уу.). Энэ нь улсын хэмжээнд гаргасан дүн юм.

<sup>113</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)



*Шүүхийн ерөнхий зөвлөлөөс жил бүр эмхтгэн гаргадаг «Шүүн таслах ажиллагааны тайлан» (2013-2017 он)*

2013-2017 онд онд Анхан шатны шүүх 58133 хүнд холбогдох 40286 хэрэг хүлээн авснаас 33901 хэрэг шийдвэрлэж нийтдээ 7329 хүнийг сэжигтнээр, 9516 хүнийг яллагдагчаар цагдан хорьжээ. Тайлангийн дүнгээс харахад сүүлийн жилүүдэд сэжигтэн, яллагдагчийн тоо төдийлөн буурахгүй байна. Зөвхөн 2017 оноор авч үзэхэд Анхан шатны шүүхээс Эрүүгийн байцаан шийтгэх (2002 оны) хуулийн 68 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (2017 оны) хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар 2765 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ.

Товч дүгнэхэд, 2013-2017 оны 7 дугаар сар хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн болон яллагдагчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч хүний эрхийг ноцтой зөрчин цагдан хорьдог байсан нь харагдаж байна (График 2-ыг харна уу.).




Улсын дээд шүүхээр авч шийдвэрлэсэн хэргийн тоо  
(дээд шүүхийн 2013-2017 оны тайлангаас)

**Хүснэгт 1. Улсын дээд шүүхийн хянасан хэргийн тоо**

Он	Дээд шүүх хяналтын журмаар хүлээн авсан хэргийн тоо		Шийдвэрлэсэн хэргийн тоо	
	Эрүүгийн	Цагаатгалын	Эрүүгийн	Цагаатгалын
2013	579	72	463	72
2014	634	8	478	6
2015	501	383	0	0
2016	444	2	335	2
2017	455	5	340	2

Хүснэгтээс харахад, дээд шүүхээс цагаатгасан хэрэг маш бага байгаа нь анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэлт сайн байгаа төдийгүй хуулийг буруу, зүйл заалтыг зөрүүтэй, дутуу хэрэглэсэн дутагдал бага ажиглагдаж байгааг харуулна (Улсын дээд шүүхээс шийдвэрлэсэн хэргийн тоон дүнг График 2-т оноор нь жагсаан харуулав)



*Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс цагаатгасан тогтоол гарсан хэргүүд (Шүүхийн цахим сангаас түүвэрлэв)*


2013 онд Анхан шатны шүүх 6169 хэрэг хянан шийдвэрлэснээс 12 хэргийг, 2014 онд 6375 хэргээс 72, 2015 онд 6756 хэрэг хянаснаас 8, 2016 онд 5762 хэрэг хянаснаас 6, 2017 онд 8839 хэрэг хянаснаас 5 хэргийг тус тус цагаатгах тогтоолоор шийдвэрлэсэн байна

2014 онд Анхан шатны шүүх 6375 хэргийг хянан шийдвэрлэсэн. Үүнээс 72 хэргийг цагаатгах тогтоолоор шийдвэрлэсэн ба түүний 13 хэрэг нь цагдан хоригдоод цагаатгагдсан хэрэг байна.

2015 онд Анхан шатны шүүх 11603 хүнд холбогдох 7998 хэргийг хүлээн авч 6756 хэргийг хянан шийдвэрлэсэн. Үүнээс 8 хэргийг цагаатгах тогтоолоор шийдвэрлэсэн байна.

2016 онд Анхан шатны шүүх 5762 хэргийг хянан шийдвэрлэсэн. Үүнээс 6 хэргийг цагаатгах тогтоолоор шийдвэрлэсэн байна.

2017 онд Анхан шатны шүүх 8839 хэргийг хянан шийдвэрлэсэн. Үүнээс 5 хэргийг цагаатгах тогтоолоор шийдвэрлэсэн байна. (Анхан шатны шүүхээс цагаатгагдсан хэргийн дүнг график 4-өөс харна уу)



Цагаатгагдсан хэргийн тоо жилээс жилд буурсан үзүүлэлттэй байгаа нь нэг талаас хүнийг хууль бусаар хорих шийтгэх явдал багассан болохыг харуулж байна. Нөгөө талаас, шүүхээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгохоос илүүтэй нэмэлт мөрдөн байцаалтад буцаах явдал нэмэгдэж байгаа болно.

*Судалгаанд хамрагдсан иргэдийн тайлбар, ярилцлага*

Судалгааны хүрээнд бид хууль бусаар гэмт хэрэгт шалгагдан цагдан хоригдож байгаад цагаатгагдсан зарим иргэнтэй уулзаж ярилцлага хийсэн бөгөөд тэд цагдан хоригдсон үндэслэл шалтгаан, хохирсон байдлын талаар дараах тайлбарыг өгсөн болно.

Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сангаас шүүлт хийхэд эрүүгийн хэрэгт цагдан хоригдож, цагаатгагдсан 45 шүүхийн шийдвэр гарч ирснээс бид тухайн иргэдтэй уулзах ажил зохион байгуулсны үр дүнд 17 иргэнтэй холбоо тогтоож чадсан.

*1. Улаанбаатар хотын ... дугаар хорооны Иргэн Т.*

*Би 188 хоног буюу бүтэн 6 сар цагдан хоригдсон. Гэр бүлийн хүнтэйгээ маргалдаж манай хүн хутга барьж над руу дайрахад*

нь би биеэ хамгаалж ноцолдож байгаад нөхөр нас барсан. Цагдан хоригдох хугацаанд маш хэцүү байсан. Сэтгэл зүйн хувьд байнгын тогтворгүй байдалтай, гурван хүүхдэдээ маш их санаа зовж байлаа. Биеэ хамгаалсныхаа төлөө ингээд л шоронд орчих гэж үү? Миний үр хүүхдүүдийг хэн харж хандах вэ? гэж маш их бодож шаналж байсан. Тухайн хэрэг болохоос өмнө би цэргийн газар ажилладаг байсан. Хэрэгт холбогдон шалгагдсанаас хойш ажлаа ч хийж чадахгүй хоригдоод анхан шатны шүүхээс цагаатгах тогтоол гарсан. Үүний дараа прокуророос давж заалдаад хэрэг маань нэмэлт мөрдөн байцаалтад буцсан ба прокуророос хэргийг хэрэгсэхгүй болгосон. Гэм буруугүй гэдэг маань тогтоогдоод суллагдсаны дараа ажилдаа эргэн орох гэтэл манай ажлын газрын Хүний нөөцийн ажилтан та одоо ажилдаа эргэн ороход хэн хэнд нь хэцүү, та мэдэж байгаа биз дээ. Угаасаа бид таны сул орон тоонд хүн авч ажиллуулж байгаа гэсэн хариу өгсөн. Тэгэхээр нь би Хил хамгаалах ерөнхий газарт хүсэлт гаргаад өөр салбар анги руу шилжүүлж өгөөч гэсэн хүсэлт гаргасан. Гэтэл одоо хүртэл миний хүсэлтийг шийдвэрлээгүй, бас ажлаас халсан тушаал гараагүй байгаа. Ажилтай байх хугацаандаа нөхөр бид хоёр тус тусдаа цалингийн зээл авсан байсан. Тэрийгээ төлж дуусаагүй банкнаас алданги тооцуулаад явж байна. Анх 7 сая төгрөгийн зээл авсан ч энэ хэргээс болж зээлээ төлж чадахгүй байсаар одоо 17 сая төгрөг төлөхөөр болсон, банкнаас залгаад байнга мөнгө нэхээд хэцүүхэн л байна.

Би хохирлоо арилгуулахаар шүүхэд хандах эрхтэй гэдгээ мэдэж байсан. Намайг өмгөөлж байсан өмгөөлөгч хэлж байсан. Гэхдээ тухайн үед маш удаан шүүх цагдаагаар яваад залхсан байсан болохоор энэ асуудлын талаар өргөдөл гаргахаа хэсэг хугацаанд хүлээе гэж бодсон. Яагаад гэвэл хэрвээ би энэ асуудлаар дахин шүүх цагдаатай орооцолдвол дахиад шүүхээр явах байх гээд айсан. Эргэж миний өмнөх хэргийг сөхөхгүй тэгээд үнэхээр баталгаатай гэвэл би та бүхэнтэй хамтран хохирлоо нэхэмжилмээр байна. Ядаж энэ хохирлоо нэхэмжилж банкны өр төлбөрөө барагдуулж гурван хүүхэдтэйгээ тайван амьдармаар байна.



2. Улаанбаатар хотын ... дугаар хорооны Иргэн Э.

Надад Хан-Уул дүүргийн прокуророос эрүүгийн хуулийн 148.4 дэх зүйл ангиар хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй эрүүгийн хэрэг үүсгээд шүүх рүү шилжүүлэхээр бэлдсэн байсан. Хан-Уул дүүргийн эрх бүхий албан тушаалтнууд үгсэн хуйвалдаад намайг хүнд гэмт хэрэгт гүтгэсэн. Дээрх албан тушаалтнуудын үйлдэл хууль бус гэдэг нь нотлогдсон. Бүтэн 2 жилийн хугацаанд миний хилээр орж гарах эрх, бусад үйл ажиллагаа явуулах эрхийг бүгдийг нь зогсоосон. Анх 2012 онд миний бичсэн хөрөнгө оруулалтын төсөл 110 сая доллар болсноос 77 сая доллар нь шийдэгдсэн байсан. Уг төслийг хөөцөлдөж өгнө гээд олны танил, нэр бүхий хүн 100 мянган доллар 175 сая төгрөгийг надаас авсан. Би тухайн үед энэ мөнгийг хүнээс зээлж авч өгсөн байсан. Ердөө ийм асуудлаас болоод би өөрөө хэрэгт гүтгүүлж 10 хоног цагдан хоригдсон, надаас мөнгө зээлсэн байж намайг эргүүлээд хэрэгт унагах төлөвлөгөөтэй байсан. Дээрээс нь би өөрөө УЕПГ-т гомдол гаргаад хэргийн харьяаллаа тогтоолгосон. Үүний дараагаар Сүхбаатар дүүргийн шүүхэд хохирогчоор тогтоолгох хүсэлт гаргасны дагуу Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийнхэн ажиллагаа явуулаад олны танил, нэр бүхий эрхмийг надаас 175 сая төгрөг авсан бичлэгийг олсон. Ингээд миний тэр хүнээс залилсан гэх 175 сая төгрөгийг хэрэгсэхгүй болсон. Надаас авсан 100 мянган доллараа хүртэл өгөөгүй л байгаа аваагүй гэж гүрийгээд. Энэ хүний эцсийн зорилго нь Хөгжлийн банк дээр явж байсан миний төслийг унагаж хэрэгжүүлэхэд бэлэн болсон төслийг өөртөө авах зорилготой байсан юм байна лээ. Тэр хүний санаа бүтэж намайг үйл ажиллагаа явуулах эрхгүй байх хугацаанд миний төслийг өөрөө авч одоо хэрэгжүүлээд явж байгаа.

Төслийн зардалд 380 мянган доллар зарцуулсан ба энэ мөнгөөр хохирсон. Нэр төр сэтгэл санаанд учирсан хохирлоо хэнээс гаргуулах вэ? (тус буруутай этгээдүүдэд хариуцлага тооцуулмаар байна). Хэрэг шалгагдаж байх хугацаанд бүх төрийн байгууллага руу миний талаар алдарт гэмт хэрэгтэн, залилагч гэсэн агуулга бүхий албан бичгүүд очсон байсан. Үүнээс болоод би ажилд орж чадахгүй болсон.

*Прокурор, мөрдөн байцаагч, анхан шатны шүүхийн ажлын хариуцлагыг нэмэгдүүлмээр байна. Би хохирол шаардах эрхтэй гэдгээ мэдэж байсан ч бүтэн 2 жилийн турш цагдаа, шүүхтэй орооцолдсон болохоор үнэндээ халширсан. Хууль хяналтын байгууллагад итгэх итгэл алдарсан.*

*3. Улаанбаатар хотын ... дугаар хорооны Иргэн Ө.*

*Би аялал жуулчлалын чиглэлээр бизнес эрхэлдэг байсан. Зарын сонин дээрээс оффис зарна гэх зарын дагуу нэгэн эмэгтэйдгээс үл хөдлөх худалдаж авахаар болсон. Тэр эмэгтэйд яаралтай 100 сая төгрөг хэрэгтэй байсан юм билээ. Банкинд тухайн үл хөдлөхийг барьцаалан зээл авсан байсан ба надад 500 саяар зарсан гэж гэрээ хийгээд банкныхаа өрийг төлөөд надаар тухайн үл хөдлөхийг эргүүлэн банкинд тавиулсан. Би худалдаж авсан үл хөдлөх хөрөнгийн мөнгийг бага багаар төлж байсан. Тухайн үед би алтны уурхайн орд эзэмшихээр болоод түүнтэй холбоотой асуудлаар АНУ руу нисэхээр боллоо гэж ярихад намайг мөнгөө төлөхгүй зугтсан, үл хөдлөхийг нь залилсан гээд цагдаад өргөдөл гаргаад прокурорт миний хэрэг очсон байсан. Үүнээс болоод би хүн залилсан болж цагдан хоригдсон ба үл хөдлөхийг банкнаас барьцаалахад хэрэглэсэн мөнгөө хүнээс зээлж өгсөн байсан. Олон хоног цагдан хоригдоод дээрээс нь үйл ажиллагаа эрхэлж болохгүй, гаднаас авах хөрөнгө оруулалт зогссон. Би өөрөө сүүлдээ хүнээс хүүтэй мөнгө зээлсэн байсан болохоор тэр хүүгээ бас өөрөө төлөөд бөөн өрөнд унаад байсан учир өөрийн эзэмшдэг бүх үл хөдлөх зарж болох юу байна бүгдийг нь зарж өрөө төлсөн. Надад прокурор шүүхэд гомдох зүйл байхгүй ээ. Намайг залилсан, надад үл хөдлөх хөрөнгө зарсан хүүхнээс мөнгө нэхэмжилмээр байна. Хохирол нэхэмжлэх эрхтэй гэдгээ мэдэж байсан. Гэхдээ шүүхэд хандаагүй учир нь хохирол гаргуулдаг тохиолдол цөөн, бага дүнгээр хохирол гаргадаг гэж сонсон учраас хэзээ нэгэн өдөр нэхэмжлэл гаргана гэж бодож явсан. Би та бүхэнтэй хамтран ажиллахад бэлэн байна. Хэргээ шийдүүлэхийн тулд олон сар цагдаа прокурорын үүд сахисан болохоор дахин шүүх цагдаагийн байгууллагаар явах итгэлгүй болсон. Та бүхнийг над шиг*

*хохирсон олон хүний эрх ашгийг хамгаалахын тулд тодорхой ажлууд хийж байгаад баяртай байна.*

Цагаатгагдсан иргэд хохирол нэхэмжлэх эрхээ мэддэг ч тэдэнд түүнийг нэхэмжлэх зориг нь мохсон байдаг. Учир нь цагаатгагдсан иргэд цагдан хоригдож байх хугацаандаа хэтэрхий их сэтгэл зүйн дарамтад өртдөг ба үүнээсээ болоод дахин шүүх, прокурорын байгууллагатай холбогдохыг хүсдэггүй болох нь харагдаж байна.

Дээрх ярилцлага нь анкетын судалгааг үндэслэхгүйгээр цагдан хоригдсон нь тогтоогдсон 15 иргэнээс авсан болно. Ярилцлагаар цагдан хорих бодит үндэслэл байсан эсэх, хэдий хугацаанд хоригдсон, ямар хохирол учирсан, хохирлоо нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авсан эсэхийг мэдэхийг зорьсон болно. Судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 60 хувь нь дахин шүүх цагдаагийн байгууллагаар явж хохирлоо арилгуулах сонирхолгүй байгаага илэрхийлсэн бөгөөд шалтгаан нь хууль хяналтын байгууллага шударга ажилладагт эргэлзсэн, дахин хэргийн хохирлын талаар ярьвал буруутаж хэрэгт орохоос айсан, итгэл алдарсан тухайгаа илэрхийлсэн юм. Харин судалгаанд оролцсон хүмүүсийн 33 хувь нь хохирлоо нэхэмжлэх хүсэлтэй байсан бөгөөд шүүхээр хохирлоо гаргуулж зөрчигдсөн эрхээ сэргээлгэх нь чухал болох талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн.

Дээрх судалгааны үр дүнд тулгуурлан эрүүгийн хэрэгт хууль бусаар шалгагдаж цагдан хоригдоод цагаатгагдсан иргэд хэрхэн хохирдог, хохирол нөхөн төлүүлэх эрх зүйн боломж ямар байгааг судлах нь хүний эрхийн хамгаалалтын түвшин ямар байгааг олж харах, зохих үнэлэлт дүгнэлт өгөхөд ач холбогдолтой юм.

## **2. Шүүхээр цагаатгагдсан иргэдийн цагдан хоригдсоноос үүдсэн хохирол, түүнийг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт**

### **2.1 Хууль бусаар цагдан хоригдсоны улмаас учирсан хохирол**

Эрүүгийн хэрэгт шалгагдаж хууль бусаар цагдан хоригдсон этгээд нь бие махбодь, сэтгэл санааны хувьд ихээхэн хохирдог нь ойлгомжтой.

Харин энэхүү хохирлыг хэрхэн тооцох, үнэлэх, шүүхээс ямар хэмжээнд барагдуулж байгаа нь сонирхон судлах асуудал мөн.

ЭБШТХ-ийн 45.1 дэх хэсэгт «Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах, тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй» гэж зааснаас харахад хохирол гэдэгт эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг тодорхой дурдаж өргөн хүрээнд тодорхойлж өгчээ.

ЭБШТХ-ийн 45.3 дахь хэсэгт нөхөн төлөгдөх эд хөрөнгийн хохирлыг тодорхойлохдоо:

- Хууль бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлого;
- Хууль бусаар хорих ял шийтгүүлсний улмаас зогсоосон тэтгэвэр, тэтгэмж;
- Шүүхийн шийдвэрээр хураасан, улсын орлого болгосон болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын гаргуулсан эд хөрөнгө, орлого, эд зүйл;
- Шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж гаргуулсан мөнгөн төлбөр; иргэн, хуулийн этгээдээр төлүүлсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад зардал;
- Хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг эдийн хөрөнгөд хамруулахаар нарийвчлан зохицуулжээ.

Харин Иргэний хуульд хохирлыг эдийн ба эдийн бус хохирол гэж тодорхойлсон ба Иргэний хуулийн 229.1 дэх хэсэгт эд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг эдийн хохирол гэж заасан бол мөн хуулийн 497.1 дэх хэсэгт «Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай болон болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд тэр этгээдээр зардлаа нөхөн төлүүлэхийг шаардаж болно» гэснээс харахад эдийн хохирлоос гадна эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг эдийн бус хохиролд тооцож хамгаалахаар заажээ.

Тэгвэл хохирлыг шүүхийн практикт хэрхэн ойлгож тодорхойлж байгааг холбогдох иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдээс харахад дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэслэлгүй цагдан хоригдсоны улмаас учирсан хохирол (цалин хөлс, олох байсан орлого);
- Эрүүл мэндийн хохирол (эмчилгээ, үйлчилгээний төлбөр);
- Хууль бусаар цагдан хоригдсоны улмаас учирсан зардал (замын зардал, байрны зардал, өмгөөлөгчийн хөлс);
- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр төр гутаагдсаны хохирол;
- Ажлаас үндэслэлгүй халагдсаны хохирол;
- Сэтгэл санааны хохирол.

Эндээс үзэхэд хохирсон иргэд хуульд заасны дагуу өөрсдөө хохирлоо тодорхойлж байгаа ч нийтлэг жишгийн дагуу дээр дурдсан хохирлын төрлийн хүрээнд л шүүхэд нэхэмжлэл гаргаж байна. Гэтэл ЭХШХтХ-д тэтгэвэр тэтгэмж авах, орон сууц эзэмших, бусад эрхэд учирсан хохирлоо гаргуулах боломжийг олгосон байдаг бөгөөд энэхүү хохирлоо гаргуулах талаар шүүхэд хандаж нэхэмжлэл гаргаж байгаа нь харьцангуй цөөн байна.

Хууль бусаар цагдан хоригдож хохирсон иргэд учирсан хохирлоо тодорхойлохдоо нийгмийн амьдралд идэвхтэй оролцож чадахгүй болсон, ажилдаа явж чадахгүй болсон, ажлаас халагдсан шагнал урамшууллаасаа хасагдсан, гэр бүл, эцэг эх, үр хүүхэд нь хүндлэхээ больсон, гэр бүлээ цуцалсан, найз нөхөд, ажлын хамт олон, хамаатан садангийн дунд нэр хүндгүй болсон, орлогогүй болж өр төлбөрт унасан, эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд хохирсон гэж тодорхойлж байгаагаас үзвэл иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхээс гадна хөдөлмөрлөх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, гэр бүлтэй байх гэх мэт бусад үндсэн эрхүүд давхар давхар зөрчигдөж хохирдог байна. Иймд хууль бусаар цагдан хоригдож цагаатгагдсан иргэдийн хохирлыг нөхөн төлж арилгах, зөрчигдсэн эрхийг сэргээх асуудалд төрөөс онцгой анхаарч ажиллах нь зүйтэй.

## 2.2 Хууль бусаар цагдан хоригдсоны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал

Эрүүгийн хэрэгт хууль бусаар шалгагдаж цагдан хоригдсон этгээдийн гэм буруугүй болох нь тогтоогдсон тохиолдолд түүний зөрчигдсөн эрхийг сэргээж учирсан хохирлыг нөхөн төлүүлэх явдал нь шударга ёсны илэрхийлэл бөгөөд хүний эрхийн хамгаалалтын бодит үр дүн болох юм. Хууль бусаар цагдан хоригдсон этгээд нь бие махбодь, оюун санаа, эд хөрөнгийн хувьд асар их хохирдог бөгөөд төрийн албан хаагчдын (мөрдөн байцаагч, прокурор, шүүгч) үйл ажиллагааны улмаас хохирогч болдог. Энэ утгаар нь ЭБША-ны хохирогчтой адилтган авч үзэж болох юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийн эрхийг хамгаалах нь хүний эрхийн тулгуур зарчмуудын нэг бөгөөд үүнийг дэлхийн улс орнууд дотоодынхоо хууль тогтоомжоор зохицуулсан байдаг<sup>114</sup>. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан «Гэмт хэрэг болон албан тушаалын үүргээ урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал»-ын заалтаас харахад хохирогч гэдэгт «...Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие махбодийн болон оюуны санааны гэмтэл учирсан, эсхүл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн бие хүн болон хамт олныг хэлнэ» гэж тодорхойлсон байх бөгөөд энэхүү тодорхойлолтын хүрээнд авч үзэхэд хууль бусаар цагдан хоригдсон этгээдийг ЭБША-ны хохирогч гэж үзэхэд хүндрэлтэй харагдаж байна. Учир нь хууль бусаар цагдан хоригдсон этгээдийн хувьд эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувиар оролцож байгаад шүүх, прокуророос хуульд заасан үндэслэлээр гэм буруугүй нь тогтоогдож суллагдсан байдаг бөгөөд мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд л хохирол нөхөн төлүүлэх эрх үүсдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн хохирогч гэх статуст багтдаггүй байна. Иймээс энэ төрлийн хэргийн хохирогчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох

<sup>114</sup> « Хүний эрх сэтгүүл» 2005 он, №2, 14 дахь тал

нь зүйтэй юм. Хэдий тийм боловч манай улсын хувьд хууль бусаар цагдан хоригдож цагаатгагдсан иргэд учирсан хохирлоо арилгуулах эрх зүйн үндэс тодорхой хэмжээнд хангагдсан гэж үзэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хүний үндсэн эрх, эрх чөлөөний нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлж хамгаалахаар зааснаас гадна тус хуулийн 16.14-т «...иргэн нь бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй» гэж заажээ. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5-д «Хууль бусаар баривчлагдаж, эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй» гэж заасан байна. Баривчлагдаж буюу цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр түүнийг хорьсон хууль эрхийн үндэслэлийн талаар шүүхийн тогтоол нэн даруй гаргуулах, хэрэв хууль бусаар хоригдсон бол суллуулах шийдвэрийг шүүхээр гаргуулах эрхтэй. Хууль бусаар цагдан хоригдож хэлмэгдсэн хүн бүр хохирлоо нөхөн төлүүлэх, нэхэмжлэл гаргуулах эрхтэй<sup>115</sup>.

Дээр дурдсанчлан манай улсын хувьд хохирол нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг Үндсэн хууль болон олон улсын гэрээ конвенцийн хүрээнд баталгаажуулсан бөгөөд иргэд хохирлоо нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг Иргэний хуулийн 498.4 дэх хэсэгт заасны дагуу иргэний журмаар арилгуулах хуулийн зохицуулалт бий.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЭХШХШтХ-д «Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч прокурор, мөрдөн байцаагч эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай» асуудлыг 45 дугаар бүлэгт зохицуулсан байдаг бөгөөд Хохирол арилгуулах эрх, хохирол нөхөн төлүүлэх үндэслэл, эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх, сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах, хэргийг хэрэгсэхгүй болгосны лавлагаа өгөх, хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах, хохирол арилгуулах тухай нэхэмжлэл гаргах талаар нарийвчлан зохицуулсан бол ИХШХШтХ-д энэ төрлийн хохирлыг гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүйд хамааруулан

<sup>115</sup> «Хүний эрх» «Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл» 1992 он НҮБ. УБ хот



Иргэний хуулийн 498.4-т тусгайлан зааж өгсөн байна.

Дээрх хуулийн зохицуулалтын онцлог нь Хууль бусаар явуулсан ажиллагааны улмаас учирсан хохирлыг мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгахаар заасан явдал юм. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд «Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай» шинэ бүлгийг (44 бүлэг) нэмж оруулсан нь уг хуулийн өмнөх хуулиасаа ялгагдах гол онцлог болсон<sup>116</sup> бол 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өмнөх хуулийн зохицуулалтыг сайжруулан илүү тодорхой болгосон байдал харагдаж байна. Тухайлбал, Хохирол арилгуулах эрхийн тухай асуудлыг өмнөх хуульд «...эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, эдийн бус хохирлын үр дагаврыг арилгуулах» гэж заасныг 2015 оны ЭХШХШТХ-д «...эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах... гэж эдийн бус хохирлыг...» гэж тодорхой болгож зохицуулсан байна. Хууль тогтоомжид дээр дурдсан өөрчлөлт хийгдэж эрх зүйн орчин сайжирч байгаа боловч практикт хохирсон иргэд хохирлоо хангалттай хэмжээнд арилгуулж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Иргэд хохирлоо иргэний журмаар нэхэмжилж байгаа боловч ихэнх тохиолдолд нэхэмжлэлийн багахан хэсгийг л шүүхээс хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгож байна. Энэ нь нэг талаас, нэхэмжлэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй байдал, эрх зүйн мэдлэг, нэхэмжлэлээ нотолж буй байдалтай холбоотой боловч нөгөө талаас, хохирол арилгуулах эрх зүйн зохицуулалт хангалттай бус, тодорхойгүй байгаатай шууд холбоотой байдал ажиглагдсан. Тухайлбал, эдийн бус хохирлыг нөхөн төлөх, үр дагаврыг арилгуулах нэхэмжлэлийн шаардлагыг шүүхээс ихэнх тохиолдолд хэрэгсэхгүй болгож, эсхүл нэхэмжлэлийн шаардлагаас багахан хэмжээнд хангаж шийдвэрлэж байгаа практик байна. Иргэний хуульд эд хөрөнгийн бус сэтгэл санааны хохирлыг мөнгөөр

<sup>116</sup> «Хүний эрх сэтгүүл» 2005 он, №2, 14 дэх тал



нөхөн төлүүлэх талаар хуулийн зохицуулалт тодорхой бус байгаагаас практикт хохирол гаргуулахад хүндрэлтэй, шүүгч хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх боломжгүйгээс өөрийн дотоод итгэлээр шийдвэрлэхээс аргагүй байдалд ордог.

Иргэний хуулийн 229.1-д «Үүрэг бүхий этгээд нь гэм хорыг арилгахдаа эд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг нөхөн төлөх үүрэгтэй», Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн 391.1-д «эд хөрөнгийн бус хохирлыг иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө», Иргэний хуулийн 230.2-г «гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө» гэж заасан зохицуулалт нь эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх боломжийг хязгаарласан шинжтэй байхаас гадна эдийн бус хохирлыг хэмжих, үнэлэх талаар зохицуулалт байхгүйгээс нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаадлагаа тодорхойлоход хүндрэлтэй байна.

Улсын дээд шүүхийн иргэний танхимын 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолд «Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах» талаар тусгажээ. Уг тогтоолд «сэтгэл санааны үр дагавар» гэдэгт хууль бус ажиллагааны улмаас зовон тарчилсан, сэтгэл зүйн дарамтад орсон, айж балмагдсан, сэтгэл гутрал, сэтгэцийн өвчин эмгэгтэй болсон, нэр төр алдар хүндээрээ хохирсон зэргийг ойлгоно» гэж тодорхой заасан ч үүнийг мөнгөн хэлбэрээр хэрхэн хэмжих, үнэлэх талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 2-т «Баривчлагдан цагдан хоригдсон нэг хоногийг торгох ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож эдлэх ялаас хасна» гэж заасан нь 2002 оны эрүүгийн хуулийн 59.3-г заасан зохицуулалтаас дордсон байх тул шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1-д зааснаар өмнөх Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж, шүүхээс хохирогчийн мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгахдаа хуучин хуулийг буцааж хэрэглэн, шийдвэрлэж байна.

Эрүүгийн хуулийн цагаатгасан буюу хэрэгсэхгүй болгосон тухай тогтоолын хуулбарыг хохирсон иргэнд өөрт нь гардуулан өгөх буюу шуудангаар илгээх тухай заалт хуульд байдаг. Үүний хамт хохирлоо нөхөн төлүүлэх журмыг хамтад нь тайлбарлах, шүүхэд хэрхэн хандаж эрхээ сэргээлгэх, ямар журмаар нэхэмжлэл гаргах, шүүхэд хандах хугацаа болон харьяаллын талаарх мэдээллийг тухайн иргэнд хүргүүлсэн байх ёстой. Энэхүү хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгждэг эсэх нь тодорхойгүй байна. Судалгаанд оролцсон иргэдийн хувьд хууль бусаар цагдан хоригдсоны улмаас учирсан хохирлоо арилгуулах эрхтэй болохоо мэдэж байсан боловч шүүхэд хандсан нэг ч иргэн байгаагүй нь иргэд хуульд заасан эрхээ мэдэхгүй байгаагаас бус хууль хяналтын байгууллагын шударга байдалд итгэл алдарсантай холбоотой байна.

Хохирол нөхөн төлүүлэх эрхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар шийднэ гэж заасан боловч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд гэсэн ангилалд энэ заалт байхгүй байгаа нь хуулийг практикт нэг мөр ойлгон хэрэглэхэд хүндрэл учруулж байна.

### **2.3. Шүүхийн практикт тулгамдаж буй асуудал**

#### *1. Хууль бусаар цагдан хоригдсон хугацааны хохирлыг тооцох аргачлал байхгүй*

Манай улсад хууль бусаар цагдан хоригдсон хугацааны хохирлыг тооцон гаргах аргачлал хуульд байхгүйгээс шүүгч бүр харилцан адилгүй аргачлал ашиглаж байна. Энэ нь хуулийг нэг мөр хэрэглэх, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмуудтай зөрчилдөж байна. Ижил төрлийн нэхэмжлэлтэй хэргүүдэд харилцан адилгүй аргачлал ашигласнаас хохирлын хэмжээ илт зөрүүтэй бодогджээ. Тухайлбал:

- А. Цагдан хоригдсон хоногийн тоог хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр үржүүлэн тооцсон<sup>117</sup>;
- В. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажлын нэг цагийн үнэлгээг бодож ажлын найман цагаар үржүүлж цагдан хоригдсон хоногт үржүүлэн тооцсон<sup>118</sup>;
- С. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ажлын 21.5 хоногт хуваан нэг өдөрт ногдох хөлсийг тооцон цагдан хоригдсон хоногоор үржүүлэн тооцож байна<sup>119</sup>.

Цагдан хоригдсон хоногийн тоог хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр үржүүлэн тооцсон эхний тохиолдолд шүүхээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэсэн байх бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 2-т «Баривчлагдаж цагдан хоригдсон нэг хоногийг торгох ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож эдлэх ялаас хасна» гэж заасан нь 2002 оны Эрүүгийн хуулийн 59.3-т заасан зохицуулалтаас дордсон байх тул шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1-д зааснаар өмнөх Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж, шүүхээс хохирогчийн мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгахдаа хуучин хуулийг буцааж хэрэглэн шийдвэрлэж байна. 2002 оны Эрүүгийн хуулийн 59.3-т «Цагдан хоригдсон этгээдэд торгох буюу тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан бол цагдан хоригдсон хугацааг харгалзан шүүх уг ялыг хөнгөрүүлэх буюу ял эдэлсэнд тооцож болно. Цагдан хоригдсон этгээдэд торгох ял оногдуулсан бол цагдан хоригдсон нэг хоногийг тухайн үед мөрдөгдөж байгаа нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлж, торгох ялаас хасч тооцно» гэжээ. Жишээ нь, 2016 оны 04 сарын 02-ны өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл 140 хоног хууль бусаар

<sup>117</sup> Багануур дүүргийн шүүхийн 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн №3060 шийдвэр

<sup>118</sup> Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 сарын 07-ны өдрийн №3060

<sup>119</sup> Сүхбаатар аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 06 сарын 16 өдрийн №278 тоот шийдвэр

цагдан хоригдсон гэж үзье. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2013 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн цагт 1142.85 төгрөг буюу сард 192600 мянган төгрөгөөр тогтоосон байх тул цагдан хоригдсон нэг хоногийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 192.600 төгрөгөөр тооцон ( $140 \times 192600 = 26.964.000$ ) нэхэмжлэгчид олгосон байна. Ийнхүү хуульд тодорхой аргачлал байхгүйгээс шүүгч бүр өөр аргачлал ашиглаж байгааг арилгаж хуулийг боловсронгуй болгох нь зүйтэй.

*2. Хууль бусаар цагдан хоригдсон этгээдийн хохирлыг нотлох, үнэлэх асуудал*

Шүүхийн практикаас харахад эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх нэхэмжлэлийн шаардлага бүхий иргэний хэргийг 2 үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байна. Үүнд:

1. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх хууль зүйн зохицуулалт байхгүй;
2. Нэхэмжлэгч хохирлоо баримтаар нотолж чадаагүй гэх үндэслэл болно.

Нэгдүгээр үндэслэлийн хувьд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх хуулийн зохицуулалт дутмаг, боловсронгуй бус байгаа нь үнэн бөгөөд энэ төрлийн хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоогчийн зүгээс зориуд хязгаарласан шинжтэй зохицуулалттай учир эдийн бус гэм хорын хохирлыг гаргуулахад хүндрэлтэй байна. Гэвч Иргэний хуулийн 498.4, 230.2 дахь хэсгийг удирдлага болгон 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж сэтгэл санааны гэм хорын хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлж болохоор Улсын дээд шүүхийн тайлбарт заасан ч энэ нь практикт хэрэгждэггүй. Учир нь эдийн бус хохирлын хэмжээг тогтооход хэцүү байдаг бөгөөд нэхэмжлэгч өөрөө тогтоосон шаардлагын хэмжээнд хүртэл шүүхээс өөрчлөх хуулийн зохицуулалт байхгүйгээс шүүхээс үндэслэлгүйгээр нэхэмжлэлийн шаардлагыг багасгах, эсхүл хэрэгсэхгүй болгодог практик тогтсон байна.

Хоёрдугаар үндэслэлийн хувьд шүүхээс сэтгэл санааны хохирлыг нөхөн арилгуулахад тодорхой нотлох баримт буюу эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээ авсан баримт, сэтгэц мэдрэлийн өөрчлөлтийн баримт байна уу?... гэх мэтээр нэхэж энэ төрлийн нотлох баримт шаардаж байгаа практикийг өөрчлөх нь зүйтэй. Шүүхээс сэтгэл санааны хохирлыг энгийн дундаж хүний сэтгэл санаанд нөлөө үзүүлэх байдлаар нотлогдож буй фактын хүрээнд дүгнэж үзэхэд л хангалттай юм. Өөрөөр хэлбэл, хилсээр цагдан хоригдсон хугацаа, эрүүл мэндийн байдал, нэр төр гутаагдсан байдал гэр бүлийн байдал гэх мэт харгалзан үзвэл зохих байдлууд нотлогдож байхад дахин өөр баримтууд шаардаж байгаа нь үндэслэлгүй юм. Иргэний хуулийн хохирол арилгуулах гэсэн хуулийн нэр томъёоноос үүдэлтэйгээр хохирлоо нотлох шаардлага тулгардаг бөгөөд дэлхийн жишигт нэгэнт учирсан хохирол, эдэлсэн зовлон шаналал, хязгаарлагдсан эрх чөлөө, алдагдсан боломжийг олж авах, арилгах боломжгүй тул нөхөн төлөх, нөхөн олгох гэсэн байдлаар хуульчилсан байдаг.

#### **2.4 Хууль бусаар цагдан хоригдсоны улмаас учирсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх асуудал (Харьцуулсан судалгаа)**

Олон улсын гэрээ, конвенцээр хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг тунхаглаж, халдашгүй эрхэд хууль бусаар халдсан тохиолдолд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, учирсан хохирлоо арилгуулах эрхтэйг заасан байх бөгөөд дэлхийн улс орнууд энэхүү эрхийн хамгаалалтад анхаарч эрх зүйн орчноо боловсронгуй болгож байна. Тухайлбал, Япон Улс хууль бусаар цагдан хоригдсон этгээдэд учирсан хохирлыг арилгах тухайд Нөхөн олговрын тухай хууль баталсан байдаг. Энэхүү харилцааг зарим улсад хэрхэн зохицуулсныг авч үзье.

##### **Япон Улс**

Япон Улсад хууль бусаар цагдан хоригдсон, албадан саатуулагдсан этгээд гэм буруугүй нь тогтоогдвол бие махбодийн эрх чөлөөгөө хасуулсны төлбөрөө төрөөс шаардах эрхтэй байдаг. Энэхүү эрхийг хангах баталгаа болгож Эрүүгийн хэргийн нөхөн олговрын тухай хууль баталжээ. Нөхөн олговор гаргуулах эрх нь Нөхөн төлбөр

шаардах эрх, Зардал шаардах эрх гэсэн хоёр төрөлтэй.

**Нөхөн төлбөр шаардах эрх:** Энэ хуульд нөхөн олговор олгох үндэслэл, нөхөн төлбөрийн хэмжээг нарийвчлан тогтоож өгсөн. Тухайлбал, хууль бусаар цагдан хоригдсон албадан саатуулагдсан тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээ нь 1 хоногийн доод тал нь 1000 иен, дээд тал нь 12500 иен байна. Мөнгөний нийт хэмжээг тогтоохдоо албадлагын арга хэмжээний төрөл, хугацааны урт богино, эд хөрөнгийн хохирол, олох байсан орлого, ашгийн алдагдал, сэтгэл санааны хямрал, бие махбодийн гэмтэл болон цагдаа, прокурор, шүүгчийн шийдвэрт санаатай гэм буруугийн хэлбэр байгаа эсэхийг харгалзан тогтоодог байна. Хэрэв шүүгдэгч нас барвал гэр бүлийн гишүүнд нь нөхөн олговор олгодог байна.

**Зардал шаардах эрх:** Цагаатгах тогтоол гарсан тохиолдолд улс нь тухайн хэргийн яллагдагч байсан этгээдэд зөвхөн шүүхийн шатанд гарсан зардлыг нөхөн олгохоор хуульчилсан. Зардалд шүүх хуралдаанд биеэр оролцоход гарсан замын зардал, өдөр тутмын хэрэглээний зардал, байрны зардал, өмгөөлөгчийн хөлс хамаарна. Эдгээр зардлыг нарийвчлан тогтоосон байдаг ба мөнгөн дүнг тооцох аргыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын тухай хуулиар зохицуулдаг. Харин өмгөөлөгчийн зардлыг нийтлэг стандартаар хамгийн доод хэмжээгээр тогтоодог.

Хууль зөрчсөн ажиллагааны улмаас мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, хүнийг хууль бусаар хохироосон нь тогтоогдвол хариуцлагыг хууль тогтоомжид заагдсанаар хүлээхээс гадна хэрэв үйлдэл эс үйлдэхүй нь гэмт хэрэг болох нь тогтоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр заасан байна.

### **Бүгд Найрамдах Хятад Ард Улс<sup>120</sup>.**

БНХАУ-ын хуулийн үзэл баримтлалд хуулийн этгээдээс бусдад учруулсан гэм хорыг арилгах нь гэм хор учруулагчийн нуруун дээр дааж давшгүй ачаа болж түүний хэвийн үйл ажиллагаанд дарамт болох учиргүй гэж үздэг бөгөөд иймээс учруулсан хохирлыг төрөөс барагдуулдаг байна. БНХАУ-д эрүүгийн процессын ажиллагааны

<sup>120</sup> Д.Мөнхбаатар, ЭБША-ны явцад иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ, 2016 он 25 тал

явцад хохирсон иргэний эрхийг сэргээх, учруулсан хохирлыг нөхөн төлөх ажиллагаа нь 1994 онд БНХАУ-ын бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн 7 дугаар хурлаар төрийн байгууллага, албан тушаалтнаас иргэдэд гэм хор учирсан гэх үндэслэл, хохирол барагдуулах журам, хохирлын хэмжээг тогтоох стандарт зэргийг зохицуулсан 6 бүлэгтэй БНХАУ-ын төлбөрийн хуулийг баталсан нь 1995 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэ хуулиар хохирол барагдуулах хэмжээ хязгаар, хохирол барагдуулах шаардлага гаргах эрх бүхий субъект, хохирол барагдуулах журам, хохирол барагдуулах арга, хэлбэр хэмжээ, стандарт зэргийг хуульчлан тогтоосон. Энэ хуулийн 15 дугаар зүйлд «Мөрдөн байцаах, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон түүний албан тушаалтнаас дор дурдсан үүрэг гүйцэтгэх явцад учруулсан гэм хорыг арилгуулах эрхтэй» гээд дараах үндэслэлийг тодорхойлж өгчээ. Үүнд:

1. Гэмт хэргийн бодит нөхцөл байдлыг бүрэн тогтоогоогүй, нотлох баримтыг дутуу бүрдүүлж цагдан хорьсон;
2. Ялаа эдлээд дууссаны дараа гэм буруугүй нь тогтоогдож цагаатгагдсан;
3. Эрүү шүүлт тулган зодох, хууран мэхлэх замаар мэдүүлэг авч хүний биед гэмтэл учруулсан, улмаар амь насыг хохироосон;
4. Галт зэвсэг, тусгай хэрэгслийг хууль бусаар хэрэглэж хүний биед гэмтэл учруулсан, улмаар амь насыг хохироосон үндэслэлүүдийг тодорхойлжээ.

Мөн хуулийн 16 дугаар зүйлд зааснаар мөрдөн байцаах, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон түүний албан тушаалтнаас үүрэг авах явцдаа хууль бусаар эд хөрөнгийг битүүмжилсэн, захиран зарцуулах эрхийг хязгаарласан, эд хөрөнгө хураан авсан, торгох, эд хөрөнгө хураах ял шийтгүүлээд цагаатгагдсан этгээд тухайн эд хөрөнгөө нөхөн төлүүлэх эрхтэй гэж заажээ. Харин хохирогч өөрөө зориуд худал мэдүүлэг өгсөн, нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлснээс цагдан хоригдсон, дээрх албан тушаалтны албан үүрэгтэй нь холбогдолгүйгээр хохирол учруулсан, хохирогч өөрийн биедээ санаатай гэмтэл учруулсан зэрэг тохиолдолд учирсан хохирлыг төр хариуцахгүй.

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Үндэслэлгүйгээр цагдан хоригдсон бол цагдан хорих, баривчлах тухай шийдвэр гаргасан байгууллага, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас ял эдлээд шүүх болон давж заалдах шүүхээр тухайн хэрэг цагаатгагдсан бол анхан шатны шүүх хуульд зааснаар хохирлыг хариуцна.

### **Англи Улс**

Англи Улсын тухайд аливаа этгээд хариуцлагад татагдаж шийтгүүлсэн боловч хожим шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хилс ял эдэлсэн нь тогтоогдож цагаатгагдсан бол Төрийн нарийн бичгийн дарга тухайн үйлдлийн улмаас хохирсон этгээдэд нөхөн төлбөр олгох хуулийн зохицуулалттай. Төрийн нарийн бичгийн дарга нөхөн олговор олгох эсэх асуудлыг шийдвэрлэдэг боловч түүний үнэлгээг Төрийн нарийн бичгийн томилсон бие даасан үнэлгээчин тогтоодог бөгөөд үнэлгээ тогтоохдоо дараах нөхцөл байдлыг харгалзан үздэг. Үүнд:

- Тухайн хүнийг эрүүгийн хариуцлагад татсан гэмт хэрэг болон түүнд оногдуулсан ялын хүнд, хөнгөн;
- Тухайн гэмт хэргийн мөрдөн байцаалт, яллах үйл ажиллагаа явагдсан байдал;
- Түүнээс үүдэлтэйгээр хохирогч бусад гэмт хэрэг үйлдсэн эсэх, болон түүнд оногдуулсан ялын хэмжээг харгалзан үздэг байна.

Нөхөн төлбөрийн үнэлгээг иргэний эрх зүйн зөрчлийн улмаас учирсан хохирлын үнэлгээтэй ижил байдлаар хийдэг байна. Нөхөн төлбөрийн ердийн хэмжээг 500 000 паунд, 10-аас дээш жил хоригдсон бол 1 000 000 паунд байхаар хуульчилжээ.

Монгол Улсад тулгамдаад буй эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг гадаад улс орнууд хэрхэн шийдвэрлэсэн талаар авч үзье.

### **Англи болон АНУ**

Нийтлэг эрх зүйн системд сэтгэл санааны гэм хорын талаарх нэр томъёог нэгдмэл болгосон, шийдвэрлэгдсэн гэж судлаачид үздэггүй ба «сэтгэл зүйн гэм хор», «сэтгэцийн гэм хор» мэдрэлийн шок,



ердийн шок гэсэн нэр томъёог өргөн хэрэглэдэг байна<sup>121</sup>. Эдгээр нэр томъёоны ялгаатай байдлаас сэтгэл санааны гэм хорын ойлголтод янз бүрийн үзэл баримтлал хэрэглэх арга байдаг байна.

**Сэтгэл санааны гэм хорын хохирол төлүүлэх:** Ерөнхийлөн авч үзвэл нийтлэг эрх зүйд гэм хор учруулж буй үйлдэл нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэрээс хамаарч хариуцлагын өөр өөр төрлүүдийг тогтоожээ. Болгоомжгүйгээр гэм хор учруулсан<sup>122</sup> бол хохирогчид учруулсан гэм хор нь гэм хор учруулагч этгээд анхаарал болгоомжтой байх үүргээ зөрчсөн эсэх; энэ зөрчлийн улмаас хохирогчид гэм хор учруулсан эсэхийг анхаарч үздэг байна.

Англи, АНУ-ын шүүгч нар гэм хорын асуудал дээр «Өндөгний хальсан дагзны яс» гэх дүрмийг их хэрэглэдэг байна<sup>123</sup>. Жишээ нь, хүнийг машинаар дайрах, эсхүл ямар нэгэн аргаар болгоомжгүйгээр биед нь гэмтэл учруулсан бол гэм хор учруулагч этгээд нь хохирогчийг бусдаас нимгэн дагзтай юм уу, бусдаас муу зүрхтэй байгаагүй бол арай бага гэмтэх байсан гэх эсрэг шаардлага гаргах эрхгүй гэж үздэг. Энэ дүрэм сэтгэл санааны гэм хорын нэхэмжлэлд хэрэглэгддэг юм байна. Тухайлбал, бусдаас илүү мэдрэмжтэйгээсээ болж хохирогч «энгийн» хүнд учрах сэтгэл санааны хохирлын хэмжээнээс илүү сэтгэл санааны өвчлөлтэй болсон гэж үзэхгүйгээр сэтгэл санаанд учирсан гэм хорыг бүхэлд нь нөхөн төлдөг байна. Гэхдээ тодорхой этгээдэд сэтгэл санааны гэм хор нөхөн төлөх нөхцөл нь гэм хор учруулагч тухайн үйл явдал болох талаар урьдчилан харж чадсанаар сэргийлэх үүрэгтэй гэх үзэл баримтлалд үндэслэдэг байна.

### **Австрали Улс**

Жишгийн эрх зүйн бүлд<sup>124</sup> хамаарах Австрали Улсын гэм хорын эрх зүйн хүрээнд сэтгэл санааны гэм хороос үүдэлтэй хохирлын асуудлыг тусгайлан авч үзсэн шалтгаан нь АНУ-д хэрэглэгдэх буй

<sup>121</sup> Дам ишлэв. Э. Золзаяа «Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал» магистрын судалгааны ажил, 2016 он, 18 дахь тал

<sup>122</sup> Дам ишлэв. Э. Золзаяа «Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал» магистрын судалгааны ажил, 2016 он, 19 дахь тал

<sup>123</sup> Дам ишлэв. Э. Золзаяа «Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал» магистрын судалгааны ажил, 2016 он, 19 дахь тал

<sup>124</sup> Б.Амарсанаа «Харьцуулсан эрх зүй судлал» 2014 он

ойлголтоос ялгаатай байгаа явдал юм. Аль аль улс нь холбооны улс боловч АНУ дахь муж улс бүр гэм хорын эрх зүйн тус тусын зохицуулалттай байдаг бол Австрали Улс нь үндэсний нэгдсэн жишгийн эрх зүйтэй ажээ. Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэхдээ аль болох шударга байх шалгуураар тогтоодог байна. Австрал Улсын Иргэний хариуцлагын тухай (1936 оны) хууль<sup>125</sup>-ийн 52 дугаар зүйл нь эд хөрөнгийн бус хохирлын асуудлыг зохицуулсан ба бие махбодид учруулсан хохиролтой холбоотой сэтгэл санааны хохирлын хэмжээг 0-60, авто хохирлын улмаас учирсан сэтгэл санааны хохирлын хэмжээг 0-100 хүртэлх түвшнээр ангилан хохирлын мөнгөн дүнгийн хэмжээг тогтоохдоо 1150-2000 долларыг суурь болгодог. Түвшин ахих тусам хохирлын хэмжээг хувь тэнцүүлэн нэмэгдүүлэх замаар тогтоодог байна.

## ХБНГУ

ХБНГУ-ын хууль тогтоомжид сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх асуудлыг Иргэний хуулийн 823 дугаар зүйлээр зохицуулдаг ажээ. Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөхөд «шаналлын төлөө төлж буй мөнгө» эсхүл шаналлын мөнгөн нөхөн төлбөр» гэх нэр томъёог эрх зүйн ном болон шүүхийн практикт хэрэглэдэг боловч энэ нэр томъёог хуульд хэрэглэдэггүй байна. «Шаналал» гэх нэр томъёоны оронд германы эрх зүйн ном зохиолд «мэдрэмжийн гэм хор» гэх үгийг хэрэглэдэг байна.

Герман Улсын Иргэний хуулийн 823 дугаар зүйл нь гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий зохицуулалт бөгөөд энэ зохицуулалтаар сэтгэл санааны гэм хорын хохирлыг зүйлчилж шийдвэрлэдэг байна. Дээрх зүйлд хууль бусаар санаатайгаар, эсхүл болгоомжгүйгээр бусдын амь нас, бие махбодийн халдашгүй байдал, эрүүл мэнд, эрх чөлөө, өмчлөх эрх болон бусад эрхэд халдсан этгээд өөрийн үйлдлийн улмаас бусдад учирсан хохирлыг арилгах үүрэгтэй гэж заасан. Түүнчлэн нэрлэн заасан эрхүүдээр хязгаарлалгүй уг эрхүүдийг бусад хуульд заасан байж болох бөгөөд эдгээр эрхийг хамгаалсан хуулийн агуулгад гэм буруугаас шалтгаалж, гэм хорыг

<sup>125</sup> Дам ишлэв. Э. Золзаяа «Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал» магистрын судалгааны ажил, 2016 он, 24 дахь тал

арилгахаар заасан бол хохирлыг нөхөн төлүүлнэ гэж зохицуулжээ.

Герман Улсын Иргэний хуулийн 253 дугаар зүйлд эдийн бус гэм хорыг хуульд заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлнө гэж зохицуулжээ. Хэдийгээр иргэний хууль тогтоомжоор хязгаарлалт тогтоосон ч тус улсын шүүхийн практикаар ХБНГУ-ын Үндсэн хуулийн 1 ба 2 дахь заалтыг тайлбарлах замаар эдийн бус баялгийг дордуулснаас учирсан шаналлыг нөхөн төлбөр олгох замаар бусад эрхийг эрх зүйн хамгаалалтад авдаг нь манай практикаас өөр байна<sup>126</sup>.

### **Франц Улс**

Франц Улсын эрх зүй хэдийгээр иргэний эрх зүйн бүлд хамаарах боловч сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх асуудал Герман Улсынхтай харьцуулахад өргөн хүрээний зохицуулалттай байдаг ажээ. Иргэний хуулийн 9 дүгээр зүйлд эдийн бус гэм хорын асуудлыг шууд авч үзсэн байна. Өмнө нь хууль хэрэглээний практикт амжилттай хэрэглэж байсан ерөнхий заалтууд болох 1382, 1383 дугаар заалтуудад энэ 9 дүгээр заалт нь шинэ зүйлийг авчраагүй гэж үздэг юм байна. Эдгээр хэм хэмжээгээр хууль бус буруутай үйлдлээр гэм хор учруулсан бол нөхөн төлөх үүргийг зохицуулсан байна. Иргэний хуульд эдийн болон эдийн бус гэм хорыг нөхөн төлөх харилцаанд аливаа нэгэн ялгааг гаргадаггүй, ерөнхий ойлголтуудтай боловч шүүхийн практикт эдийн бус эрх болон баялагт учруулсан гэм хорыг «dommagemoral» гэж нэрлэн ялгаж авч үздэг юм байна. Франц Улсын шүүхийн практикт сэтгэл санааны гэм хорыг 2 ялгаж авч үздэг байна. Хүний материаллаг бус эрх, үнэт зүйлд халдах болон материаллаг эрх ба үнэт зүйлд халдсанаас үүсэх шаналал гэж заажээ.

Сэтгэл санааны гэм хорыг арилгахдаа нөхөн төлбөрийн хэмжээ тодорхойлсон шүүгчдийн өмнө гаргасан шийдвэрээр баримжаалдаг байна. Энэ асуудлаар Франц, Герман улсуудын шүүхийн практик төстэй. Сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ тухайн тохиолдлын нөхцөл байдлаас их хамаардаг байна.

---

<sup>126</sup> Дам ишлэв. Э. Золзаяа «Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал» магистрын судалгааны ажил, 2016 он, 25 дахь тал

## ОХУ

ОХУ сэтгэл санааны гэм хорыг арилгах талаар харьцангуй саяхнаас зохицуулж эхэлжээ<sup>127</sup>. 1990 оны Хэвлэл мэдээлэл болон бусад олон нийтийн мэдээллийн тухай хуульд сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийг олгох талаар зохицуулсан бол 1991 онд Иргэний хуулиар зохицуулахдаа сэтгэл санааны гэм хорыг «бие махбодийн болон сэтгэл зүйн шаналал» гэж тодорхойлсноор манай иргэний хуулийн зохицуулалтаас дэвшилттэй болжээ. Үүнээс хойш 1991 оны Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хууль, Хэрэглэгчдийн эрхийн тухай хууль зэрэгт сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлөх хэм хэмжээг тус тус зохицуулжээ.

ОХУ-ын Дээд шүүх 1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр «Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх тухай хууль тогтоомжийг шүүхээс хэрэглэх тухай» 10 дугаар тогтоол гаргаснаар сэтгэл санааны гэм хорын хохирлыг нэг мөр шийдвэрлэхэд ач холбогдолтой болсон гэж үздэг юм байна. Энэ тогтоолын 2 дугаар заалтад «...сэтгэл санааны гэм хор гэдэгт иргэний эрхийн эсрэг үйлдсэн зөрчлийн үр дүнд хохирогчийн доромжлуулсан, уурласан, ичгүүртэй болон аргагүй байдалд орсноос учирсан бие махбодийн өвдөлт, тайван бус байдал гэх зэргээр мэдэрч буй сэтгэл зүйн болон бие махбодийн шаналал учруулахыг ойлгоно» гэж заажээ.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд хууль бусаар цагдан хоригдсон этгээдийн хохирлыг төрөөс гаргаж байгаа нь дэлхийн улс орнуудын хувьд нийтлэг жишиг болсон байна. Манай улсын хувьд 2 дахь буюу нөхөн төлбөрийн тусгай хуульгүй, эдийн бус хохирлын хэмжээг үнэлэх, тогтоох эрх зүйн зохицуулалтгүй байна.

Харин хохирлын хэмжээ тогтоох, үнэлэх асуудал нь харьцангуй өөр зохицуулалттай байгаа бөгөөд тоймлон авч үзвэл дараах 3 төрөлд хувааж үзэхээр байна:

1. Нөхөн төлбөрийн тусгайлсан хуультай хохирлын хэмжээг тогтоох, тодорхой зохицуулалттай;

<sup>127</sup> Дам ишлэв. Э.Золзаяа «Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал» магистрын судалгааны ажил, 2016 он, 28 дахь тал

2. Нөхөн төлбөрийн тусгайлсан хуульгүй хохирлын хэмжээг тогтоох эрх зүйн зохицуулалтгүй, шүүгчийн итгэл үнэмшлээс хамаарах;
3. Нөхөн төлбөрийн тусгайлсан хуульгүй ч хохирлын хэмжээг тогтоох үнэлэх эрх зүйн зохицуулалттай.

## **Дүгнэлт, зөвлөмж**

Энэхүү судалгааны хүрээнд хууль бусаар цагдан хоригдож цагаатгагдсан иргэдийн хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцаанд эрх зүйн хувьд ямар тулгамдсан асуудлууд байгааг илрүүлэн цаашид холбогдох хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн дараах санал, зөвлөмж гаргаж байна.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цагдан хорих арга хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй. Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж байгаа эрүүгийн шүүхийн практикт дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:
  - Цагдан хорих арга хэмжээг түгээмэл хэрэглэдэг;
  - Цагдан хоригдсон этгээд болон өмгөөлөгчийн эрхийг бодитоор хангадаггүй;
  - Цагдан хорих асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдааны өмнө прокурор хэрэг танилцуулах нэрийдлээр шүүгчтэй уулзаж ярилцдаг;
  - Цагдан хорих үндэслэлд заасан нотлох баримтыг гүйцэтгэх ажлын нууц хэмээн өмгөөлөгчид танилцуулдаггүйгээс үйлчлүүлэгчийнхээ эрхийг бүрэн дүүрэн хамгаалж шүүх хуралдаанд мэтгэлцэх боломжгүй болгодог.
2. Эрүүгийн байцаан шийтгэх болон Эрүүгийн гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулж өмгөөлөгч шүүх хуралдаанд мэтгэлцэх боломжийг бодитоор хангах шаардлагатай. Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхдээ хуулийн үндэслэлийг баримтаар хангалттай нотлохгүйгээр нийт хэрэгт хавтгайруулан хэрэглэж байгааг

хязгаарлах үүднээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд прокуророос цагдан хорих үндэслэлийг нотолсон баримтыг «гүйцэтгэх ажлын нууц» гэсэн статусаас гаргаж өмгөөлөгч, яллагдагчид танилцуулдаг болох нь зүйтэй.

3. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй. Монгол Улсад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, хохирлын хэмжээг тогтоох үнэлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа бөгөөд олон улсын жишигт нөхөн төлбөрийн доод, дээд хэмжээг зааж хохирсон байдлыг харгалзан нөхөн төлбөр тогтоох болон мөн мэргэжлийн үнэлгээчин хохирлыг тооцож үнэлдэг болох ёстой.
4. Эдийн бус хохирлыг тогтоож үнэлэх эрх зүйн зохицуулалтыг Иргэний хуульд оруулбал тус хуулийн 498.4-т заасан тохиолдлоос гадна бусад гэм хорын нэхэмжлэлтэй иргэний хэргийн хувьд ч гэм хорын хохирлыг гаргуулах боломж бүрдэх ач холбогдолтой. Хууль бусаар яллагдагчаар татагдсан, цагдан хоригдсоноос үүссэн гэм хорын хохирлыг арилгах асуудлыг цогцоор бүрэн дүүрэн шийдвэрлэх үр дүнтэй арга нь энэ төрлийн харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах явдал бөгөөд ингэж зохицуулах нь одоогийн эрх зүйн зохицуулалтын боловсронгуй бус байдлыг өөрчлөх боломж бүрдүүлнэ. Нөгөө талаас, харилцаанд оролцогч талуудын эрх ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл болно.

Иргэний хуулийн 498.4 дэх хэсгийн «...хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн...» гэдгийг ЭХХШтХ-ийн 45.1 дэх хэсгийн «...мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн...» гэж заасныг харьцуулан үзэхэд субъектийн хувьд зөрүүтэй хуульчилсан байхаас гадна «эрх бүхий албан тушаалтан» гэдэгт ямар субъектийг хамааруулах талаар тайлбар байхгүй байгаа нь эрх зүйн хэм хэмжээний хийдэл, зөрчилдөөн үүсгэж байгаа тул хуульд шаардлагатай өөрчлөлт оруулан алдааг засаж, тайлбар оруулах нь зүйтэй. Тэрчлэн Иргэний хуульд хууль бусаар

цагдан хоригдсоны улмаас учирсан хохирлыг арилгах, ЭХШХШТХ-д учирсан хохирлыг арилгах, хохирол нөхөн төлөх гэх мэтээр нэр томьёоны хувьд ялгаатай байгааг нэг мөр болгож засах шаардлагатай байна. Хохирол арилгах гэсэн нэр томьёо нь хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн зохицуулалтад илүү нийцсэн байгаа боловч нэхэмжлэгч хохирлоо тодорхойлж, нотлох зайлшгүй шаардлага тулгарч эдийн бус хохирлыг гаргуулахад хүндрэлтэй байдал үүсгэж байна. Иймд олон улсын жишгийн дагуу нэгэнт учирсан хохирол, амссан зовлон шаналлыг арилгах боломжгүй учир үр дагаврыг зөөлрүүлэх хүрээнд «нөхөн төлбөр олгох» нэрээр хуульчлах нь зүйтэй.

5. Цагдан хорих шүүх хурлын өмнө прокурор шүүгчтэй уулзаж хэрэг танилцуулдаг тогтсон практикийг арилгах зорилгоор шүүгч, прокуроруудад сургалт хийх хэрэгтэй.
6. Цагдан хоригдож байсан хугацааны хохирлыг тооцохдоо шүүхээс харилцан адилгүй аргачлал ашиглаж байгааг өөрчлөн хохирол тооцох аргачлал баталж мөрдүүлэх шаардлагатай.

## Ном зүй

1. «Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар толь» УБ, 2000 он
2. Шүүх эрх мэдэл сэтгүүл» 2014 он. №3
3. Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. УБ. 2014он
4. Б.Амарсанаа «Харьцуулсан эрх зүй судлал» 2014 он
5. «Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт» бодлогын судалгааны тайлан 2014 он
6. Ж.Бямбаа, Г.Баясгалан «Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд» УБ, 1998 он
7. С. Нарангэрэл «Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо» 2001 он
8. Б.Ширэндэв «Цагдан хорих ТСАХ-г хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал» магистрын дипломын ажил
9. П.Эрдэнэбат «Гадаад орнуудын эрүүгийн процессын онцлог» 2018 он. УБ хот. Нийтлэл
10. «Хүний эрх сэтгүүл» 2005 он, №2
11. Д.Цогтсайхан «Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ», Шүүх эрх мэдэл сэтгүүл УБ. 2014он
12. Э. Золзаяа « Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал» магистрын судалгааны ажил, 2016 он
13. Д.Мөнхбаатар «ЭБША-ны явцад иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал» магистрын судалгааны ажил УБ, 2016 он
14. Henry.F.Fradella ‘Criminal procedure for the criminal justice professional’ 2012
15. Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002 он
16. Эрүүгийн байцаан шийтгэх албадлагын арга хэмжээ, сургалтын гарын авлага, УБ 2007 он
17. Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж. 2008.03.31-ний өдөр №35
18. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй 2015он
19. Эрүүгийн хууль 2002 он
20. Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан 2013 он
21. Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан 2014 он
22. Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан 2015 он
23. Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан 2016 он
24. Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан 2017 он
25. Улсын дээд шүүхийн тайлан 2013 он



26. Улсын дээд шүүхийн тайлан 2014 он
27. Улсын дээд шүүхийн тайлан 2015 он
28. Улсын дээд шүүхийн тайлан 2016 он
29. Улсын дээд шүүхийн тайлан 2017 он
30. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1976 он
31. НҮБ-ын эрүүдэн шүүхийн эсрэг хорооны зөвлөмж
32. Монгол улсын дээд шүүхийн тогтоол №15, 2009 он

**Интернэт эх сурвалж**

<http://www.shuukh.mn>  
<http://www.supremecourt.mn>  
<http://www.prokuror.mn>  
<http://www.judcouncil.mn>  
<http://www.judoinstitute.mn>  
<http://www.legalinstitute.mn>  
<http://www.legalinfo.mn>

## ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Б.Баттуул (Хуульч, Хууль зүйн ухааны докторант)*

*Ц.Мөнхбат (Хуульч, Хууль зүйн ухааны магистр)*

*Б.Гүнжидмаа (Төрийн удирдлагын доктор)*

*Зөвлөх Б.Бат-Эрдэнэ (Хууль зүйн ухааны доктор, профессор)*

### **Товч дүгнэлт**

Монгол Улс шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд шүүгчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулахад анхаарч тэр хэрээр тодорхой ахиц гарч байгаа нь сайшаалтай. Гэсэн хэдий ч шүүхийн шийдвэр нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдүүдийн эрхийг хамгаалах олон улсын наад захын хэд хэдэн шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Шүүхээс бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд буюу насан туршийн даван туулагч нарын сэтгэл санааны хохирлыг барагдуулах асуудалд ач холбогдол өгч ажиллахгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Түүнчлэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг зөвхөн шүүгдэгчид эрүүгийн хариуцлага тооцоход «нотлох баримт» болгон ашиглаж харин тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрхийг нь нөхөн сэргээхэд чиглэсэн асуудлыг шүүхийн шийдвэрт тусгахгүй байна.

Шүүгч хуулийг сайтар судалж, түүний заалт бүрийг хэлбэрэлтгүй биелүүлэх ёстой хэдий ч шинээр батлагдсан эрүүгийн хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр хэрэгжүүлэхгүй байх тохиолдол илэрлээ. Тэрчлэн шүүхийн шийдвэр ойлгомжтой, хуулийн хэм хэмжээний зохицуулалт, хэргийн үйл явцын хооронд логик холбоог бүрэн илэрхийлсэн байх шаардлагатай атал зарим шүүхийн

шийдвэрүүд логикийн хувьд зөрчилтэй, эргэлзээ төрүүлэхээр, утгын хувьд ойлгомжгүй бичигдсэн байх тул шинэ хуулийн талаар шүүгч нарт сургалт зохион байгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид хуулийг нэг мөр хэрэглэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухайлбал, хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар илүү санаачилга гарган ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

#### *Судалгааны арга зүй*

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс «Насанд хүрээгүй болон бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал 2015 онд 30, 2016 онд 22, 2017 оны эхний хагас жилд 11 байна» гэсэн тоо баримтад тулгуурлан нийт 10 шүүхийн тогтоолд дүн шинжилгээ хийв. Үүнд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэргийг шийдвэрлэсэн 2002 оны Эрүүгийн хууль (ЭХ) болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар (ЭБШХ) шийдвэрлэсэн 4 хэрэг, 2015 оны Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар (ЭХХШТХ) шийдвэрлэгдсэн 6 хэргийн шийдвэрийг сонгож ажиллав. Энэ нь 2002 оны хуулиар сүүлийн 3 жилд шийдвэрлэсэн хэргийн 8,3 хувь, 2015 оны хуулиар шийдвэрлэсэн хэргийн 45 орчим хувийг тус тус эзэлж байгаа юм.

Шүүхийн шийдвэр хууль ёсны эсэх талаас нь дүн шинжилгээ хийхдээ дараах 3 шалгуурыг баримталсан бөгөөд харин тогтоол үндэслэл бүхий байх гэсэн шалгуураар үнэлэлт өгөөгүй болно. Үүнд:

- Шийтгэх тогтоол үйлдэхдээ Эрүүгийн хуулийг хэрэглэсэн байдал;
- Шүүхийн практикт 2002 оны ЭБШХ, 2015 оны ЭХХШТХ-ийг хэрхэн хэрэглэсэн эсэх;
- Хүчингийн гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр Монгол Улс Хүүхдийн эрхийн конвенц, түүний нэмэлт протоколуудын наад захын шаардлагын гол чиглэлүүдийг хэрэгжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийх замаар судлав.

Нийт 10 хэргийг сонгож авахдаа Хүснэгт 1-д үзүүлсэн шалгуурыг баримталлаа.

### Хүснэгт 1. Судлах хэрэг сонгосон шалгуур

№	Шалгуур	Сонгож авсан шүүхийн шийтгэх тогтоолын талаарх тэмдэглэгээ
1.	Хохирогчийн нас	- 6-16 насны хохирогчид
2.	Гэм хэрэг үйлдэгч этгээдийн байдал	- Хамаарал бүхий этгээд (хамаатны ах - 3, хойд эцэг - 4, төрсөн эцэг - 1) - Үл таних этгээд - 2
4.	Хамаарах хууль	- 2002 оны хуулиар - 4 - 2015 оны хуулиар - 6
5.	Гэмт үйлдлийн давтамж	- Удаа дараагийн үйлдэл - 4 - Нэг удаагийн үйлдэл - 6

## 1. Эрүүгийн хуулийн хэрэглээ

Шүүхээс шийтгэх тогтоол гаргах явцад Эрүүгийн хуулийг хэрэглэхэд дараах алдаа цөөнгүй гарчээ. Үүнд:

- 1) Шүүхээс эрүүгийн хуулийг буруу хэрэглэх тохиолдол түгээмэл ажиглагдав. Судалж үзсэн шүүхийн шийдвэрийн зарим тохиолдолд нь эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн байна. Шүүхээс Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн нь хэлбэр талаасаа техникийн алдаа мэт боловч хууль хэрэглэх тухайд ноцтой алдаанд тооцогдоно. Тохиолдол 1-ийг харахад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлийн 78.2.3-т зааснаар 2011 оны 05 сарын 11-ний өдөр ялгүй болсныг шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлийн 78.2.1-д зааснаар ялгүй болсон гэж буруу зүйлийг ишлэн бичсэн нь эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ.

**Тохиолдол-1:** *Шийтгэх тогтоолд эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн байдал*

*Шүүгдэгч нь 2006 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн шүүхийн шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуульд заасан хүндэвтэр гэмт хэрэгт 3 сар 10 хоногийн хугацаагаар баривчлах ял шийтгүүлж, 2006 оны 5 дугаар сарын 11-ний өдөр уг ялаа эдэлж дууссан тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлийн 78.2.1-д зааснаар тэрээр 2011 оны 5 дугаар сарын 11-нд ялгүй болжээ.*

*Иймд шүүгдэгчийг 2015 оны 3 дугаар сарын 20-нд анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэлтэй.*

Түүнчлэн «... сум дундын эрүүгийн анхан шатны шүүхийн 2015 оны шийтгэх тогтоолд «Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.10-т заасныг журамлан, 52.5-д зааснаар ялтан ...-д оногдуулсан 12 жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлсүгэй» гэж Эрүүгийн хуулийг мөн буруу хэрэглэсэн байна. Учир нь шүүх Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.10 дах хэсгийг журамлан хорих ял эдлүүлэх дэглэмийг хөнгөрүүлсэн атлаа Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсгийг давхар журамласан нь алдаатай байна.

Үүнээс гадна сум дундын эрүүгийн шүүхийн тогтоолын тогтоох хэсэгт «Шүүгдэгч Б-г насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай. Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар шүүгдэгч Б-г 12 (арван хоёр) жилийн хорих ялаар шийтгэсүгэй» гэжээ. Шүүхээс энд техникийн алдаа гаргасан мэт харагдаж байх боловч хууль зүйн утгаараа шүүгдэгчид ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.2 дахь хэсгийн 126.2.4 дэх заалтад заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцсон атлаа ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.3 дэх хэсэгт зааснаар ял оногдуулж Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн байна.

- 2) Бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэргийг хянан хэлэлцэж, шийдвэр гаргахдаа дараах нийтлэг алдааг гаргаж байгаа нь ажиглагдлаа. Бага насны хүүхэд хүчиндсэн нь 126 дугаар зүйлийн 126.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг заавал агуулахыг шаарддаггүй байхад Шийтгэх тогтоолд тухайн шинжийг дурдаж байгаа нь алдаатай байна. (Тохиолдол 2).

**Тохиолдол-2:** (... дүүргийн ... шүүхийн эрүүгийн хэргийн 2015 оны шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)

1. Шүүгдэгч [redacted] хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бага насны буюу 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай.

Дээрх жишээнд дурдагдсан «Хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгаа байдлыг далимдуулж» гэдэг нь ЭХ-ийн 126 дугаар зүйлийн 126.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинж юм. Энэ хуулийн 126.3-т заасан хүндрүүлэх шинжүүдийн зарим нь 126.1-д заасан шинжтэй хоршин нийлж 126.3-т заасан гэмт хэргийн шинжийг бүрдүүлдэг онцлогтой. Харин бага насны хүүхдийг хүчиндсэн гэдэг нь ЭХ-ийн 126 дугаар зүйлийн 126.1-д заасан шинжийг заавал агуулсан байх шаардлагагүй бөгөөд 126.3-т заасан шинжийг шууд илэрхийлдгээрээ бусад гэмт хэргээс ялгагдах онцлогтой. Иймд бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэргийг шийдвэрлэхэд хохирогч биеэ хамгаалж чадахгүй байх шинжийг агуулах шаардлагагүй байхад дээрх шинжийг шаардаж байгаа нь хуулийг алдаатай хэрэглэжээ.

- 3) Шүүхийн тогтоолуудад байгаа бас нэг нийтлэг алдаа бол хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөв нэрлэж хэрэглэхгүй байна. Тухайлбал, Тохиолдол 3-т байгаа шийтгэх тогтоолын тогтоох хэсгүүдэд хуулийн зүйл, хэсгийг алдаатай бичиж харин тогтоох хэсгийн 5-д зөв бичжээ. Өөрөөр хэлбэл, хуулийн зүйл хэсэг гэж бичихийг... хуулийн зүйлийн ...-д гэж бичиж алдаа гаргасан байна.

**Тохиолдол-3:** *Шийтгэх тогтоолд хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөв хэрэглэхгүй байгаа нь (... дүүргийн ... шүүхийн эрүүгийн хэргийн 2016 оны шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)*

2. Шүүгдэгч [REDACTED] Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар 20 (хорь) жилийн хугацаагаар хорих ял, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.1-д зааснаар 1 (нэг) жилийн хугацаагаар хорих ял тус тус шийтгэсүгэй.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасныг журамлан [REDACTED] Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар оногдуулсан 20 жил хорих ялд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.1-д зааснаар оногдуулсан 1 жилийн хорих ялыг багтаан, [REDACTED] биечлэн эдлэх ялыг 20 (хорь) жилийн хугацаагаар хорих ялаар тогтоосугай.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6-д зааснаар шүүгдэгч [REDACTED] оногдуулсан 20 жил хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч [REDACTED] цагдан хоригдсон 144 (нэг зуун дөчин дөрөв) хоногийг түүний ял эдэлсэн хугацаанд оруулан тооцсугай.

## **2. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн хэрэглээ**

ЭБШХ-ийн 294 дүгээр зүйлд зааснаар шүүхийн тогтоол нь тодорхой, ойлгомжтой бичигдсэн байх бөгөөд удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгүүдэд тавигдах шаардлагыг (ЭБШХ-ийн 295, 296, 297, 298-р зүйлүүд) шүүхийн шийдвэрүүд хэрхэн хангасан эсэхэд дүн шинжилгээ хийснийг доор товчлон харууллаа.

### **2.1. Шүүхийн тогтоолын УДИРТГАЛ ХЭСЭГ**

1. Энэ хэсэгт тусгавал зохих Монгол Улсын нэрийн өмнөөс тогтоол гаргах, тогтоолыг хэзээ, хаана гаргасан, тогтоол гаргасан шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчид, шүүгдэгчийн биеийн байцаалт, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт хамаарах тухай заалтыг шүүх ерөнхийдөө хангасан байна гэж үзэж байна.

2. Тогтоолын удиртгал хэсэгт шүүгдэгчийн нэрийг орхигдуулж бичсэн нь шүүхийн шийдвэртэй танилцаж байгаа судлаач, хөндлөнгийн этгээдүүдэд шүүгдэгчийг байхгүйд хэрэг хянан хэлэлцсэн мэт тодорхойгүй байдал үүсгэж болзошгүй байна. ЭБШХ-ийн 295 дугаар зүйлийн 295.1.3 дахь заалтын дагуу шүүгдэгчийг шүүх хуралдаанд оролцсон эсэхийг удиртгал хэсэгт зайлшгүй тусгахыг хуульд заагаагүй боловч шүүгдэгчийн нэрийг бусад оролцогчдын хамт бүрэн бичих нь зүйтэй байна (Тохиолдол 4).

3. Мөн шүүгдэгчийн биеийн байцаалтыг тусгахдаа түүнтэй холбогдолтой мэдээллүүдийг «гэх» гэсэн аливаа зүйлийг найдвартай, тодорхой, баттай бус, магадгүй гэсэн агуулгыг илэрхийлэхэд хам

хэрэглэгддэг үгээр илэрхийлж тогтоолд тусгасан нь оновчгүй байна. Тухайлбал, Шүүгдэгчийн оршин суугаа газрыг нь заахдаа «Эхэн бүрд гэх газар оршин суух» гэж тодорхой бус бичжээ.

ЭБШХ-ийн 295 дугаар зүйлд «шүүгдэгчийн оршин суугаа газрыг заана» гэсэн нь шийтгэх тогтоолд гэмт хэрэг үйлдсэн газар болон шүүгдэгчийн амьдран суудаг газрыг эргэлзээгүй тогтоосон байх хуулийн шаардлагыг илэрхийлж байгаа бөгөөд «гэх» гэсэн нэр томьёо, сул үг хэрэглэж тодорхой бус байдлыг илэрхийлсэн нь хуулийн шаардлагыг хангахгүй байна.

**Тохиолдол-4:** Шүүгдэгчийн нэрийг тогтоолын удиртгал хэсэгт тусгаагүй байдал

*Монгол Улсын нэрийн өмнөөс*

*Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хуралдааныг ерөнхий шүүгч [REDACTED] даргалж, шүүгч [REDACTED] нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн шүүхийн хуралдааны танхимд хаалттай хийсэн шүүх хуралдаанд*

*Иргэдийн төлөөлөгч [REDACTED]*

*Нарийн бичгийн дарга [REDACTED]*

*Улсын яллагч [REDACTED]*

*Шүүгдэгчийн өмгөөлөгч [REDACTED] нарыг оролцуулан Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газраас мөрдөн байцаалт явуулж, Прокурорын газраас 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4-д зааснаар зүйлчилж ялах дүгнэлт үйлдэж ирүүлсэн [REDACTED] холбогдох эрүүгийн [REDACTED] дугаартай хэргийг хянан хэлэлцэв.*

## 2.2 Шүүхийн тогтоолын ТОДОРХОЙЛОХ ХЭСЭГ

1. ЭБШХ-ийн 296 дугаар зүйлийн 296.1 дэх хэсэгт зааснаар шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт «гэмт хэрэг үйлдсэн газар, цаг, арга, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний хэмжээ, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, шүүхийн дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримт, шүүхээс бусад нотлох баримтыг няцаан үгүйсгэсэн



үндэслэл, хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлж байгаа нөхцөл байдал, хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа бол түүний үндэслэл, түүнчлэн урьд сонгосон ялыг шүүхээс өөрчилсөн бол түүний үндэслэл, шүүгдэгчийг ял эдлэхээс чөлөөлсөн, хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол шалтгааныг тодорхойлох» гэж заасан байдаг.

Харин дүн шинжилгээ хийсэн тогтоолуудын тал орчим хувь нь тус шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал, Тохиолдол 5-д дээр дурдсан хуулийн шаардлагаас гадна ЭБШХ-ийн 80 дугаар зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих асуудлууд буюу шүүх хуралдааны үед гэмт хэрэг гарсан байдлыг тодруулж тогтоох шаардлагыг хангаагүй байна.

**Тохиолдол-5:** *Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт гэмт хэргийн талаар буюу үйл явдлын талаар огт тодорхойлоогүй байдал (... сум дундын шүүхийн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолын хэсгээс)*

*Шүүх хэрэгт авагдсан хэрэг учралын газар үзлэг хийсэн тэмдэглэл (хх 3х), хувицсанд үзлэг хийсэн тухай тэмдэглэл (хх-ийн 8х), шүүгдэгчийн ял шийтгэгдсэн эсхийг шалгах хуудас (хх-ийн 129х), насанд хүрээгүй хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, гэрч нарын мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт зэрэг бичгийн нотлох баримтуудыг шинжлэн судлаад шүүгдэгч [REDACTED] улсын яллагчийн яллах дүгнэлтэнд дурдсан буюу бага насны өөрөөр хэлбэл, арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох хуульд заасан ял шийтгэлийг оногдуулах нь зүйтэй.*

2. Тодорхойлох хэсэгт хуулийн нэр томъёоны хувьд ч алдаатай байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал, «Нотлох баримтуудыг уншиж судлав» гэж бичсэн нь ЭБШХ-д байхгүй ойлголт юм. Харин шүүхийн хэлэлцүүлгийн үед яллах болон өмгөөлөх талаас гаргасан хүсэлтийн дагуу хавтаст хэрэгт авагдсан, эсхүл шинээр гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэн судалдаг журамтай тул нотлох баримтыг «шинжлэн судлав» гэж гэж зөвтгөн бичих шаардлагатай.

3. Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт зааснаар шүүх ял оногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэр хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэх учиртай. Түүнчлэн хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох талтай.

Гэтэл Тохиолдол 6-д шүүх хуульд заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулах болсон үндэслэлээ зааж өгөөгүй нь хуулиар тогтоосон шаардлагыг хангаагүй байна гэж үзнэ. Доорх жишээнд шүүгч «хохирогч нь шүүгдэгчээс нэхэмжлэх зүйлгүй, гомдол саналгүй, түүнд хөнгөн ял шийтгэж өгнө үү гэсэн байх тул шүүх шүүгдэгчийг бусдад төлөх төлбөргүй буюу гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн, гэмт хорыг арилгасан» хэмээн хуульд заасан хэмжээнээс доогуур ял оногдуулах болсон үндэслэл гэж үзэв. Мөн Тохиолдол 6-д шүүгдэгчийн чин санаанаас гэмшсэн байдлыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд хамааруулсан боловч ямар нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчийг «чин санаанаасаа гэмшсэн» гэдгийг тогтоосон үндэслэлээ шүүгч тодорхойлж өгөөгүй байгаа нь учир дутагдалтай байна.

**Тохиолдол-6:** *Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт хорих ялыг доод хэмжээнээс доогуур оногдуулахдаа хуульд заасан шаардлагуудыг хангаагүй байдал (... сум дундын шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)*

*Шүүх шүүгдэгчид ял оногдуулахдаа анх удаа гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаасаа гэмшсэн байдал болон гэмт хэргийн нөхцөл байдал, шүүгдэгчийн хувийн байдал зэргийг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж, оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэх нь зүйтэй гэж үзэв.*

4. Түүнчлэн тодорхойлох хэсэгт ЭБШХ-ийн 296 дугаар зүйлийн 296.1 дэх хэсэгт заасны дагуу шүүгдэгчид оногдуулах ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тодорхойлж өгөх ёстой. Гэтэл ... дүүргийн 2016 оны шийтгэх тогтоолд ямар хүнд хор уршиг учирсныг шүүхийн шийдвэрт тодорхойлолгүйгээр «...гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсныг хүндрүүлэх нөхцөлд харгалзав» хэмээн бичсэн нь ойлгомжгүй байна.

5. Шүүхийн шийдвэр нотлох баримтуудыг давхцуулж бичих нийтлэг дутагдал ажиглагдлаа. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндсэн А-д холбогдох Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт «шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үед шүүгдэгч, хохирогч нарын мэдүүлэг, бичгийн бусад нотлох баримтыг шинжлэн судалж тодорхойлбол гээд шүүгдэгчээс, насанд хүрээгүй хохирогчоос, насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс мэдүүлэхдээ...» гэжээ. Шүүгч үргэлжлүүлээд насанд хүрээгүй хохирогчийн биед хийсэн шүүх эмнэлгийн ...43 тоот акт, шүүхийн сэтгэц, эмгэг судлалын дүгнэлт зэрэг 8 нотлох баримтын эх сурвалжийг иш татаад «шүүх дээрх баримтуудыг дүгнэн үзвэл, ... нь 2016 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ... тоотод ... төрсөн 13 нас 9 сартай ...-г хүчиндсэн» гэж үйл явдлын талаар дүгнэлт хийсэн байна. Ингэж үйл явдлыг дүгнэсний дараа энэ нь шүүгдэгч, хохирогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт бичгийн бусад баримтаар нотлогдон тогтоогдлоо гээд нотлох баримтуудыг дахин дурджээ. Хуульч-судлаач бидний үзэж байгаагаар А-гийн бага насны хүүхдийг хүчиндсэн гэх үйлдэлд дүгнэлт хийсний дараа энэ үйл явдал нь ямар нотлох баримтаар нотлогдож байгааг дурдаж, улмаар нотлох баримтыг үнэлсэн бол илүү тодорхой ойлгомжтой болох байв.

### **2.3 Шүүхийн тогтоолын ТОГТООХ ХЭСЭГ**

1. ЭБШХ-ийн 297, 298 дугаар зүйлд «шүүгдэгч Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт дурдсан гэмт хэрэг үйлдсэн, шүүгдэгчид оногдуулсан ялын төрөл, хэмжээ, эдэлбэл зохих ялын хэмжээ, ялтны ял эдлэх дэглэм, урьдчилан хоригдсон хугацааг тооцох, иргэний нэхэмжлэл, эд мөрийн баримт, байцаан шийтгэх

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

ажиллагааны зардал, давж заалдах гомдол гаргах журам» зэргээр шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт тавигдах шаардлагыг тодорхойлсон. Дүн шинжилгээ хийсэн шүүхийн тогтоолууд ерөнхийдөө дээрх шаардлагыг хангасан байна.

2. Гэхдээ шүүхийн нэрийг буруу бичих алдаа нэг тогтоолд ажиглагдлаа. Тохиолдол 7-д Аймгийн шүүхэд давж заалдах гомдол гаргана хэмээн буруу бичсэн бөгөөд харин «Шүүх байгуулах тухай» хуульд заасны дагуу «Эрүүгийн хэргийн давж заалдах шатны ..... дугаар шүүх» гэж зөв бичих шаардлагатай байжээ.

*Тохиолдол-7: Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт шүүхийн нэрийг оролцогчдод тодорхой зааж өгөөгүй байдал (... аймгийн ... шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)*

*6. Шийтгэх тогтоолыг танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд давж заалдах гомдол гаргах болон эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд тогтоолыг эс зөвшөөрвөл, гардуулснаас хойш 14 хоногийн дотор Аймгийн шүүхэд давж заалдах гомдол гаргах буюу улсын яллагч эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.*

## **3. 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ**

### **3.1 Шүүхийн тогтоолын УДИРТГАЛ ХЭСЭГ**

1. 2015 оны ЭХХШТХ-иар шүүхийн шийдвэрийг шийтгэх, цагаатгах хэлбэртэй байхаар тогтоогоод хуучин ЭБШХ-иар тогтоож байсан шийтгэх тогтоолын бүтцээр буюу удиртгал, тодорхойлох, тогтоох хэсэгтэй байхаар хуульчилжээ. Харин удиртгал хэсэгт ЭХХШТХ-иар хэлэлцэж буй хэргийн дугаарыг зайлшгүй тусгаж байхыг зааж өгсөн нь шинэлэг ач холбогдолтой заалт болжээ. Бидний шинжлэн судалснаар ЭХХШТХ-ийн дагуу гаргасан 2017 оны шүүхийн тогтоолууд нь тус хуулийн 36.6 дугаар зүйлд заасан удиртгал хэсэгт тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна гэж үзэж байна. Харин шүүх хуралдааны оролцогчдыг тогтоолд дутуу тусгасан байсан нэг тохиолдол байсныг тэмдэглэх нь зүйтэй.

### 3.2 Шүүхийн тогтоолын ТОДОРХОЙЛОХ ХЭСЭГ

1. ЭХХШТХ-ийн 36.7 дугаар зүйлд шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг нь (i) шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, (ii) эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хоёр хэсгээс бүрдэх, түүнд тусгавал зохих шаардлагыг тодорхойлж өгсөн байдаг. Бидний шинжлэн судалсан тогтоолд дээрх шаардлагыг хангахгүй буюу тогтоолын тодорхойлох хэсгийг ялган хуваадаггүй, хэсэг тус бүрт тусгавал зохих зүйлсийг холилдуулан бичдэг, эсвэл хуучин ЭБШХ-иар тогтоосон загвараар тогтоолыг үйлдэж байгаа нь бүх 2017 оны шийтгэх тогтоолд ажиглагдлаа.

2. Тодорхойлох хэсэгт хуулиар тогтоосон бусад шаардлагыг хангаагүй тохиолдлууд нэлээд байсныг Төхиолдол 8-аар харууллаа. Тус тогтоолд ЭХХШТХ-ийн 36.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар «гэмт хэрэг үйлдэгдсэн газар, цаг, хугацаа, тогтоосон хэргийн талаарх нөхцөл байдлыг тодорхойлох хэсэгт тусгах» шаардлагатай байтал хүүхдийг хүчиндэж жирэмсэн болгосон гэмт хэрэг хаана үйлдэгдсэн болохыг тодорхойлоогүй, яллах дүгнэлтэд ч энэ асуудал орхигдсон байгаа нь ноцтой алдаа гэж үзэж болохоор байна.

**Төхиолдол-8:** *Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт гэмт хэрэг үйлдсэн газрыг тусгаагүй байдал (... дүүргийн ... шүүхийн эрүүгийн хэргийн 2017 оны шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)*

*Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, [REDACTED] тоотод оршин суух өөрийн дагавар охин болох насанд хүрээгүй буюу 16 нас 08 сар 13 хоногтой [REDACTED] биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан, хүч хэрэглэж, 2017 оны 02 дугаар сараас 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд хүч хэрэглэн хүчиндэж жирэмсэн болгосон.*

3. ЭХХШТХ-ийн 36.7-р зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтад тогтоолын тодорхойлох хэсэгт тавигдсан шаардлагыг дараах байдлаар тусгасан «... гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, шүүх тухайн нотлох

баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой хууль ёсны гэж үзсэн улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн саналын үндэслэл болгосон баримт, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэлийг тусгана». Гэтэл 2017 оны шүүхийн шийтгэх тогтоолуудын талаас дээш хувийн тодорхойлох хэсгүүдэд гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон ямар нотлох баримт байгааг тусгасан хэр нь нотлох баримтыг үнэлж, тодорхойлсон улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн саналын үндэслэл болсон ямар баримт байгаа, иргэдийн төлөөлөгч ямар дүгнэлт гаргасан, үүнийг нь няцаан үгүйсгэсэн ямар үндэслэл байгаа зэргийг огт дурдаагүй байгаа нь хуулийн шаардлага хангаагүй байна.

4. Түүнчлэн шүүгдэгчид хорих ял оногдуулсан бол уг ялыг эдлүүлэх хорих байгууллагын дэглэмийг заасан үндэслэлийг тус хэсэгт огт тусгаагүй орхигдуулсан тохиолдол илэрлээ. Үүнийг шүүхийн шийдвэр хуулийн шаардлага бүрэн хангаагүй гэж үзэж болохоор байна.

5. Мөн шүүхийн тогтоолын тодорхойлох хэсэгт нотлох баримтын агуулгыг давхардуулан бичиж, энэ үндсэн дээр үйл явдлыг тодорхойлж хууль зүйн дүгнэлт хийдэг, найруулгын хувьд алдаатай бичсэн тохиолдол цөөнгүй байна. Жишээлбэл, ...дугаартай тогтоолын тодорхойлох хэсэгт «Талуудын хүсэлтээр хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгт авагдсан дараах нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор шинжлэн судлаад **ТОДОРХОЙЛОХ** нь: ... зэрэг нотлох баримтуудыг тус тус шинжлэн судлав гээд дараа нь дахиад шүүх хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжлэн судалбал:» гэж бичсэнийг тэмдэглэж байна.

6. Мөн Тохиолдол 9-д дурдагдсан ... дүүргийн 2017 оны тогтоолд «шүүгдэгчээс эмчилгээний зардал гаргуулж олгох нь зүйтэй» гэж үзсэн хэр нь «шүүгдэгч нь бусдад төлөх төлбөргүй болохыг дурдаж байна» гэсэн нь шүүхийн шийдвэр эргэлзээ төрүүлэхээр байна.

**Тохиолдол-9:** *Шийтгэх тогтоол нь эргэлзээ төрүүлэхээр бичигдсэн байдал (... дүүргийн ... шүүхийн эрүүгийн хэргийн 2017 оны шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)*

*Гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, гэм хор, бусад байдал:*

*Шүүгдэгч [ ] эмчилгээний зардал 150000 төгрөгийг гаргуулж [ ] олгох нь зүйтэй байна.*

*Эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүй, битүүмжлэгдсэн эд хөрөнгөгүй [ ] нь бусдад төлөх төлбөргүй болохыг дурдаж байна.*

7. Тэрчлэн шүүхийн тогтоолын тодорхойлох хэсэгт хуульд заагаагүй үндэслэл бичсэнийг ноцтой алдаанд тооцохоор байна. Тухайлбал, шүүгдэгч ...зарим үйлдлийг огт үйлдээгүй гэсэн мэдүүлгийг «мөрдөн байцаалтад шүүгдэгч ...-с хууль сануулж авсан мэдүүлэг... зэргээр няцаан үгүйсгэгдсэн» гэжээ. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2015 оны ЭХХШтХ-д яллагдагч, шүүгдэгчийг хууль сануулж байцаах тухай заалт байхгүй байгаа тул няцаан үгүйсгэсэн дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзнэ.

8. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгч ямар мэдүүлэг өгч, санал хүсэлт гаргасан эсэх нь шүүхийн тогтоолд дурдагдаагүй хэр нь шүүгч нь насанд хүрээгүй хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч нар иргэний нэхэмжлэл гаргаагүй гэж тогтоолд дурдсан нь шүүхээс талуудын тэгш оролцоог хангаагүй гэж үзэж болохоор байна. Мөн хохирогчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцсон байтал хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар байр сууриа илэрхийлсэн эсэх нь тогтоолд дурдагдаагүй байгаа нь ойлгомжгүй байна.

9. ... дугаартай шийтгэх тогтоолын удиртгал хэсэгт хүчингийн гэмт хэргийн хохирогч ...-г 6 нас 10 сартай хэмээн тодорхойлсон ч тогтоолын тодорхойлох хэсэгт хохирогчийн нас тоолсон нотлох баримтыг огт дурдаагүй байгаа нь алдаатай байна. Учир нь хүчиндэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний нэг нөхцөл нь хохирогчийн нас байх бөгөөд нас тоолсон баримт нь хүчингийн хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой байдаг (Тохиолдол 10).

10. Тохиолдол 10-т дурдагдсан тогтоол нь ЭХХШтХ-ийн 39.6 дугаар зүйлийн 1.3 дахь заалт «дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авахдаа бусдыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй бол дүгнэлт нь

## Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

хэргийн бодит байдалтай нийцээгүй байна» гэснийг мөн зөрчсөн байлаа. Тус тогтоолд шүүгдэгчийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлгийг (i) хохирогчийн мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлэг, (ii) хохирогчийн биед хийсэн шүүх эмнэлгийн үзлэг шинжилгээний дүгнэлт, (iii) шүүгдэгчийн өөрийнх нь мөрдөн шалгах ажиллагааны үеэр өгсөн мэдүүлгээр няцаан үгүйсгэсэн байх боловч бусад үлдсэн нотлох баримтыг хэрхэн үнэлэх асуудлыг орхигдуулсан нь хуулийн шаардлага хангаагүй гэж үзэхээр байна.

**Тохиолдол-10:** *Шийтгэх тогтоолд хохирогчийн насыг дурдсан хэр нь нотлох баримтыг дурдаагүй тохиолдол гарч байна (... дүүргийн ... шүүхийн эрүүгийн хэргийн 2017 оны шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)*

*Холбогдох хэргийн талаар:*

■ нь 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо ■ байрны 2 дугаар орцны жижүүрийн 00 өрөөнд гэр бүлийн хамаарал бүхий дагавар охин 6 нас 10 сартай буюу бага насны ■ өөрийн эрхшээлдээ байгааг далимдуулан бэлгийн замын халдварт өвчин халдааж хүчиндсэн гэмт хэрэгт холбогджээ.

### 3.3 Шүүхийн тогтоолын ТОГТООХ ХЭСЭГ

1. Бидний шинжлэн судалснаар ЭХХШТХ-ийн 36.8 зүйлд заасан тогтоох хэсэгт тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна гэж үзлээ.

## 4. Ял оноосон байдал

1. 2015 оны шинэ хуулиар хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэрэгт хүүхдийг хамгаалах үүднээс зарчмын болон оногдуулах ялын хувьд томоохон өөрчлөлт оруулсан. Тухайлбал, (i) хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүүхэд байж болох, (ii) 14 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэргийг үйлдэхэд хуульд заасан арга шаардахгүй буюу бэлгийн харьцаанд орсон бол хүчиндэх гэмт хэрэгт тооцохоор, (iii) ураг зулбасан, гэр бүлийн



хамаарал бүхий хүнийг хүчиндэх, гэр бүлийн хамаарал бүхий 16 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх, 16 насанд хүрээгүй хүүхдийг жирэмсэн болгох зэрэг үйлдэл тус бүрийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцсон байна. Мөн бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцож, хуульд тайлбарыг оруулсан нь сайшаалтай.

2. Бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгаж хуучин хуулиар 15-25 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ (2002 оны эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэг) гэж байсан бол 2015 оны хуулиар энэ хэмжээг багасгаж 12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ (2015 оны Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг) хэмээн ялын хугацааг багасгасан нь тус гэмт хэргийн хор уршигтай харьцуулахад нийцсэн заалт болж чадаагүй, хөнгөрүүлсэн байна гэж хуульч-судлаачид бидний зүгээс үзэж байна. Хүснэгт 1-д шийтгэх тогтоолд дурдсан ялын хэмжээг үзүүлсэн бөгөөд шинэ, хуучин хуулиудыг харьцуулахад тус гэмт хэрэгт оноож буй ялын хэмжээ багассаныг харж болохоор байна.

3. Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшил, хэрэг тус бүрийн онцлогт тулгуурлаж ял оноож байгаа хэдий ч бага насны хүүхдийг нэг удаа хүчиндэх, давтан хүчиндэхэд ижил ял оноож байгаа нь шударга ёсны зарчимтай нийцээгүй байна гэж үзлээ. Доорх хүснэгтэд үзүүлснээр бага насны дагавар 2 охиноо давтан үйлдлээр олон жил хүчиндсэн гэмт хэрэгт 20 жилийн ял оноосон байдал нь нэг удаа нэг хүүхэд хүчиндсэн гэмт хэрэгт оноосон ялын хугацаатай ижил байгаа нь оноосон ял нь учруулсан гэмт хэргийн хор уршигтай нийцээгүй байна гэж үзэж байна.

**Хүснэгт 2. Оноосон ял ба учруулсан  
гэмт хэргийн нөхцөл байдал**

№	Хохирог- чийн тоо	Нас	Нэг удаа эсвэл удаа дараа хүчирхийлсэн эсэх	Ялын байдал
<b>2002 оны хуулиар</b>				
1	1	7	Нэг удаа	12 жил (жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид)
2	1	13	Нэг удаа	18 жил (чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид)
3	2	10-11, 10-14	Удаа дараа	20 жил (чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид)
4	1	10	Нэг удаа	23 жил (чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид)
<b>2015 оны хуулиар</b>				
5	1	10	Нэг удаа	12 жил (нээлттэй хорих байгууллагад)
6	1	8	Удаа дараа	13 жил (хаалттай хорих байгууллагад)
7	1	11	Нэг удаа	16 жил (хаалттай хорих байгууллагад)
8	1	12-14	Удаа дараа	17 жил (хаалттай хорих байгууллагад)
9	2	9-16, 7-8	Удаа дараа	18 жил (хаалттай хорих байгууллагад)
10	1	6	Нэг удаа	18 жил (хаалттай хорих байгууллагад)

**5. Шүүхийн тогтоол тодорхой, ойлгомжтой байх шаардлага буюу тогтоолын найруулга, өгүүлбэр, үг зүйн алдааны тухайд**

1. Үйл явдал, фактын талаар найруулгын хувьд зөв бичих нь хэргийн талаарх үйл баримтыг тодорхой харуулдаг билээ. Харин зарим шийтгэх тогтоолд тухайлбал, Тохиолдол 11-д найруулгын хувьд засаж залруулах зүйлүүд байгаа нь ажиглагдлаа. Уг жишээнд шүүгдэгч ... тоотод согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн мэтээр найруулгын алдаатай байгааг харж болно. Харин бодит үйл явдал нь шүүгдэгч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байдалтай гаднаас орж ирэн ... тоотод бага насны хүүхэд хүчиндсэн байдаг. Иймд «согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ... тоотод бага насны хүүхдийг хүчиндсэн» гэж тодорхой бичвэл зохино.

**Тохиолдол-11:** Шийтгэх тогтоол найруулгын хувьд оновчгүй байгаа нь (... дүүргийн ... шүүхийн эрүүгийн хэргийн 2015 оны шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс)

нь (яллах дүгнэлтэд тэмдэглэсэнээр) 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдөр [REDACTED] дүүргийн 28 дугаар хорооны нутаг дэвсгэр [REDACTED] тоотод согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 13 настай бага насны [REDACTED] овогтой [REDACTED] хүчиндсэн гэмт хэрэгт холбогджээ.

2. Түүнчлэн бидний дүн шинжилгээ хийсэн шүүхийн тогтоолуудад үг олонтаа давхардуулсан, үг үсгийн болон цэг таслалын алдаанууд багагүй байгааг дурдах шаардлагатай.

3. Нэмж хэлэхэд, ЭХХШТХ-ийн 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдааныг хаалттай явуулах үндэслэлийг тодорхойлсон бөгөөд хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэрэг хаалттай явуулах гэмт хэргийн тоонд ордог. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн зөвхөн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгох боломжтой юм. Гэтэл shuukh.mn цахим хуудас дээр дээрх хаалттай явуулсан шүүх хуралдааны тогтоолуудын заримыг бүрэн эхээр нь байршуулж хохирогч, шүүгдэгч нарын биеийн байцаалттай холбогдох хэсэг, гэрийн хаяг зэрэг мэдээллийг нийтэд ил болгожээ. Энэ нь хувь хүний нууц, насанд хүрээгүй хохирогч, өсвөр насны хүүхдийн ирээдүй, нэр төрд сөргөөр нөлөөлөх уршигтай юм.

## **6. Хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэрэгтэй холбоотой тусгай дүн шинжилгээ**

Хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх болон шүүхийн шийдвэрт тавигдах тусгайлсан шаардлага өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд суугаагүй боловч хүүхдийн эрхийг хамгаалах талаарх Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн наад захын шаардлагад дурдагдсан дараах асуудлууд судалгааны явцад анхаарал татлаа.

**Хүснэгт 3. Гэмт хэргийн улмаас харилцан адилгүй хохирол, хор уршиг учирсан байдал**

ХОХИРОГЧ бэлгийн замын халдварт өвчин туссан	ХОХИРОГЧ бэлгийн замын халдварт өвчин тусаагүй
ХОХИРОГЧ эрүүл мэндийн хүнд хохирол учирсан	ХОХИРОГЧ эрүүл мэндийн хүнд хохирол учраагүй
2 болон түүнээс дээш хүүхэд хүчиндсэн	Нэг хүүхэд хүчиндсэн
Удаа дараа хүчиндсэн	Нэг удаа хүчиндсэн

**1. Ялын бодлого:** Хүүхэд худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцэд оруулах нэмэлт Протоколд хүүхдийг биеэ үнэлэх, садар самуунд уруу татах оролдлого болон тэдгээр үйл ажиллагаатай холбоотой ямар нэг хуйвалдааныг эрүүгийн хариуцлагад татах, зохих ял шийтгэл хүлээлгэх, тухайн гэмт хэргийн гэм хор, учруулсан хор уршгийн хэмжээг тогтооход чиглэсэн байдаг. Өнөөгийн практикт хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэх явцад харилцан адилгүй хохирол, хор уршиг бий болсон байхад хохирол, хор уршиг тооцох, үнэлэх нэгдсэн ойлголтгүй, шүүхээс энэ талаар дүгнэлт хийдэггүй байдал нь судалгааны явцад ажиглагдлаа. Ийнхүү харилцан адилгүй хохирол, хор уршиг бий болсон байхад ялгавартай ял оноохгүй байгаа нь шударга ёсны зарчимтай нийцэхгүй байх бөгөөд, дээрх Протоколыг хэрэгжүүлэхэд манай улс оролцогч улсын хувьд идэвх гаргахгүй байна гэж үзэхээр байна (Хүснэгт 3).

**2. Хохирогчийн өмгөөлөл:** Хүүхэд худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцэд оруулах нэмэлт Протоколын 8 дугаар зүйл ба хохирогч хүүхдийн эрхэд «хүүхдэд шүүх хуралдааны явцад зохих туслалцаа үзүүлэх; хүүхдийн эрхийг эн тэргүүнд эрхэмлэх нөхцөлийг оролцогч улсууд хангана» зэргээр хохирогч хүүхэд эрх зүйн болон бусад туслалцаа үйлчилгээ авах эрхийг баталгаажуулсан. Гэвч хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор насанд хүрээгүй хохирогчид зайлшгүй хууль зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалт байхгүй байгаа нь хохирогчид шүүх ажиллагаанд өмгөөлөгчгүй оролцох, хуулиар олгогдсон эрхээ бүрэн эдэлж, хамгаалуулж чадахгүйд хүрч байна. Харин шүүгдэгч заавал

өмгөөлөгчтэй оролцох хуулийн зохицуулалттай байгаа нь хүүхдийн эрхийг хамгаалах, шүүх тэгш эрхийн зарчим дээр шийдвэр гаргахад учир дутагдалтай байгаа юм. Бидний судлан үзсэн хэргүүдийн талаас дээш хувьд нь хохирогч хүүхдүүд, тэдний хууль ёсны төлөөлөгчид өмгөөлөгчгүй шүүх хуралдаанд оролцжээ.

**3. Сэтгэл зүйн хамгаалалт, сэтгэл санааны хохирол:** Хүүхдийн эрхийн конвенцийн 39 дүгээр зүйлд: «Оролцогч улсууд ... хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлага зэргийн хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авна» хэмээн заасны дагуу сэтгэл зүйн хамгаалалт, нөхөн сэргээлтийн үйлчилгээ үзүүлэх үүргийг манай улс хүлээсэн. Гэсэн хэдий ч манай улсад сэтгэл зүйчийн эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлоогүй байгаа нь хохирогч хүүхдүүдийн хувьд сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авахад хүндрэлтэй төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйчтэй харьцах боломжгүй болгож байна.

Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон эрх нь зөрчигдвөл хүн бүр үндэсний шүүхээр зөрчигдсөн эрхээ сэргээн тогтоолгох бүрэн эрхтэй хэмээн зөрчигдсөн эрхээ сэргээх, хохирлоо тогтоолгох эрхийг баталгаажуулсан. Гэвч судалгаа хийх явцад хохирогч хүүхдүүдийн хууль ёсны төлөөлөгчид хохирогчдын сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх талаар иргэний нэхэмжлэл гаргадаггүй, гаргасан ч үндэслэл бүхий байх шаардлага хангадаггүй, эсвэл шүүхээс гаргасан нэхэмжлэлийг иргэний журмаар шийдвэрлүүлэхээр буцаасан байна. Энэ нь сэтгэл санааны буюу эдийн бус хохирол тооцох, үнэлэх аргачлал байхгүйтэй холбоотой гэж үзэж байна. Ерөнхийдөө хохирогчдын сэтгэл санааны хохирлыг арилгахаас илүүтэй гэм буруу, эрүүгийн хариуцлагын асуудалд түлхүү анхаардаг практик манай улсад тогтсон гэж үзэж болохоор байна.

Товч дүгнэхэд, дотоодын хууль тогтоомжид тусгалаа олсон эсэхийг үл харгалзан, Монгол Улсын Үндсэн хуульд харшлахгүй тохиолдолд шүүхээс олон улсын эрх зүйн хэм хэмжээнд

нийцүүлэн шийдвэр гаргах бүрэн боломжтой боловч бидний дүн шинжилгээний явцад энэ талаар шүүхийн шийдвэрт үндэслэл болгосон практик огт байхгүй байна.

## Дүгнэлт

Шүүхийн шийдвэрийн нийтлэг алдаа, зөрчил, хуулийн хэрэгжилтийн байдлыг нэгтгэж дараах ерөнхий дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- 1) Ерөнхийдөө шүүхийн шийдвэрийн удиртгал болон тогтоох хэсэг нь хуульд заасан шаардлагыг хангасан, харин тодорхойлох хэсэгт хууль зүйн шаардлага хангаагүй, болсон үйл явдал, хуулийн хэрэглээ, тэдгээрийн логик уялдаа холбоог бүрэн илэрхийлэхгүй байх явдал түгээмэл байна.
- 2) Шийтгэх тогтоолыг бичихдээ эрүүгийн хуулийг буруу хэрэглэх, хуулийн шаардлагад бүрэн нийцүүлэхгүй байх тохиолдол цөөнгүй байна. Шүүхээс эрүүгийн хуулийг буруу хэрэглэх нь техникийн алдаа мэт харагдаж байх боловч хууль хэрэглээний хувьд томоохон алдаанд тооцогдохоор байна.
- 3) Шүүхийн шийтгэх тогтоолуудад хуулийн нэр томъёоны хувьд алдаатай, шийтгэх тогтоолыг ойлгомжгүй бичих, үг олонтаа давхардуулсан, үг үсгийн болон цэг таслал, найруулгын алдаанууд багагүй байна. Түүнчлэн хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөв нэрлэж хэрэглэхгүй байгааг анхаарах шаардлагатай.
- 4) Шүүхээс хуульд заагаагүй шинжүүдийг шийтгэх тогтоолд тусгасан байгаа нь алдаа гэж үзэж болохоор байна. Тухайлбал, бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэрэг нь «хохилогчийн биеэ хамгаалж чадахгүй байгаа байдлыг далимдуулж» гэх зэрэг Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-д заасан шинжүүдийг заавал агуулах шаардлагагүй байхад шүүхийн шийдвэрт үүнийг тусгасан байна. Түүнчлэн шүүгдэгчийг хууль сануулан байцаах

тухай заалт байхгүй байхад хууль сануулан байцаасан мэдүүлгийг шүүхийн шийдвэрт заасан нь хуульд нийцээгүй байна.

- 5) Шүүхийн шийдвэр нь нотлогдсон гэж үзсэн үйл баримт нь ямар учраас тодорхой нэг үр дагаварт хүргэж байгааг хангалттай тайлбарлахгүй байна. Аливаа үйл баримт нь ямар нэгэн эрх зүйн хэм хэмжээтэй холбогдож, эрх зүйн үр дагаврыг бий болгосон нь шүүхийн тогтоолоос шууд харагдаж байх учиртай. Өөрөөр хэлбэл, үйл баримт болон эрх зүйн үр дагавар нь үндэслэл бүхий тайлбараар холбогдох ёстой байтал үйл баримтыг бүрэн гүйцэд илэрхийлээгүй, ямар эрх зүйн үр дагаварт хүрсэн талаарх тодорхойлолт ойлгомжгүй байгааг дурдах нь зүйтэй.
- 6) Шүүгч шинэ хуулийг сайтар судалж, түүний заалт бүрийг хэлбэрэлтгүй биелүүлэх, хэрэгжүүлэх ёстой. Гэтэл шинээр батлагдсан хуулийн зүйл заалт хэрэгжихгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, шинэ хуулийн дагуу тодорхойлох хэсгийг шүүгдэгчийг (i) гэм буруутайд тооцох, (ii) эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хоёр хэсэгт ялган хуваадаггүй. Хэсэг тус бүрт тусгавал зохих зүйлсийг холилдуулах, хуучин хуулийн дагуу бичих нийтлэг алдаа байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн ЭХХШТХ-ийн 34.1-р зүйлийн 2 дахь хэсэгт «Шүүх гэм буруутай талаар маргасан шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийнхээ үндэслэлийг танилцуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна» гэсэн шинэ хуулийн заалт хэрэгжихгүй, хуучин хуулийн процессоор явж байгаа нь хуулийн хэрэгжилт сул байгааг харуулж байна.
- 7) Дүн шинжилгээ хийсэн тогтоолын талаас дээш хувьд нь гэм буруутайд тооцсон шийтгэх тогтоолд шүүгдэгчийг гэмт буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, шүүх тухайн нотлох баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль ёсны

гэж үзсэн улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн саналын үндэслэл болгосон баримт, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл зэргийг дурдах ёстой байтал энэ талаар огт дурдаагүй байна.

- 8) Нотлох баримтыг дутуу үнэлэх, үнэлэхгүй орхигдуулах тохиолдлууд ажиглагдлаа. Талуудын тайлбар ихэнхдээ зөрүүтэй байдаг бөгөөд хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтын заримыг үнэлэхгүй орхигдуулах, дутуу үнэлснээр «дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авахдаа бусдыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй бол дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй байна» гэсэн ЭХХШтХ-ийн 39.6 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг зөрчсөн байдал ажиглагдаж байна. Иймд аль нотлох баримтыг ач холбогдолтой, алийг нь ач холбогдолгүй гэж үзсэнээ шийдвэрт үндэслэж бичих шаардлагатай байна. Үүнээс гадна нотлох баримтын агуулгыг давхардуулан бичиж энэ үндсэн дээр үйл явдлыг тодорхойлж хууль зүйн дүгнэлт хийдэг дутагдал цөөнгүй байна.
- 9) Шүүхийн шийдвэрийн хууль зүйн дүгнэлт болон хуулийн тайлбарыг ойлгомжгүй, логик зөрчилтэй, эргэлзээ төрүүлэхээр хийж байна.
- 10) Хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийн улмаас (i) үр хөндүүлсэн болон үр хөндүүлээгүй, (ii) уг хэргийн улмаас хохирогч бэлгийн замын халдварт өвчин туссан эсвэл тусаагүй, (iii) хохирогчид эрүүл мэндийн хүнд хохирол учирсан эсвэл учраагүй, (iv) нэг хүүхэд нэг удаа хүчиндэх эсвэл удаа дараа хүчиндэх, (v) хоёр хүүхэд нэг удаа эсвэл удаа дараа хүчиндэх гэх зэрэг хохирлын хувьд ялгаатай, харилцан адилгүй хор уршиг бий болсон байхад ялгамжгүй ял оноож буй нь шударга ёсны зарчимтай үл нийцэж байна.
- 11) ЭХХШтХ-ийн 34.4 дүгээр зүйлд насанд хүрээгүй хохирогч, өсвөр насны хүүхдийн ирээдүй, нэр төртэй шууд хамаарах асуудлыг шийдвэрлэдэг тул хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийн шүүх хуралдааныг хаалттай явуулах



үндэслэлийг тодорхойлж шүүхийн шийдвэрийн зөвхөн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгох боломжийг олгосон. Гэтэл [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) цахим хуудас дээр дээрх хаалттай явуулсан шүүх хуралдааны тогтоолуудыг бүрэн эхээр нь байршуулсан, хохирогч, шүүгдэгч нарын биеийн байцаалттай холбогдох хэсэг, гэрийн хаяг зэрэг мэдээлэл нийтэд ил байгааг анхаарах шаардлагатай байна.

- 12) Саяхан батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар ялын хугацааг багасгасан бөгөөд үүнийг насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс авч үзвэл тус гэмт хэргийн нийгмийн аюул, хор уршигтай харьцуулахад нийцсэн заалт болж чадаагүй, хөнгөрүүлсэн байна гэж хуульч-судлаач бидний зүгээс үзэж байна
- 13) Хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийн шүүх хуралдаанд хүүхдийн эрх, ашгийг төлөөлөн хамгаалах үүрэг бүхий хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид шүүх хуралд идэвхгүй оролцох, өөрөөр хэлбэл хүүхдийн сэтгэл санааны хохирлыг барагдуулах, хохирогч хүүхдийг нийгэмшүүлэх, эрүүл мэндийг нь хамгаалах зэргээр хүүхдийн эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байгааг онцолж байна.
- 14) Манай улсын хуулийн практик (i) хохирогч хүүхдэд учирсан сэтгэл санааны, эд материалын, бие махбодийн хохирол бүрийг үнэлэн тогтоох, (ii) хүүхдийн эрх, сэтгэл санааны хохирлыг барагдуулах, (iii) хохирогчдын нэр төрийг хамгаалж ажиллах, (iv) хохирогч хүүхдэд хууль зүйн, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхэд олон улсын хэмжээнд тогтсон наад захын шаардлагыг хангахгүй, санаачилгатай ажиллахгүй байна.

## Санал, зөвлөмж

### *Нэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрэгжүүлэгчдэд*

- Шинэ хуулиар шийтгэх тогтоол бичиж, боловсруулах, шинэ хуулийг бүрэн хэрэгжүүлэх талаар шүүгч нарт сургалт явуулах;
- Хүүхэд хүчиндсэн тохиолдолд энэ үйлдлийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тодорхойлж байх, мөнгөн хэлбэрээр тооцох, хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийг шийдвэрлэхдээ сэтгэл санааны хохирол болон онгон хальсыг нөхөн төлүүлэх зэргийг иргэний нэхэмжлэлийн хүрээнд заавал хэлэлцдэг байх журам оруулах;
- Хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийн хор уршигт тохирсон ял шийтгэл оногдуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч хүүхдийг дахин сэтгэл зүйн хувьд хохироолгүйгээр сэтгэл санааны тэнцвэрт байдалд оруулах зарчмыг баримтлан хэргийг шийдвэрлэхэд санаачилга гарган ажиллах;
- Шүүх хурлыг тухайн хүүхдийн туулж өнгөрүүлсэн сэтгэл санааны дарамтыг сэдрээхгүйгээр явуулахыг чармайх, тухайлбал хохирогчийн видео бичлэгээр өгсөн мэдүүлгийг шүүх хуралд түлхүү ашиглах.

### *Хоёр. Хууль тогтоогч, шийдвэр гаргагчдад*

- Насанд хүрээгүй хохирогч нь заавал өмгөөлөгчтэй байх асуудлыг хуульд тусгах, хохирогч хүүхдийн эрхийг хамгаалагч өмгөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх, оролцоог дээшлүүлж, хариуцлагыг нь өндөржүүлэхэд анхаарах;
- Хүчингийн гэмт хэргийн хохирогч хүүхдэд учирсан сэтгэл санааны, эд материалын, бие махбодийн хохирол бүрийг үнэлэн тогтоож, ялын хэмжээнд нөлөөлөх нэг үндэслэл болгох, сэтгэл санааны хохирлыг үнэлэх, барагдуулах талаар хуульд тусгах;
- Монгол Улсын нэгдэн орсон хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ конвенцийг хэрэгжүүлэх;

- Насанд хүрээгүй этгээдийн холбогдсон болон насанд хүрээгүй хохирогчтой эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нарыг зөвхөн насанд хүрээгүй этгээдийн хэргийг хянан хэлэлцдэг чиглэлээр дагнан мэргэшүүлэх;
- Эмэгтэй хохирогч хүүхэдтэй харьцах эмэгтэй хуульч, өмгөөлөгч, байцаагч, шүүгч ажиллуулах;
- Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулах явдлыг тухайн хүүхдэд учруулсан хохиролтой уялдуулж ял оноож байх;
- Хохирогч хүүхдийг, ялангуяа хүчингийн гэмт хэргийн хохирогчдыг далд болон далд бус хэлбэрээр буруутгахаас зайлсхийх ёстой ба эдгээрийг нарийвчлан зохицуулсан журам хуульд тусгах;
- Хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээх хөтөлбөр хэрэгжүүлэх, ингэхдээ хүчингийн гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд анхаарал халамж тавих, тэдний хэрэгцээг тусгайлан анхаарах, эргэн нийгэмшихэд нь туслах.

*Гурав. Бусад байгууллагад*

www.shuukh.mn дээр хүүхдийн эсрэг хүчингийн гэмт хэргийн шүүхийн шийдвэрийг нийтлэхгүй байх;

